

2008-2012 ОНЫ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

Анхдугаар хуралдаан

Аймгийн ИТХ-ын Анхдугаар хуралдааныг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 10 дугаар сарын 15-ний өдрийн 228 дугаар тогтоолоор 10 дугаар сарын 31-ний өдөр хуралдуулж Аймаг, сумын ИТХ-ын сонгуулийн дүн, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэн эрхийн тухай сонгуулийн хорооны дарга Н.Дамбаагийн илтгэл болон зохион байгуулалтын асуудал хэлэлцэхээр товлон зарлажээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 10 дугаар сарын 29-ний өдрийн 86 дугаар тогтоолоор Ховд аймгийн Мөст суманд 1952 оны 2 дугаар сарын 28-ны өдөр төрсөн сонгогдсон төлөөлөгчдөөс хамгийн ахмад настан З.Рагчаабазараар анхдугаар хуралдааныг удирдуулахаар шийдвэрлэсэн байна.

Анхдугаар хуралдааныг З.Рагчаабазар нээж үг хэлж хуралдааныг удирдаж анхдугаар хуралдааны дэгийг баталуулсан байна.

Хуралдааны ажлын албаны нарийн бичгийн даргаар аймгийн ИТХ-ын Ажлын албаны ажилтан Б.Сандагсүрэн, У.Цэрэнтогтох, редакцийн комиссоор аймгийн ерөнхий аудитор Ч.Цэрэнчимэд, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн түшмэл Б.Шоовдой, тэмдэглэл хөтлөгчөөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ахлах ажилтан Б.Энхтуяа нар ажилласан байна.

Аймгийн сонгуулийн хорооны дарга Н.Дамба “Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг нөхөн сонгох сонгуулийн дүн, төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай” илтгэлдээ ... Орон нутгийн Хурлыг сонгох 2008 оны сонгуулийг зохион байгуулахаар аймаг, 17 сумын сонгуулийн хороо, 92 хэсгийн хороо байгуулагдаж аймгийн сонгуулийн хороонд 13, сумын сонгуулийн хороонд 119, хэсгийн хороонд 1012 нийт 1114 хүн сонгуулийн хороодод ажилласан байна.

Сонгуульд оролцохоор 5 нам мэдэгдэл, материалаа ирүүлснээс хуулийн дагуу бичиг баримтаа бүрдүүлээгүй ИЗН-ыг бүртгэхээс татгалзаж МАХН, АН, Эх орон нам, ҮШН-уудыг бүртгэж батламж олгосон байна. Мөн бие даан нэр дэвшүүлэхээр 4 хүн бүртгүүлж дэмжигч-сонгогчийн бүртгэлийг авсан боловч 2 нь хуулийн хугацаандаа материалаа ирүүлээгүй, 1 нь гарын үсэг зуруулахдаа сонгуулийн хууль зөрчсөн гэж үзэж нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзаж, 1 хүнийг бие даан нэр дэвшигчээр бүртгэжээ.

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох 31 мандаттай 20 тойрог, сумдын ИТХ-ыг сонгох 365 мандаттай, 107 тойрог байгуулагдаж аймгийн ИТХ-ын төлөө 86 нэр дэвшигч, сумын ИТХ-ын 365 мандатын төлөө 762 хүн нэр дэвшсэн байна. Үүнд аймгийн ИТХ-д МАХН-аас 31, АН-аас 30, Эх орон намаас 6, ҮШН-аас 13, бие даан 1, хүний нэр дэвшсэн бол сумдын ИТХ-д МАХН-аас 364, АН-аас 362, Эх орон намаас 6, ҮШН-аас 14, бие даан 16 хүн нэр дэвшсэн байна.

Аймаг, сумын ИТХ-ын 127, сонгуулийн 92 хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтад нийт 42879 сонгогч бүртгэгдсэнээс 31678 сонгогч буюу 73.88 хувь нь санал хураалтад оролцсон байна.

Сонгуулийн үр дүнгээр МАХН-аас 21, АН-аас 9, бие даагч 1 хүн сонгогдсоноос 26 эрэгтэй, 5 эмэгтэй, насны хувьд хамгийн залуу нь 34, хамгийн ахмад нь 53, боловсролын хувьд нябо, эдийн засагч 6, хүний их эмч 4, инженер, малын их эмч тус бүр 3, эрх зүйч 2, эм зүйч 1, аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр дахин сонгогдсон төлөөлөгч 6 байгааг тэмдэглэсэн байна.

Хуралдааны 2008 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 1/03-33 дугаар тогтоолуудаар аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрсөн байна.

Аймгийн ИТХ-ыг сонгох сонгуулийн 20 тойрогт аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгогдсон төлөөлөгчийн нэрс

№	Тойрог-ийн дугаар	Сумын нэр	Манда-тын тоо	Сонгогдсон төлөөлөгчийн овог, нэр	Намын харъяа-лал
1.	1	Алтай	1	Төмөрийн Шинэбаяр	АН
2.	2	Булган	3	Содноон Баярсайхан	АН
3.		Булган		Батмэндийн Мөнхбаяр	АН
4.		Булган		Баастын Гансүх	АН
5.	3	Буянт	1	Тэрбишийн Баярсайхан	МАХН
6.	4	Дарви	1	Доржнямын Түмэндэмбэрэл	МАХН
7.	5	Дөргөн	1	Гэндэнжавын Нямдаваа	МАХН
8.	6	Дуут	1	Аюурзанын Батмөнх	МАХН
9.	7	Зэрэг	1	Жамсрангийн Цэнд-Аюуш	МАХН
10.	8	Манхан	2	Гомбоо Гончигсүрэн	МАХН
11.		Манхан		Салзадын Чулуунжав	Бие даагч
12.	9	Мөст	1	Загдын Рагчаабазар	МАХН
13.	10	Мөнххайрхан	1	Чойжилын Болд	МАХН
14.	11	Мянгад	1	Жамсрангийн Цэен-ойдов	АН
15.	12	Үенч	1	Пүрэвийн Эрвээхэй	МАХН
16.	13	Ховд	1	Долдойн Мурат	АН
17.	14	Цэцэг	1	Довчингийн Цагаанцоож	МАХН
18.	15	Чандмань	1	Дамдиндоржийн Цэвээнравдан	АН
19.	16	Эрдэнэбүрэн	1	Цэрэндоржийн Отгонбаатар	МАХН
20.	17	Жаргалант	3	Халтайн Батболд	МАХН
21.				Цогтоогийн Ганчимэг	МАХН
22.				Дагийгийн Энхсайхан	МАХН
23.	18	Жаргалант	3	Уртнасангийн Батзаяа	МАХН
24.				Ёндонгийн Адилбиш	МАХН
25.				Дагвын Жүгдэрбарам	МАХН
26.	19	Жаргалант	3	Дамбийгийн Ширэндэв	МАХН
				Очирын Ширэндэв	МАХН

				Агаажавын Хишигсүрэн	МАХН
27.	20	Жаргалант	3	Жанчивдоржийн Даваабал	МАХН
28.				Юрагийн Азамат	АН
29.				Баасанхүүгийн Батмөнх	АН

Төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрсөнөөр аймгийн МАХН-ын хорооноос аймгийн ИТХ-д 23 төлөөлөгч бүхий намын бүлэг байгуулж, даргаар нь Г.Гончигсүрэн, дэд даргаар П.Эрвээхэй нарыг сонгосон тухай, АН-аас 9 гишүүн бүхий АН-ын бүлэг байгуулж ахлагчаар нь Д.Цэвээнравдан, дэд ахлагчаар Т.Шинэбаяр нарыг сонгосон тухай бүрэлдхүүнийг хуралдаанд танилцуулсан байна.

Хуралдаанд МАХН-ын бүлгийн ахлагч Г.Гончигсүрэн аймгийн ИТХ-ын даргаар төлөөлөгч О.Ширэндэвийн нэрийг дэвшүүлж Ардчилсан нам нэр дэвшүүлээгүй О.Ширэндэвийг дэмжиж байгааг намын бүлгийн ахлагч Д.Цэвээнравдан танилцуулж, төлөөлөгчдөөс өөр хүний нэр дэвшүүлээгүй тул төлөөлөгчдийн 100,0 хувийн саналаар аймгийн ИТХ-ын даргаар О.Ширэндэв сонгогдсон байна.

Дараа нь Тэргүүлэгчдийн тоог 9, 11 байхаар төлөөлөгчдөөс санал гарч олонхийн саналаар 9 тэргүүлэгчтэй байхаар тогтож, МАХН, АН-аас сонгогдох харьцаа 6:3 байхаар олонхийн санал авч, АН-ын бүлэг хурлаас 1 цагийн завсарлага авсан байна.

Хуралдаан үргэлжилж МАХН-ын бүлгээс аймгийн ИТХ-ын тэргүүлэгчээр Хурлын даргыг оролцуулаад Х.Батболд, У.Батзаяа, А.Хишигсүрэн, Ч.Болд, Г.Гончигсүрэн, АН-ын бүлгээс Ю.Азамат, Т.Шинэбаяр, Д.Цэвээнравдан нарын нэрсийг дэвшүүлж төлөөлөгчдөөс Д.Энхсайханы нэрийг тус тус дэвшүүлж “Тооллогын комисс байгуулах тухай” 1/35 дугаар тогтоолоор тооллогын комиссын даргаар төлөөлөгч С.Чулуунжав, гишүүдэд төлөөлөгч Ж.Цэндаюуш, Б.Батмөнх нарыг сонгосон байна. Санал хураалтанд 6:3-ийн харьцаагаар МАХН-аас болон төлөөлөгчдөөс нэр дэвшсэн 6 хүний төлөө санал хураалт явуулж санал хураалтанд 30 төлөөлөгч оролцсоноос хамгийн олон санал авсан У.Батзаяа 30, Х.Батболд 28, Ч.Болд 28, Г.Гончигсүрэн 22, Д.Энхсайхан 21 санал тус тус авсанаар АН-ын төлөөлөлөөр Д.Цэвээнравдан, Ю.Азамат, Т.Шинэбаяр нар намын саналаар орж хуралдааны 1/36 дугаар тогтоолоор Хурлын даргыг оролцуулан дээрхи төлөөлөгчид аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчээр сонгогдсон байна.

Хуралдааны 1/36 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ыг нийгмийн бодлогын хороо, эдийн засгийн хороо, хүнс, ХАА, байгаль орчны хороо, үйлдвэрлэл, дэд бүтэц, хот байгуулалтын хороотой ажиллахаар баталжээ.

Хуралдаан хэлэлцэх асуудлын дараалалын дагуу аймгийн Засаг даргад МАХН-ын бүлгээс төлөөлөгч Г.Нямдаваагийн нэрийг дэвшүүлж АН-ын бүлгээс дэмжиж байгаагаа илэрхийлсэн байна.

Төлөөлөгч Д.Жүгдэрбарам төлөөлөгч У.Батзаяагийн нэрийг дэвшүүлсэнээр нэр дэвшүүлэх асуудлыг тасалж төлөөлөгчдөөс нэр дэвшигчдээс асууж танилцсаны дараа МАХН-аас 20 минутын завсарлага авсан байна. Тус намын завсарлага дууссанаар 2 нэр дэвшигчид үг хэлж санал хураалтыг нууцаар явуулж санал хураалтанд оролцсон 30 төлөөлөгчийн 53,4 хувийн саналаар төлөөлөгч У.Батзаяаг аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэн Ерөнхий сайдад өргөн мэдүүлэх тухай 1/38 дугаар тогтоолыг баталсанаар хурал өндөрлөсөн байна.

Аймгийн ИТХ-ын анхдугаар хуралдаанд нийт 31 төлөөлөгч бүрэн оролцож урилгаар 10 хүн оролцсоноос төсвийн байгууллагын ажилтан 5, иргэд 5 оролцож хуралдаанд 12 хүн үг хэлж, нийт 4 асуудал хэлэлцэн 38 тогтоол баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2 дугаар хуралдаан

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 11 дугаар сарын 05-ний өдрийн 245 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын 2 дугаар хуралдааныг 2008 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хуралдуулж Ховд аймгийн 2008 оны төсвийн тодотголын тухай аймгийн Засаг даргын илтгэл хэлэлцүүлэхээр зарласан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 11 дугаар сарын 17-ны өдрийн 247 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын 2 дугаар хуралдааны хэлэлцэх асуудлын дараалалд “Зохион байгуулалтын асуудал”-ыг хэлэлцэхээр нэмэлт оруулсан байна.

Хуралдаан “Хуралдааны дэг батлах” тухай 2/01 тогтоолоор аймгийн ИТХ-ын хуралдааны үндсэн зарчим, хуралдаанаар хэлэлцэх асуудал, хуралдаанд асуудал оруулах субъектүүд, хуралдаанд бэлтгэх, хуралдаан хуралдах /дэд бүлэг хуралдааны дарга нь, хурлын хороо нь, Төлөөлөгч нь, аймгийн ИТХ дахь Намын бүлэг түүний үйл ажиллагаа, Хуралдаанд урилгаар оролцогсод нь, Тооллогын комисс нь/, хуралдааны шийдвэрийг ёсчлох, нийтлэх, мэдээлэх, Хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг ашиглах тухай 7 бүлэг зохицуулалт бүхий хуралдааны дэгийг сонгуулийн эрхийн хугацаанд мөрдөж байхаар баталсан байна.

Хуралдааны ажлын албаны нарийн бичгийн даргаар У.Цэрэнтогтох аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны ажилтан, А.Оюундэлгэр Засаг даргын Тамгын газрын Санхүү, эдийн засаг бодлого зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн, М.Отгонхишиг Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийн мэргэжилтэн, редакцийн комиссоор Ч.Цэрэнчимэд аймгийн Ерөнхий аудитор, Б.Шоовдой аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн түшмэл, тэмдэглэл хөтлөгчөөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны ажилтан У.Сандагсүрэн нар ажилласан байна.

“Аймгийн 2008 оны төсвийн нэмэлт өөрчлөлтийн тухай” аймгийн Засаг дарга Г.Нямдаваа илтгэлдээ ... Монгол улсын Их Хурлаас улсын 2008 оны төсвийн тухай хуулинд өөрчлөлт оруулсанаар аймгийн төсөвт өөрчлөлт орж байгааг дурдаад эхний 10 сарын

байдлаар орон нутгийн төсөвт 1,7 тэрбум төгрөгийн орлого орж төлөвлөгөө 11,2 хувиар, татварын орлого 0,7 тэрбум төгрөг орж төлөвлөгөө 27,0 хувиар тасарч, мал бүхий иргэний орлогын албан татвар 33,1 сая төгрөгөөр, лицензийн төлбөр 324,2 сая төгрөгөөр тус тус тасарч байгаа нь нөлөөлсөнийг тэмдэглэжээ. Улсын төсөвт 1,3 тэрбум төгрөг орж төлөвлөгөө 1,1 хувиар тасарч орон нутгийн урсгал зарлага 3,7 тэрбум төгрөг, орон нутгийн улсын төсөвт байгууллагуудын зарлага 15,2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Эхний 10 сарын байдлаар орон нутгийн хөрөнгө оруулалтаар 972,4 сая төгрөг, улсын төсөв болон бусад хөрөнгийн эх үүсвэрээр 2,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгджээ,

Аймгийн 2008 оны төсөвт лицензийн орлогыг 156,7 сая төгрөгөөр бууруулан замын сангийн хөрөнгө оруулалтаас хасах, хүн амын орлогын албан татварыг 82,1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн орон нутгийн нийт зарлагыг 232,6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, улсын төсөвт байгууллагуудын зарлагыг 22,7 сая төгрөгөөр бууруулахаар тооцсоныг илтгэж хуралдаанд оруулсан байна.

Хуралдаанаас “Орон нутгийн төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 03 дугаар тогтоолоор нийт орлогын доод хязгаарыг 95,2 сая төгрөгөөр нэмэгдүүлж зарлагыг 356,9 сая төгрөгөөр хорогдуулж, “Төсвийн өөрчлөлтийг батлах тухай” 04 тогтоолоор эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Засаг даргатай 2008 онд нийлүүлэх бүтээгдхүүний санхүүжилтийг 22,6 сая төгрөгөөр хорогдуулсан тогтоолыг тус тус баталсан байна.

Хуралдаан “Хорооны бүрэлдхүүнийг батлах тухай” 2/03 дугаар тогтоолоор нийгмийн бодлогын хороог Т.Шинэбаяр ахлагчтай 12 гишүүнтэй, нутгийн удирдлага, хууль зүй, хүний эрхийн хороог Г.Гончигсүрэн ахлагчтай 9 гишүүнтэй, эдийн засгийн хороог Д.Цэвээнравдан ахлагчтай 15 гишүүнтэй, Хүнс, ХАА, байгаль орчны хороог Х.Батболд ахлагчтай 10 гишүүнтэй, үйлдвэрлэл, дэд бүтэц, хот байгуулалтын хороог Д.Энхсайхан ахлагчтай 9 гишүүнтэйгээр байгуулсан байна.

Анхдугаар хуралдаанаас аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэн Ерөнхий сайдад мэдүүлсэн У.Батзаяаг Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр томилохоос татгалзсан тул дахин нэр дэвшүүлэх ажиллагааг зохион байгуулж олонхийн бүлэг болох МАХН-ын бүлгээс төлөөлөгч Г.Нямдаваагийн нэрийг дэвшүүлсэн байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан АН-ын бүлэг хуралдаанаас завсарлага авч аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэхгүй гэж шийдвэрлэсэнээ мэдэгдсэн байна. Төлөөлөгчдөөс У.Батзаяа аймгийн Засаг даргад өмнө Засаг даргаар ажиллаж байсан Д.Галсандондогийн нэрийг дэвшүүлсэн байна. Үүнтэй уялдан МАХН-ын бүлгээс хуралдаанаас 2 цагийн завсарлага авсан боловч асуудлаа шийдвэрлэж чадаагүй тул маргааш өдрийн 13,00 цаг хүртэл түр завсарлуулах санал тавьсанаар хуралдаан завсарласан байна.

Маргааш өдөр нь хуралдаан үргэлжилж хуралдааны 2/08 тогтоолоор Т.Баярсайхан даргатай Б.Батмөнх, Ц.Ганчимэг гишүүнтэй тооллогын комисс байгуулж санал хурааснаар аймгийн ИТХ-ын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн 68,96 хувийн санал авсан Г.Нямдавааг 2/07 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргад томилуулахаар Ерөнхий сайдад өргөн мэдүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 3 дугаар хуралдаан

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 251 дүгээр тогтоолоор аймгийн ИТХ-ын 3 дугаар хуралдааныг 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдөр хуралдуулж

1. Аймгийн ИТХ-ын 2008-2012 оны үндсэн чиглэлийн тухай илтгэл,
2. Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тухай илтгэл
3. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2009 оны төсвийн төсөл, 2010-2012 оны төсвийн төсөөлөлийн тухай илтгэл
4. Аймгийн 2008 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, орон нутгийн 2009 оны төсвийн төсөлд болон төсвийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар өгөх саналын тухай илтгэл
5. Иргэнд газар өмчлүүлэх болон газар зохион байгуулалтын 2009 оны төлөвлөгөөний тухай илтгэл
6. Зохион байгуулалтын асуудал /Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн бүрэлдхүүнд өөрчлөлт оруулах тухай/ илтгэлүүдийг хэлэлцүүлэхээр зарласан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны 261 дүгээр тогтоолоор хэлэлцэх илтгэлүүдээс өмнөх баталсан илтгэлийн “Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр” гэсний дараа “Аймгийн эдийн засаг нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл” гэж нэмж өөрчлөн найруулсан байна.

Хуралдаан аймгийн ИТХ-ын 2008 оны 2 дугаар хуралдаанаас баталсан дэгийн заалтыг мөрдөхөөр тогтож хуралдааны ажлын албаны нарийн бичгийн даргаар аймгийн ИТХ-ын Ажлын албаны ажилтан Б.Сандагсүрэн, У.Цэрэнтогтох, Аудитын газрын ахлах шинжээч Б.Түмээ, Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн А.Оюунцэцэг, редакцийн комиссоор аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн ажилтан Б.Шоовдой, аймгийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийн ажилтан М.Отгоншиг, тэмдэглэл хөтлөгчөөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны ахлах ажилтан Б.Энхтуяа нарыг ажиллауулахаар баталсан байна.

Аймгийн ИТХ-ын дарга О.Ширэндэв илтгэлдээ ... бүх шатны хурлын байгууллагуудыг үйл ажиллагаандаа олон ургальч үзэл, зөвшилцөлийн зарчмыг голлон анхаарч цөөнхийн саналыг хүндэтгэх зарчмаар ардчилал, шударга ёсыг хөгжүүлэн Хурлын байгууллага, иргэд

олон түмний холбоог бэхжүүлэхэд онцгойлон анхаарч хурлын үйл ажиллагааны уламжлал, шинэчлэлийг хослуулан аймаг, сумын нутгийн удирдлагын үйл ажиллагааны эрх мэдлийн ялгаа, зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц, бүтцийн хувьд энгийн, улс төрөөс ангид, өндөр чадавхи, бодиттой үйл ажиллагааг эрхэмлэн НӨУЁ-ыг нутгийн захиргааны удирдлагатай чадварлаг хослох үндсэн зарчмыг удирдлага болгон ажиллах, эдийн засаг, нийгмийн салбарыг өргөтгөн хөгжүүлж ДНБ-ний жилийн дундаж өсөлт 12,5 хувиас доошгүй байлгасанаар нэг хүнд ногдох ДНБ-нийг 2009 онд 1800, 2012 онд 4000 ам долларт хүргэх, баруун бүсийн босоо болон хэвтээ тэнхлэгийн замыг барих, бүх сумдын төвийг баруун бүсийн эрчим хүчний системд 2009 онд холбох, дулааны 2 дахь эх үүсвэрийг барих, холбоо мэдээлэлийн шинэ технологийг нэвтрүүлэх, хот хоорондын ачаа болон зорчигч тээврийг нэгдсэн бодлоготой хөгжүүлэх, ХАА, газар тариалангийн хөгжлийг эрчимжүүлэх, нийгмийн салбарын асуудлыг тухай бүр шийдвэрлэсэнээр 2012 онд нэг хүнд ногдох ДНБ-ийг 4000 ам долларт хүргэж хөдөлмөр эрхлэлтийн түвшинг 67,0 хувь, сургуульд хамааралтыг 98,0 хувь, хүн амын дундаж наслалтыг 66-д, нийт бүтээгдхүүнд ногдох аж үйлдвэрийн бүтээгдхүүний эзлэх хувийг 3 дахин нэмэгдүүлэх, мянган хүнд ногдох халдварт өвчний гаралтыг 20,0 хувь, ядуурлын түвшинг 25,0 хувь бууруулах зорилтыг дэвшүүлж байгааг илтгэсэн байна.

Илтгэлийг аймгийн ИТХ-ын нутгийн удирдлага, хууль зүй, хүний эрхийн хорооны хурлаар хэлэлцэж хурлын бүх шатны байгууллагыг төлөвшүүлэх, хуралдааны үйл ажиллагааг тогтмолжуулах, Тэргүүлэгчдийн ажлыг эрчимжүүлэх, Төлөөлөгчдийг тойрогт ажиллах нөхцөл боломжоор хангах, ирэх 4 жилд дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлэх, Ховд аймгийн бүсийн хөгжлийн ойрын ирээдүйн хөтөлбөр боловсруулах, нийгмийн салбарын хөгжлийг түргэтгэх, Буянт гол болон бусад гол горхийн ариун цэврийн бүс тогтоож мөрдүүлэх, Буянт, Ховд голын сав газрын зөвлөлийг байгуулах, байгаль орчноо хамгаалах, гэр хороололыг инженерийн шугамтай холбох, хүнсний аюулгүй байдлыг хангах саналыг хуралдаанд оруулсан байна.

Хуралдаан 3/02 дугаар тогтоолоор “Аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг баталсан байна.

Аймгийн Засаг дарга Г.Нямдаваа “Аймгийн Засаг даргын 2008-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, 2009 оны үндсэн чиглэлийн тухай” итгэлдээ ... Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутгийн иргэдийн хурлын сонгуулийн үеэр улс төрийн намуудын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр, манай аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүд, аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, сум албан байгууллагын ажилтанууд, аймгийн ахмадын байгууллага эмэгтэйчүүд, бизнес эрхлэгчид төрийн бус байгууллагуудын төлөөлөл, иргэдийн саналд тулгуурлан боловсруулан “Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлж-эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэн иргэний амьдралын баталгааг хангая” уриатайгаар 4 бүлэг 48 дэд хэсэг 256 асуудал бүхий хөтөлбөрийг хуралдаанд өргөн барьж

байгааг илтгэсэн байна. Мөн 2009 онд Мөст суманд 320 хүүхдийн сургууль, Жаргалант суманд 320 хүүхдийн бага сургуулийн ажлыг эхлүүлэх, Зэрэг, Алтай, Эрдэнэбүрэн, Чандмань, Мөнххайрхан сумын соёлын төвийн барилга, Дарви сумын цэцэрлэгийн барилгыг ашиглалтанд оруулж, Жаргалант сумын 3 дугаар сургууль, Манхан сумын сургуулийн өргөтгөл, Дуут сумын сургуулийн дотуур байранд их засвар хийх, аймгийн төвийн сургуулиудад англи хэлний лаборатори, БСГ-ыг өндөр хурдын интернетед холбох, Дөргөний УЦС-ыг бүрэн хүчин чадлаар нь ашиглах, 2009 онд ДНБ-нийг 2000 ам долларт хүргэх, 1600-аас доошгүй ажлын байр бий болгох тухай зорилтыг дэвшүүлжээ.

Хуралдааны 3/03 дугаар тогтоолоор “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан байна.

“Аймгийн 2008 оны төсвийн гүйцэтгэлийн урьдчилсан дүн, 2009 оны төсвийн төслийн тухай” аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү эдийн засаг бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Д.Алтангэрэл илтгэлдээ ...аймгийн төсөвт хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 4,6 тэрбум төгрөг оруулж төлөвлөгөө 0,4 хувиар давж орон нутгийн зарлагаар 3,8 тэрбум төгрөг, улсын төсвийн байгууллагуудын зарлага 19,3 тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүлсэн байна.

2008 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 0,8 тэрбум, улсын төсөв болон бусад хөрөнгө оруулалтаар 3,0 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжүүлжээ.

2009 онд орон нутгийн төсөвт 4,9 тэрбум төгрөгийн орлого үүнээс татварын орлогоор 2,5 тэрбум төгрөг, нийт зардлыг 26,6 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтыг 13,9 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн тухай илтгэсэн байна.

Хуралдаан “Орон нутгийн 2009 оны төсөв батлах тухай” 3/05 дугаар тогтоолоор аймгийн 2009 оны төсвийн орлогын доод хязгаарыг 2,6 тэрбум төгрөгөөр үүнээс татварын орлогыг 2,4 тэрбум төгрөгөөр, нийт зарлагыг 4,9 тэрбум төгрөгөөр, сумдын төсвийн орлогын доод хязгаарыг 1,4 тэрбум төгрөгөөр, санхүүгийн дэмжлэгийг 1,1 тэрбум төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 26,1 сая төгрөгөөр баталжээ. Мөн 3/06 дугаар тогтоолоор эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Засаг даргатай 2010 онд нийлүүлэх бүтээгдхүүний санхүүжилтийн 19,5 тэрбум төгрөг байхаар сайшаан дэмжсэн байна.

Аймгийн Ерөнхий аудитор Ч.Цэрэнчимэд “Аймгийн 2008 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, орон нутгийн 2009 оны төсвийн төсөлд болон төсвийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар өгөх саналын тухай” илтгэлдээ 161 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулсанаар 54,6 хувь буюу 88 тайлан “Зөрчилгүй” стандарт, 41,6 хувь буюу 67 тайлан “Хязгаарлалттай”, 2,5 хувь буюу 4 тайлан нь “Сөрөг”, 1,3 хувь буюу 2 тайлан нь “Татгалзсан” санал дүгнэлт өгсөн байна. Санхүүгийн тайлангийн аудитад хамаарагдсан 161 байгууллагын дүнгээр 712,7 сая төгрөгийн алдаа илэрүүлсэнээс 14,4 сая төгрөгийн өр төлбөр, 60,9 сая төгрөгийн бараа материал, мөнгөн хөрөнгө, авлага,

157,2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 34,4 сая төгрөгийн орлого, 110,6 сая төгрөгийн зарлага, 60,9 сая төгрөгийн өмчийн дансдын гүйлгээг, илүү буюу дутуу дүнгээр илэрхийлсэнээс тайлангийн үеийн үр дүн 50,6 сая төгрөгөөр илүү, 56,4 сая төгрөгөөр дутуу тооцогдсон байна.

Тус онд 8 сум, 27 төсөвт байгууллага, төрийн 9, хувийн 4 аж ахуйн нэгж, 2 төслийн байгууллагад гүйцэтгэлийн аудит хийж 383,6 сая төгрөгийн зөрчил төлбөр илрүүлсэнээс 60,6 сая төгрөг нь төлбөр, 323,0 сая төгрөг нь зөрчил байсаныг тайландаа дурдаад 2010 онд орон нутгийн төсвийн орлогыг 35,0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн үр ашиг, арвилан хэмнэлтийг 176,0 сая төгрөгөөр сайжруулах бололцоотой байна гэсэн санал дүгнэлтийг оруулсан байна.

Хуралдааны “Тайланд үнэлэлт өгч санал дэмжих тухай” 3/07 дугаар тогтоолоор “Аймгийн ИТХ-ын эдийн засгийн хорооны дүгнэлт, төлөөлөгчдийн саналыг үндэслэн аймгийн Аудитын газрыг 2009 онд хууль эрх зүйн хүрээнд ажил хэргээ “Хангалттай сайн биелүүлсэн” гэж дүгнэж орлогыг 25,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, зардлын үр ашгийг 183,8 сая төгрөгөөр сайжруулсаныг дэмжсэн байна.

“Аймгийн газар зохион байгуулалтын талаар 2008 онд хэрэгжүүлсэн ажил, иргэдэд 2009 онд өмчлүүлж эзэмшүүлэх газрын тухай” аймгийн Газрын албаны дарга О.Батсайхан илтгэлдээ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулинд өөрчлөлт оруулсанаар иргэн бүр гэр бүлийн зориулалтаар үнэ төлбөргүйгээр нэг удаа газар өмчилж авах эрхтэй болсон бөгөөд гэр бүлийн зориулалтаар 6586 иргэн 900 га газрыг, 1 иргэн 4 га газрыг газар тариалангийн зориулалтаар давуу эрхээр өмчилж авсан байна. Тайлангийн жилд 2 газрын дуудлагын худалдааг зохион байгуулж 83,5 сая төгрөг, газрын төлбөрөөр 29,5 сая төгрөг тус тус оруулж ажиллажээ.

2008 онд иргэд ААН-ээс 2299 өргөдөл гомдол хүлээн авч 2211 иргэнд Засаг даргын захирамж гаргуулан 4 иргэний асуудлыг шүүхээр шийдвэрлүүлсэн байна.

2009 онд иргэнд гэр бүлийн хэрэгцээнд 140,1 га, иргэн, ААН-д үйлдвэрлэл үйлчилгээ, бусад зориулалтаар дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулалтаар 26,8 га, хувийн эдлэн газартай орон сууцны зориулалтаар 40,3 га газрыг эзэмшүүлэх, өмчлүүлэх санал оруулсан байна.

Тус илтгэлтэй холбогдуулан үйлдвэрлэл, дэд бүтэц, хот байгуулалтын хорооноос аймгийн төвд газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу зохион байгуулалт хийх, газрын зөрчил бүхий газрыг цэгцлэх, зарим газрыг төлөвлөлтөөс хасах зэрэг саналыг хуралдаанд оруулжээ.

Хуралдаан илтгэлийг хэлэлцээд 3/08 дугаар тогтоолоор газар зохион байгуулалтын 2009 оны төлөвлөгөөнд иргэнд өмчлүүлэх газрыг 157,6 га, үйлдвэр, үйлчилгээ орон сууцны зориулалтаар эзэмшүүлэх газрыг 18,155 га, гэрээгээр эзэмшүүлэх авто гражны газрыг 0,072 га, газрыг элэгдэл, эвдрэл, доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх газар 235,46 га, гэр бүлийн

зориулалтаар эзэмшүүлэх 10,0 га, газар тариалангийн зориулалтаар иргэн аж ахуйн нэгжид өмчлүүлэх газрыг 110 га, хууль бус газар эзэмшилтийн талаар авах арга хэмжээний газрыг 0,884 га байхаар баталжээ.

Аймгийн ИТХ дахь АН-ын бүлгээс аймгийн ИТХ-ын дарга О.Ширэндэвт итгэл үзүүлэх эсэх талаар санал хураалт явуулах мэдэгдэл хийсэнээр тооллогын комиссыг 3 хүний бүрэлдхүүнтэй байгуулж нууц санал хураалтаар санал хураахад эхний ээлжинд тэнцэж дахин санал хураахад төлөөлөгчдийн 55,5 хувь нь итгэл үзүүлэнэ гэснийг үндэслэн хуралдааны 3/10 дугаар тогтоолоор О.Ширэндэвийг аймгийн ИТХ-ын даргаар хэвээр нь ажиллуулахаар баталжээ.

Аймгийн ИТХ-ын 3 дугаар хуралдаанд 31 төлөөлөгчийн 27 буюу 87,0 хувь нь оролцож урилгаар 120 хүн оролцсоноос төсвийн байгууллагын ажилтан 110, иргэд 10 хүн оролцож хуралдаанд 23 хүн үг хэлж, нийт 6 асуудал хэлэлцэн 10 тогтоол баталсан байна.

Ээлжит бус хуралдаан

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 28 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын ээлжит бус хуралдааныг 2009 оны 2 дугаар сарын 19-ний өдөр Ховд хотод хуралдуулж “Аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан төлөөлөгчдийн тухай” хэлэлцэхээр товлон зарласан байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 38 дугаар тогтоолоор тогтоосон хугацааг 2009 оны 3 дугаар сарын 02-ний өдөр гэж өөрчилсөн байна.

Хуралдаан 2008 оны 2 дугаар хуралдаанаар баталсан дэгээр хуралдаж нарийн бичгийн даргаар У.Цэрэнтогтох аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны ажилтан, Ч.Сүрэнжав аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн, З.Өмүртэй Стратегийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн мэргэжилтэн, редакцийн комиссоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны ахлах ажилтан Б.Энхтуяа, тэмдэглэл хөтлөгчөөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны ажилтан Б.Сандагсүрэн нар ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох 2 дугаар тойргоос сонгогдсон Б.Гансүх, 17 дугаар тойргоос сонгогдсон Ц.Ганчимэг, 18 дугаар тойргоос сонгогдсон У.Батзаяа нар төрийн албанд ажиллахаар төлөөлөгчөөс чөлөөлөгдөхөөр хүсэлтээ гаргасан байна.

Хуралдаанд аймгийн ИТХ дахь АН-ын бүлгээс Төрийн албаны хуулийн хэрэгжилт хэрхэн хангагдаж байгааг шалгаж үр дүнг ИТХ-ын хуралдаанд танилцуулах зорилгоор АН-ын бүлгээс ажлын хэсэг томилон ажиллуулахаар болсон тул шалгалтын дүнг хуралдаанд танилцуулах хүртэл хугацаанд хуралдааныг нээлттэй завсарлуулахыг санал болгосон байна. Иймд аймгийн ИТХ-ын дарга О.Ширэндэв АН-ын бүлгийн ахлагч Д.Цэвээнравдан, гишүүн Ю.Азамат нартай уулзалт хийж, МАХН-ын бүлгийн ахлагч Г.Гончигсүрэн, аймгийн ИТХ-ын

Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Ч.Багдал нар оролцсон бөгөөд ИТХ-ын дарга хуралдааныг дэгийн дагуу үргэлжлүүлэхийг санал болгосон байна.

Хуралдаан нэлээн удаан хугацаанд завсарласаны эцэст хурал эхэлж хуралдаанд оролцсон төлөөлөгчид асуулт асууж, үг хэлж хуралдааны 02 дугаар тогтоолоор Б.Гансүхийг 92,8 хувийн саналаар, 03 дугаар тогтоолоор Ц.Ганчимэгийг 89,2 хувийн саналаар, 04 дүгээр тогтоолоор У.Батзаяаг 75,8 хувийн саналаар тус тус аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөс чөлөөлсөн байна.

Хуралдааны “Тэргүүлэгч сонгох тухай” 05 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчээр ээлжит бус хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн 100,0 хувийн саналаар Т.Баярсайханыг сонгосон байна.

Аймгийн ИТХ-ын ээлжит бус хуралдаанд 31 төлөөлөгчийн бүрэн оролцож урилгаар 27 хүн оролцсоноос төсвийн байгууллагын ажилтан 24, иргэд 3 байгаа ба хуралдаанд 13 хүн үг хэлж, нийт 1 асуудал хэлэлцэн 5 тогтоол баталсан байна.

Ээлжит бус хуралдаан

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 03 дугаар сарын 12-ний өдрийн 61 дүгээр тогтоолоор аймгийн ИТХ-ын ээлжит бус хуралдааныг 2009 оны 3 дугаар сарын 27-ний өдөр Ховд хотод хуралдуулж “Аймгийн санхүү эдийн засгийн өнөөгийн байдал, түүнд хийх дүгнэлт, хүндрэлийг даван туулах үйл ажиллагааны бодлогын тухай” хэлэлцэхээр товлон зарласан байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 3 дугаар сарын 23-ний өдрийн 67 дугаар тогтоолоор аймгийн 2009 оны төсвийн тодотголын тухай илтгэлийг хэлэлцүүлэх, мөн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 3 дугаар сарын 23-ний өдрийн 67 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Хуралдаан 2008 оны 2 дугаар хуралдаанаар баталсан дэгээр хуралдаж нарийн бичгийн даргаар У.Цэрэнтогтох аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны ажилтан, А.Оюундэлгэр, О.Буяндэлгэр аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн, редакцийн комиссоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны ахлах ажилтан Б.Энхтуяа, Ч.Цэрэнчимэд аймгийн Ерөнхий аудитор, тэмдэглэл хөтлөгчөөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны ажилтан Б.Сандагсүрэн нар ажилласан байна.

Хуралдаанаас гарах тогтоол шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийн даргаар аймгийн Засаг дарга Г.Нямдаваа, нарийн бичгийн даргаар аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Багдал болон 12 хүний бүрэлдхүүнтэй байгуулжээ.

Аймгийн Засаг дарга Г.Нямдаваа “Аймгийн санхүү эдийн засгийн өнөөгийн байдал, түүнд хийх дүгнэлт, хүндрэлийг даван туулах үйл ажиллагааны бодлогын тухай” итгэлдээ ... Тус асуудлыг ирэх 6 сард хэлэлцэх байсан боловч цаг үеийн шаардлага, үүссэн нөхцөл байдалтай уялдуулан өнөөдрийн хуралдаанд оруулж байна.

Дэлхий нийтийн санхүү, эдийн засгийн хямрал Монгол орны эдийн засагт тодорхой нөлөөлөлийг үзүүлж банкны зээлийн эх үүсвэр дутагдаж, жижиг дунд үйлдвэр, ажлын байр бий болгох үйл ажиллагаа багасаж мал аж ахуйн түүхий эдийн үнэ буурч, барилгын салбар зогсонги байдалд орж, бараа бүтээгдэхүүний эргэлт удаашран, мөнгөний ханш унаж, валютын хомсдол, гадаад дотоодын хөрөнгө оруулалт зогсонги байдалд орсон байна. Үүнийг даван туулах Монгол Улсын Засгийн газраас бодлого чиглэлийг боловсруулан гаргасан байна.

Тус арга хэмжээний хүрээнд Монгол улсын төсвийг тодотгосон хуулиар манай аймгийн төсвийг 419,4 сая төгрөгөөр бууруулжээ.

Үүссэн нөхцөл байдалд дүгнэлт хийж аймгийн эдийн засгийн байдал буурах хандлагатай байгаа учир үүнээс хохирол багатай гарах зорилгоор хүндрэл бэрхшээлээс гарах стратегийн 6 зорилт, 24 шалгуур үзүүлэлт бүхий 34 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг боловсрууллаа.

Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд төсвөөс 29,2 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтаар 9,1 тэрбум төгрөг, төсөл хөтөлбөрөөс 515,0 сая төгрөг, яамдаас 477,0 сая төгрөг, хувийн хэвшлээс 2,5 тэрбум төгрөг, тусгай сангаас 48,0 сая төгрөг, банкны зээлийн эх үүсвэрээс 3,5 тэрбум төгрөг, нийт 44,2 тэрбум төгрөг зарцуулна.

Төсөл хөтөлбөр, төсөвт тусгагдсан эх үүсвэрийн хүрээнд ажлын түр байр 2200, байнгын байр 1000-ыг гаргаж, халамж өндөр настаны тэтггэвэрт 11,4 тэрбум төгрөг олгож нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх орлогыг 4,9 тэрбумд хүргэнэ.

Гадаад худалдааг чөлөөтэй болгож элдэв саад, татварын ачаалалыг багасгаж татвараас зайлсхийгчдийг татварт бүрэн хамааруулах болно.

Ойн бүсийн хамгаалалт хийж, Буянт голын сав газрын дагуу газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн 600 гаруй иргэнийг ажлаар хангана.

2009 онд татварын орлогоор 2,5 тэрбум төгрөг төвлөрүүлж, банкны зээлийн эх үүсвэрээр 3,5 тэрбум төгрөгийг бүрдүүлэх шаардлага байгаа бөгөөд төсвийг хэмнэх шаардлагын хүрээнд 0,8 тэрбум төгрөг, дулааны горимын өөрчлөлтөөс 60,0 сая төгрөг, худалдан авах ажиллагаа болон бензин шатахууны нийлүүлэх асуудлыг журамласанаар 36,2 сая төгрөг хэмнэх тооцоо гарсан байна.

Хүндрэл бэрхшээлийг ард иргэдэд зөв ойлгуулан бодит мэдээлэлээр хангаж тэдний дэмжлэгтэйгээр ажиллахаар төлөвлөгөөг болосруулсан тул баталж өгч хэрэгжилтийг хангахад хамтран ажиллахыг илэрхийлж илтгэлдээ дурдсан байна.

Илтгэлийг аймгийн ИТХ-ын эдийн засгийн хороогоор хэлэлцэж хүндрэлийг даван туулах төлөвлөгөөг сайтар боловсруулсан тул сайшаан дэмжих, тус төлөвлөгөөг баталж чанд мөрдөж ажиллах, ард иргэдийн орлогын түвшинг бууруулахгүйгээр амьжиргааны түвшинг хадгалах бодлогыг баримталж ажиллах саналыг хуралдаанд оруулсан байна.

Хуралдаан “Төлөвлөгөө батлах тухай” 02 дугаар тогтоолоор санхүү эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг даван туулах аймгийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг сайшаан баталсан байна.

Аймгийн 2010 оны төсөвт нэмэлт өөрчөлт оруулах тухай аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Д.Алтангэрэл илтгэлдээ . . . Монгол Улсын Их Хурлаас төсвийн хуулинд оруулсан өөрчлөлтийн хүрээнд орон нутгийн төсвийн орлогыг 0,3 тэрбум төгрөг буюу 11,7 хувиар, төсвийн нийт зардлыг 1,4 тэрбум буюу 29,4 хувиар, улсын төсөвт байгууллагын зарлагыг 1,8 тэрбум төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байна.

Тайлангийн хугацаанд нийт 9,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөнийг 2,0 тэрбум төгрөгөөр багасгасан болно. Иймээс аймгаас сумдад олгох дэмжлэгийг 112,2 сая төгрөгөөр бууруулж сумдаас төвлөрсөн төсөвт оруулах орлогыг 2,7 сая төгрөгөөр болгож өөрчилсөнийг илтгэлдээ тэмдэглэсэн байна.

Илтгэлийг аймгийн ИТХ-ын эдийн засгийн хороогоор хэлэлцэж тус илтгэлийг ажил хэрэгчээр боловсруулсаныг дэмжиж орлогын төлөвлөлтийг шахуу болгох, оруулах орлогыг давуулж зайлшгүй зардлыг санхүүжүүлэх, бичиг хэрэг, шуудан холбоо, шатахууны зардалд лимит тогтоож мөрдөх, төсвийн давсан орлого, хэмнэсэн төсвийг ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж хувиарлах, хэрэгцээтэй байгууллагуудын хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх, батлагдаагүй болон батлагдсан зардлыг хооронд шилжүүлэн зарцуулахыг таслан зогсоох, батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулахыг цаашид анхаарч ажиллахыг тэмдэглэсэн байна.

Хуралдаан “Орон нутгийн 2009 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 03 дугаар тогтоолоор “аймгийн ИТХ-ын III дугаар хуралдаанаар баталсан орон нутгийн төсвийн орлогыг 309,7 сая төгрөгөөр, төсвийн нийт зарлага, хөрөнгө оруулалтыг 1,4 тэрбум төгрөгөөр, сумдын төсвийн доод хязгаарыг 104,1 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэгийг 112,2 сая төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 2,7 сая төгрөгөөр тус тус бууруулан баталжээ.

Мөн “Дүгнэлт өгөх тухай” 04 дүгээр тогтоолоор улсын төсөвт байгууллагуудын төсвийн зарлагыг 1,8 тэрбум төгрөгөөр бууруулжээ.

Хуралдаан аймгийн ИТХ-ын Төлөөлөгчөөс чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн аймгийн ИТХ-ын сонгуулийн 8 дугаар тойргийн төлөөлөгч Г.Гончигсүрэн, 19 дүгээр тойргийн төлөөлөгч Д.Ширэндэв нарын хүсэлтийг хэлэлцэж “Хурлын төлөөлөгчөөс чөлөөлөх тухай” 05 дугаар тогтоолоор Г.Гончигсүрэнг хуралдаанд оролцсон 22 төлөөлөгчийн 72,7 хувийн саналаар, 06 дугаар тогтоолоор Д.Ширэндэвийг хуралдаанд оролцсон 22 төлөөлөгчийн 68,1 хувийн саналаар чөлөөлсөн байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчийг сонгохоор Д.Энхсайханаар ахлуулсан тооллогын комисс байгуулж хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн 52,3 хувийн саналаар төлөөлөгч Ж.Цэндаюушийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчээр сонгосон байна.

Аймгийн ИТХ-ын ээлжит бус хуралдаанд 28 төлөөлөгчийн 24 буюу 85,7 хувь нь оролцож урилгаар 58 хүн оролцсоноос төсвийн байгууллагын ажилтан 39, иргэд 19 байгаа ба хуралдаанд 18 хүн үг хэлж, 3 асуудал хэлэлцэн 8 тогтоол баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 4 дүгээр хуралдаан

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн 313 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын 4 дүгээр хуралдааныг 2009 оны 12 дугаар сарын 24,25-ний өдөр хуралдуулж

1. Орон нутгийн ИТХ-ын төлөөлөгчдийг нөхөн сонгох сонгуулийн дүн, төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай

2. Аймгийн ИТХ-аас 2009 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан цаашдын зорилтын тухай илтгэл

3. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2009 оны биелэлт, аймгийн эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн тухай илтгэл

4. Аймгийн төсвийн 2009 оны урьдчилсан гүйцэтгэл, 2010 оны төсөл, 2008 оны төсвийн гүйцэтгэлийн тухай илтгэл

5. Аймгийн аудитын газраас 2009 онд зохиосон ажлын тайлан, орон нутгийн 2010 оны төсвийн төсөлд төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж, орлого нэмэгдүүлэх талаар өгөх саналын тухай илтгэл

6. Аймгийн газар зохион байгуулалтын 2009 оны ажлын дүн, иргэнд газар өмчлүүлэх болон газар зохион байгуулалтын 2010 оны төлөвлөгөөний тухай илтгэлүүдийг хэлэлцүүлэхээр зарласан байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 349 дугаар тогтоолоор хэлэлцэх илтгэлүүдээс аймгийн ИТХ-ын 2009 оны тайлан, нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэн чадавхийг сайжруулах зорилтын тухай илтгэл болон аймгийн төсвийн 2009 оны урьдчилсан гүйцэтгэл, төсөвт оруулах тодотгол, 2010 оны төсөл, 2008 оны гүйцэтгэлийн тухай илтгэлийг тус өөрчлөн найруулан баталсан байна.

Аймгийн ИТХ-ын дарга О.Ширэндэв өвчтэй байсан тул тэргүүлэгч Т.Баярсайханаар хуралдаан даргалуулах тухай ирүүлсэн хүсэлтийг төлөөлөгчдэд уншиж танилцуулан хуралдааны ажиллагаа эхэлсэн байна.

Хуралдаан аймгийн ИТХ-ын 2004 оны 2 дугаар хуралдаанаас баталсан дэгийн заалтыг мөрдөхөөр тогтож ажлын албаны нарийн бичгийн даргаар аймгийн ИТХ-ын Ажлын албаны ажилтан У.Цэрэнтогтох, Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн П.Пүрэвганди, Ч.Улаанхүү, Санхүү, төрийн сангийн хэлтсийн

мэргэжилтэн А.Оюундэлгэр, редакцийн комиссоор аймгийн Ерөнхий аудитор Ч.Цэрэнчимэд, Ховдын мэдээ сонины ажилтан Б.Шоовдой, тэмдэглэл хөтлөгчөөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны ажилтан Б.Сандагсүрэн нар ажилласан байна.

Хуралдаанаас гарах тогтоол шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Багдалаар ахлуулан 11 хүний бүрэлдхүүнтэй байгуулжээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, аймгийн сонгуулийн хорооны дарга Ч.Багдал “Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг нөхөн сонгох сонгуулийн дүн, төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай” илтгэлдээ ..Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль болон төрийн албаны хуулинд өөрчлөлт орсноор аймгийн ИТХ-ын 2,8,17,18,19 дүгээр тойрог тус бүрт 1, Дөргөн, Дуут, Зэрэг, Мөст, Мөнххайрхан, Жаргалант сумдад 1, Булган, Үенч, Цэцэг сумдад 2, Эрдэнэбүрэн суманд 4, Ховд суманд 6 төлөөлөгчийг тус тус чөлөөлсөнөөр орон нутгийн Хурлын сонгуулийн хуулийн дагуу аймаг, сумын ИТХ-аас чөлөөлөгдсөн төлөөлөгчдийг нөхөн сонгох сонгуулийг тухайн шатны хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны шийдвэрийн хүрээнд аймгийн сонгуулийн хороог 9, 12 сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас баталсан сумын сонгуулийн салбар хороодод 72, 38 хэсгийн хороодод 236 хүний бүрэлдэхүүнтэй байхаар намын төлөөллийг тэнцвэртэй байдлаар байгуулж ажилуулсан, сонгуулийн үйл ажиллагааг зохих хууль тогтоомжийн хүрээнд цаг хугацааны хуваарийг чанд мөрдөж явуулсанаар аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох нөхөн сонгуулийн Манхан сумын 8, Жаргалант сумын 17, 18, 19 дүгээр тойргийн сонгогчдын нэрийн жагсаалтад нийт 10698 сонгогч бүртгэгдсэнээс 6483 сонгогч буюу 60.7 хувь нь санал хураалтад оролцсон байна.

Булган сумын сонгуулийн хороо зохих хугацаанд байгуулагдсан боловч сонгуулийн бэлтгэлийг хангах талаар шуурхай ажиллаагүй, сонгогчдыг сонгуульд оролцуулах талаар бүх шатанд хангалтгүй ажилласнаас шалтгаалан Булган сумын хэмжээнд бүртгэгдсэн 4504 сонгогчийн 28.3 хувь санал хураалтад оролцож сонгогчдын ирц хуулиар тогтоосон хэмжээнд хүрээгүй тул аймгийн сонгуулийн хорооны шийдвэрээр дахин сонгуулийг зохих хууль тогтоомжийн хүрээнд зохион байгууллаа. Булган суманд явагдсан дахин сонгуульд сонгогчдын нэрийн жагсаалтад нийт 4276 сонгогч бүртгэгдсэнээс 2772 сонгогч буюу 64.8 хувь нь санал хураалтад оролцсоныг тэмдэглээд Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг нөхөн сонгох сонгуулийн 8 дугаар тойрогт 52,06 хувийн санал авсан С.Батмөнх /МАХН/, 17 дугаар тойрогт 54,07 хувийн санал авсан М.Ганзориг /МАХН/, 18 дугаар тойрогт 53,6 хувийн санал авсан Б.Ганзориг /МАХН/, 19 дүгээр тойрогт 50,9 хувийн санал авсан Ч.Чинбат /АН/, дахин сонгуулиар 2 дугаар тойрогт 72,6 хувийн санал авсан Б.Амгаланбадрах /МАХН/, нарын төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрүүлэх саналыг оруулсан байна.

Хуралдаан “Төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай” 4/02 тогтоолоор Б.Амгаланбадрахын, 4/03 тогтоолоор С.Батмөнхийн, 4/04 тогтоолоор М.Ганзоригийн, 4/05

тогтоолоор Б.Ганзоригийн, 4/06 тогтоолоор Ч.Чинбатын төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрсөн байна.

Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Багдал илтгэлдээ ... Аймгийн ИТХ, Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах зарчимд тулгуурлан нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн ирээдүйн төлөв, дэд бүтэц, газар зохион байгуулалт, хот байгуулалт, байгаль орчныг хамгаалах, сахилга дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зах зээлийн хүрээ өргөтгөх, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх замаар ард иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадуудын нийгмийн хамгааллыг өргөтгөх, санхүү, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд төсвийг үр ашигтай зарцуулах, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх зэрэг аймгийн хэмжээнд тулгарсан асуудлуудыг судлан шийдвэрлэхэд өөрийн нөөц боломж, онцлогийг харгалзан бодлого, чиглэлээ тодорхойлон ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс аймгийн эдийн засаг нийгмийн өмнөх жилүүдэд хүрсэн түвшинг сайжруулан мал сүргийн тогтвортой өсөлтийг хангах, эрчимжсэн аж ахуй бий болгох, жижиг, дунд болон бүс нутгийн хэмжээний үйлдвэр бий болгох, санхүүгийн салбарын тогтворжилтыг хангах, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжиж эдийн засгийн хөгжлийг дээшлүүлснээр санхүүгийн чадавхыг сайжруулан ажилгүйдлийг багасгах бодлого чиглэлийг тодорхойлоход үйл ажиллагаагаа чиглүүллээ.

Мал маллах уламжлалт аргыг аж ахуй, хөдөлмөрөө хоршсон, өндөр ашиг шимтэй, эрчимжсэн аж ахуй болгон хөгжүүлж бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглалтыг сайжруулан хамгаалалт бүхий хадлангийн талбайг нэмэгдүүлэн малын тэжээлийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх, өндөр ашиг шимтэй цэвэр үүлдрийн болон эрлийз малын тоог өсгөж нутагшуулах, малын зохистой бүтцийн харьцаа бий болгох, суурин болон хагас суурин аж ахуйг хөгжүүлэх, малчдыг мэдээлэл сурталчилгаагаар хангах зэрэг бодлогыг тодорхойлон шийдвэрлэлээ.

Аймгийн хэмжээнд мал ахуй, газар тариалангийн 58 хамтын хоршсон аж ахуй нэгж үйл ажиллагаа эрхэлж байна. 2009 онд 2268.4 мянган мал тоологдсон нь өмнөх оноос 218.2 мянган толгойгоор буурч байгааг цаашид уламжлалт мал маллагааны аргын хандлагыг эрчимжсэн мал аж ахуй болгоход шинжлэх ухааны үндэстэйгээр эрхлэн хөтлөх шаардлагатай байна.

Мөн газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх тухай шийдвэр гаргаж тариалангийн талбай, ялангуяа усалгаатай тариаланг нэмэгдүүлэх, үрийн чанарыг сайжруулан үр өгөөжийг дээшлүүлэх, газар тариалангийн бүтээгдэхүүнийг хадгалах,

савлах, боловсруулах үйлдвэрлэлийг бий болгох, боловсон хүчнийг бэлтгэх буюу давтан сургах, хөрсийг эвдрэлээс хамгаалах, техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, “Төмс”, “Чацаргана”, “Малын тэжээл” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх бодлогыг тодорхойллоо.

Аймгийн хэмжээнд тайлангийн жилд 2296.3 га талбайд тариалалт хийж 18741.1 тн ургац хурааснаас төмс 9359.8 тн, үр тариа 1009.2 тн, хүнсний ногоо 7032.9 тн, тэжээлийн ургамал 1339.5 тн тус тус хураасан байна.

Монгол Улсын Засгийн газраас “Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил”-ийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн хэмжээнд нэн тэргүүнд дэмжих жижиг дунд үйлдвэрлэлийг тодорхойлон санхүү зээлийн дэмжлэг үзүүлэх, зах зээлийн мэдээллээр хангаж үйлдвэрлэл үйлчилгээний ажиллагааг тогтмолжуулан үр ашгийг дээшлүүлэх бодлогыг дэвшүүллээ. Аймгийн хэмжээгээр 2009 оны урьдчилсан тооцоогоор ДНБ үйлдвэрлэл 125.3 тэрбум орчим төгрөгт хүрч нэг хүнд ногдох хэмжээ 1384 төгрөгт хүрэх төлөвтэй байна.

Аймгийн хэмжээнд 700 гаруй жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагууд ажиллаж аж үйлдвэрийн салбар 3852.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 5208.9 сая төгрөгийн борлуулалт хийж барилгын салбар 9.9 тэрбум төгрөгийн барилга угсралт их засварын ажил гүйцэтгэлээ.

Жижиг дунд үйлдвэрлэлийг шинээр бий болгох, хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 12 сумын 36 төсөлд 198.0 сая төгрөг, аймгийн төвд 52 төсөлд 652.0 сая төгрөг нийт 850.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг аймгийн хамтын сан, Зоос банк, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн нэгдсэн эх үүсвэрээс олгосноор орон нутагт 650 орчим хүн түр болон бүр ажлын байраар хангагдлаа.

Аймгийн төсвийн орлогыг бүрдүүлэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэн төсөв захирагчдын ажлын хариуцлагыг эрс дээшлүүлэх талаар гаргасан шийдвэр зохих үр дүнгээ өглөө. Ялангуяа аймгийн ИТХ-ын хуралдаанаас “санхүү эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг даван туулах аймгийн стратеги төлөвлөгөө”-г баталж улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшил, төсөл хөтөлбөрийн байгууллагуудын 2009 онд ашиглах санхүүгийн нөөцийг нэгтгэн тэргүүн ээлжид санхүүжүүлэх, дэмжлэг үзүүлэх ажил үйлчилгээ, нийгмийн хамгаалал, хөрөнгө оруулалтын арга хэмжээг тодорхойлж, бүх шатанд арвилан хэмнэлтийн горимыг баримтлан үр ашгийг дээшлүүлэх талаар гаргасан шийдвэр зохих үр дүнд хүрснийг тэмдэглэж байна.

Орон нутгийн өмчийн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх, өмчид тавих хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 50 дугаар тогтоолоор “Орон нутгийн өмчийн алба” байгууллаа. Өмчийн алба нь төрийн болон орон нутгийн өмчийн холбогдолтой хууль тогтоомж, аймгийн Иргэдийн

төлөөлөгчдийн хурал, түүний Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид энэ онд дулаан дамжуулах, түгээх шугам сүлжээ, нийтийн зориулалттай орон сууцны доторх тоног төхөөрөмж, цахилгаан монтаж тэдгээрийн бүрэн бүтэн байдал, стандарт норм шаардлагыг хариуцан, хэрэглэгчдэд дуудлагаар түргэн шуурхай, чанартай үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх зорилгоор “Шугам сүлжээ орон сууц ашиглалтын газар”, улсын болон орон нутгийн өмчит төсвийн байгууллагуудад дулаан түгээх, зочид буудлын үйлчилгээг стандарт норм шаардлагын дагуу чанартай, мэргэжлийн түвшинд үзүүлэх зорилгоор “Мянган угалзат” зэрэг орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудыг шинээр байгуулан үйл ажиллагааг нь эхлүүлээд байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс нийгмийн салбарт дэвшүүлсэн зорилт ялангуяа тухайн үед өндөр түвшинд байсан халдварт өвчин, боловсролын байгууллагуудын үйл ажиллагааны доголдоос шалтгаалсан сургалтын чанарын бууралт зэрэг тулгамдсан асуудлуудад онцгойлон анхаарлаа төвлөрүүлэн тодорхой ажлыг хийж гүйцэтгэлээ.

Эрүүл мэндийн чиглэлээр эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний мастер төлөвлөгөөг баталснаар эмнэлгийн тусламж үйлчилгээг шинэ шатанд гаргах, үйлчлүүлэгч, иргэдийн сэтгэл ханамжид нийцсэн чанартай, хөнгөн шуурхай үйлчилгээ, чанартай найдвартай эм, тариа, урвалж орчин үеийн технологийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр эмнэлгийн байгууллагуудыг хангахад баримтлах бодлого, чиглэлүүдийг тодорхойлон хэрэгжүүллээ.

Эх нярайг эрсдэлээс хамгаалах сангийн журам, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай, эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай зэрэг ажил хэрэгч, хойшлуулшгүй заалтууд бүхий тогтоолуудыг гарган хэрэгжүүлж, биелэлтийг нь тооцон ажиллаа. Мөн аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн өдрөөр Бүсийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж буй байдал, цаашид авах арга хэмжээний тухай, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зохиож байгаа ажлын үр дүн, аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хүрэлцээ, хангамж, тогтвор суурьшлын талаар цаашид авах арга хэмжээний тухай мэдээллүүдийг өргөн хүрээтэй аймгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр баримтлах бодлогын чанартай асуудлуудыг авч хэлэлцэж үнэтэй санал, бодлоо солилцлоо.

Мөн иргэдийн нийгмийн эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, нийтийн биеийн тамир спорт, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо, иргэдийн санал санаачилгыг дэмжиж өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх арга замуудыг нийтийн хүртээл болгож хэрэгжүүлэх шийдвэр гарган хэрэгжүүлж байна. Тус онд аймгийн төвд 750.0 орчим сая төгрөгөөр Усан спорт сургалтын төв барьж

ашиглалтанд оруулсан нь олон нийтийн нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний хүрээ өргөжиж шинээр усан спортын төрөл хөгжих үндэс суурь тавигдлаа.

Ерөнхий боловсролын сургуулийн 23 сургуулийн 659 бүлэгт 20400 хүүхэд суралцах болж 6 настай 1886 хүүхдүүдийг сургуульд элсүүлж, сургуулийн насны хүүхдийн хамралт 95.6 хувь, 27 цэцэрлэгийн 196 бүлэгт 6235 хүүхэд хамруулж нийт сумдад улирлын чанартай гэр цэцэрлэг ажиллуулснаар сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 69.0 хувьтай байна. Ерөнхий боловсролын сургуулийн болон сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн боловсролыг дээшлүүлэх, сурах ая тухтай, тохилог орчин бий болгох, багш, ажилтнуудын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, багш, сурагч, эцэг эхийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн өдрөөр хэлэлцэж санал, зөвлөмж гаргаж аймгийн БСГ-т даалган хэрэгжүүлээд байна.

Хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдний авьяас чадварыг хөгжүүлэхээр хүүхдүүдийн хичээлээс гадуурх төрөл бүрийн дугуйлан, сургалтуудыг хүртээмжтэй, чанартай, үр дүнтэй явуулах зорилгоор хүүхдийн төлөө хэлтсийн төлбөртэй сургалт явуулах журмыг батлан хэрэгжүүлснээр өнөөдрийн байдлаар 11 төрлийн дугуйланд 250 орчим хүүхэд хамрагдан үйл ажиллагаа нь тогтмолжиж байгаа ч ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй нийт хүүхдийн тоонд харьцуулахад чамлалттай байгааг анхаарвал зохино.

Энэ онд нийгмийн халамж, үйлчилгээний чиглэлээр дэвшүүлсэн зорилтууд бүрэн хэрэгжиж иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд зохих хувь нэмэр боллоо. Ажилгүй ажил идэвхтэй эрж буй 618 хүн бүртгүүлснээс 370 орчим хүнийг ажлын байраар хангаж 976 иргэнийг ажлын байраар зуучиллаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 23 төсөлд 48.0 сая төгрөг, нийтийг хамарсан ажилд 1400 орчим хүнд 96.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон аж ахуй эрхлэлтийг нэмэгдүүлэн түр ажлын байраар хангахад бодиттой хувь нэмэр орууллаа.

Мөн шинээр гэр бүл бологсдод 710.0 сая төгрөг, шинээр төрсөн хүүхэд 1050 хүүхэд 105.0 сая төгрөг, ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлтөд 38 хүнд 3.4 сая төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжээр 16141 хүүхдэд, 641.5 сая төгрөг жирэмсэн 3183 эхэд 271.5 сая төгрөг, алдарт 5628 эхэд 363.0 сая төгрөг, хүүхэд хөгжилд 1713.5 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт 9.5 сая төгрөг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтөд 170.0 сая төгрөг, нийгмийн халамжийн тэтгэвэрт 1740 хүнд 431.5 сая төгрөг, мөнгөн тэтгэмж 925 хүнд 119.2 сая төгрөг, олгосон нь хүүхэд багачууд болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн амьдрал ахуйг тэтгэхэд дэмжлэг боллоо.

Аймгийн нийгмийн даатгалын хэлтэс энэ онд урьдчилсан байдлаар 4384.5 сая төгрөгийг төвлөрүүлэн 9283 өндөр насны тэтгэвэрт 8617.5 сая төгрөг, тэтгэмжид 1459 хүнд 383.7 сая төгрөг, үйлдвэрлэлийн осолд 44 хүнд 53.7 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын

санхүүжилтэд 1423.6 сая ажилгүйдлийн тэтгэмжид 225 хүнд 108.5 сая төгрөг сая төгрөг тус тус олгосон нь иргэдийн амьдралыг тэтгэж баталгааг хангалаа.

Тайлангийн хугацаанд аймгийн ИТХ-ын хуралдааныг 2009 оны 03 сарын 02-нд хуралдуулж Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх зорилгоор “Аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан төлөөлөгчдийн тухай” асуудал, 2009 оны 03 сарын 26-нд хуралдуулж “Аймгийн санхүү, эдийн засгийн өнөөгийн байдал, түүнд хийх дүгнэлт, хүндрэлийг даван туулах үйл ажиллагааны бодлогын тухай” аймгийн Засаг даргын илтгэл, “Аймгийн 2009 оны төсвийн тодотголын тухай” аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын илтгэл, “Аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан төлөөлөгчдийн тухай асуудал хэлэлцэж, хэлэлцсэн асуудал бүрээр тогтоол гаргаж, хэрэгжүүлж ажиллаж байна.

ИТХ-ын хуралдаанд төлөөлөгчдийн ирц 85.7-оос дээш болон бүрэн бүрэлдэхүүнтэйгээр хуралдаж, хуралдаанд 85 хүн урилгаар оролцсоноос 63 нь төсвийн байгууллагын ажилтан, 22 нь иргэд байна. Хуралдаанд давхардсан тоогоор нийт 31 хүн үг хэлж, санал шүүмжлэл гаргасан ба хуралдаанаас нийт 13 тогтоол, “Санхүү эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг даван туулах Ховд аймгийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан гаргалаа.

Аймгийн ИТХ-ын чөлөөт цагт Тэргүүлэгчид сард гурваас доошгүй удаа хуралдаж, нийт 43 удаа хуралдаж аймгийн ИТХ, Засаг даргын сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл, хөтөлбөрт тусгагдсан бодлого арга хэмжээг ажил хэрэг болгох, эдийн засаг нийгмийн салбаруудын хөгжлийн зорилтыг цаг алдалгүй, шуурхай шийдвэрлэх, санхүүгийн нөөц, өмч хөрөнгийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх төрийн дээд шагналд тодорхойлох, төрийн захиргааны болон үйлчилгээний ажилтны гүйцэтгэх хариуцлагыг сайжруулах зэрэг асуудлууд хэлэлцэж 357 тогтоол гаргаж, түүний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцсэн ихэнх асуудлууд аймгийн ИТХ, Засаг даргын сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хөтөлбөрт тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх, эдийн засаг, нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг цаг алдалгүй шуурхай шийдвэрлэхэд чиглэгдэж байна.

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэн эрхийн хугацаанд хэрэглэх үнэмлэх, энгэрийн тэмдэг, албаны хэвлэмэл хуудасны загвар, хэрэглэх журам, аймгийн ИТХ-ын хорооны ажиллах журам, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн зардал олгох журам, 2009 онд олгох зардлын хэмжээг баталж, хэрэгжүүлээд байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, албан ёсны статистикийг хөгжүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хүнсний баталгаат байдлыг хангах зэрэг дэд хөтөлбөрүүд, Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Ховд аймгийн 2009-2012 оны

төлөвлөгөө, төсвийн үндсэн чиглэл, Ховд аймагт 2009 онд явагдах сургалт, семинар, уулзалт, зөвлөгөөний төлөвлөгөө, хяналт шалгалтын нэгдсэн график, нийтээр тэмдэглэх ой, тэмдэглэлт өдөр, спорт, урлагийн арга хэмжээний төлөвлөгөө, Эрүүл мэндийн үйлчилгээний мастер төлөвлөгөө, аймгийн ИТХ-ын хороодын ажиллах журам, сум, багийн Хурлын ажлыг дүгнэх журам, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийг данснаас хасах, дансанд тусгах журам, сүм хийд байгуулж үйл ажиллагаа явуулах журам, эх нярайг эрсдэлээс хамгаалах сангийн журам, цахим тоглоом болон түүнийг дагасан компьютер үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, иргэнд зөвшөөрөл олгох, хяналт тавих болон согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох, хяналт тавих журам, Хүүхдийн төлөө хэлтсийн хүүхэд хөгжүүлэх төлбөртэй сургалт явуулах журам зэргийг батлан хэрэгжүүлээд байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид Буянт, Ховд голын сав газрын зөвлөл байгуулах, Хүн, ам орон сууцны тооллогын ажлын санхүүжилт, төсвийн тухай, ахмад настны талаар авах арга хэмжээний тухай, Мянганы хөгжлийн зорилтын 2015 онд хүрэх түвшин, аймгийн өмчийн 2008 оны тооллогын дүнгийн тухай, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай, Шугам сүлжээ, орон сууц ашиглалтын газар, Мянган угалзат орон нутгийн өмчит үйлдвэрийн газар байгуулах тухай, аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Хүүхдийн тасгийг Монгол Улсын Хүний гавъяат эмч М.Албанчийн нэрэмжит болгох тухай, Үенчийн хавцал, Мандал хайрхан уул, Булган голын Их, бага онгогийг улсын тусгай хамгаалалтад авах, Ховд хотыг улсын зэрэглэлтэй хот болгох тухай саналуудыг уламжилж, Улс, орон нутгийн төсвийн байгууллагууд төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн 2008 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийсэн дүнгийн тухай аймгийн ерөнхий Аудитор Ч.Цэрэнчимэдийн, Ховд аймгийн төрийн болон орон нутгийн өмчийн, төсвийн байгууллагуудын 2008 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тэнцлийг хүлээн авсан байдал, түүнд өгөх дүгнэлт, цаашид авах арга хэмжээний тухай аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Д.Алтангэрэлийн илтгэлийг хэлэлцэж “Санхүүгийн талаар авах зарим арга хэмжээний тухай”, Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар зохиож байгаа ажлын тухай аймгийн Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх албаны дарга А.Оюунчимэгийн мэдээллийг хэлэлцэж “Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай”, аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийн хаврын суулгац, үрийн нөөц, бэлтгэл ажлын үр дүн, мал хаваржаалалтын байдлын тухай аймгийн Хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн газрын дарга Г.Гончигсүрэнгийн мэдээллийг хэлэлцэж “Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх тухай, Орон нутгийн төсвийн 2008 оны давсан орлого, хэмнэгдсэн зардлын талаар аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Д.Алтангэрэлийн илтгэлийг хэлэлцэж “Давсан орлогыг зарцуулж, хариуцлага тооцох тухай”, Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас хийсэн ажлын үр дүн, цаашид баримтлах бодлого,

хяналт шалгалтын үндсэн зорилтын тухай Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Батцэнгэлийн мэдээллийг хэлэлцэж “Төрийн хяналтын үйлчилгээг сайжруулах тухай”, Төлөөлөгчдийн өдрийн санал дүгнэлтийг хэрэгжүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”, орон нутгийн өмчийн асуудлууд, Төрийн дээд шагналд тодорхойлох, аймгийн Хүндэт иргэн, Хүндэт тэмдгээр шагнах, Иргэдийн санал хүсэлт, өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэх зэрэг аймгийн тулгамдсан болон стратеги, үйл ажиллагааны олон чухал асуудал арга хэмжээг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааныг бүсчлэн Мөст, Манхан сумдад зохион байгуулж Сумын ИТХ-ын үйл ажиллагааны үр дүн, төлөөлөгчидтэй ажиллах арга барилын тухай Мөнххайрхан сумын ИТХ-ын даргын илтгэл, мэдээллийг хэлэлцэж “Ажлын арга барилыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай”, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх талаар зохиож байгаа ажлын тухай Булган сумын Засаг даргын илтгэлийг хэлэлцэж “Жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх тухай, Бэлчээрийн хуваарилалт, ашиглалт, хамгаалалтын талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тухай Мөст сумын Засаг даргын илтгэлийг хэлэлцэж “Бэлчээрийн хуваарилалт, ашиглалт, хамгаалалтын талаар авах зарим арга хэмжээний тухай”, Сумын ИТХ-ын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлж, санхүүгийн сахилга, хариуцлагыг дээшлүүлж, орлого нэмэгдүүлэх талаар зохиож байгаа ажлын үр дүнгийн тухай Манхан сумын ИТХ-ын даргын мэдээллийг хэлэлцэж “Санхүүгийн талаар авах зарим арга хэмжээний тухай”, Малын үүлдэр, угсаа, ашиг шимийг дээшлүүлж, сайн үүлдрийн мал бий болгох, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх бодлогын талаар зохиож байгаа ажлын тухай Дарви сумын Засаг даргын илтгэлийг хэлэлцэж “Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх тухай”, Сумын Боловсрол, соёлын байгууллагуудыг хөгжүүлж, удирдлагаар хангаж байгаа арга барилын тухай Зэрэг сумын Засаг даргын итгэлийг хэлэлцэж “Сумын Боловсрол, соёлын байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай” тогтоол гаргаж сум, холбогдох албан байгууллагуудад хүргүүлэн хэрэгжүүлээд байна. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдааныг бүсчлэн сумдад зохион байгуулах нь аймаг, сумын ИТХ-ынхан ажлын арга барилаас харилцан суралцах, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид сумын үйл ажиллагаатай газар дээр нь танилцан иргэдтэй уулзаж ярилцах, санаа бодлыг нь сонсож бодлогыг тодорхойлоход тусган, хууль тогтоомж, гаргасан шийдвэрийг сурталчлах олон талын ач холбогдолтой үр дүнтэй ажил боллоо.

ИТХ-ын бүтцийн 5 хороо ажлаа төлөвлөн, ИТХ-ын хуралдааны болон Тэргүүлэгчдийн хуралдааны шийдвэрийг судлан дүгнэлт гаргах, сурталчлах, биелэлтийг зохион байгуулах, үр дүнг хянаж шалгах, үнэлгээ өгөх, мониторинг хийх талаар ахиц өөрчлөлт гаргасан жил байлаа.

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн өдрийг 4 дүгээр сард зохион байгуулж “Бүсийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж буй байдал, цаашид авах арга

хэмжээний тухай” БОЭТ-ийн захирал П.Эрвээхэйгийн мэдээлэл, Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зохиож байгаа ажлын үр дүн, аймгийн Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хүрэлцээ, хангамж, тогтвор суурьшлын талаар цаашид авах арга хэмжээний тухай аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Б.Жамсрангийн сонсгол, мэдээлэл, 8 дугаар сард зохион байгуулж “Аймгийн эдийн засаг нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2010 оны төсвийн төсөл боловсруулсан дүн”, “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн байгууллагуудын үйл ажиллагааны өнөөгийн байдал, 2009-2010 оны хичээлийн жилийн бэлтгэл хангалт, цаашид анхаарах асуудлуудын тухай аймгийн Боловсрол соёлын газрын дарга Б.Дүгэржавын мэдээлэл, 10 дугаар сард зохион байгуулж “Аймгийн өвөлжилтийн бэлтгэл ажлын тухай” аймгийн Засаг дарга Г.Нямдаваагийн мэдээллийг хэлэлцэж, хэлэлцэж буй асуудал тус бүрээр төлөөлөгчид асуулт асууж, цаашид хэрэгжүүлж зохион байгуулах ажил, асуудлын талаар үнэтэй зөвлөгөө, санал дүгнэлт гаргасныг холбогдох байгууллага, албан тушаалтанд тэмдэглэлээр хүргүүлж, Эрүүл мэндийн газрын илтгэлтэй холбогдуулан тэргүүлэгчдийн тогтоол гарган хэрэгжүүлээд байна.

Сумын ИТХ, багийн ИНХ-ын үйл ажиллагаа, дотоод ажлын талаар арга зүйн зөвлөмж өгөх, цаашид хамтран ажиллах талаар санал солилцох зорилготой Конрад Адеунарын сангийн дэмжлэгтэйгээр сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарын сургалт семинарыг 2009 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулж “Сумын ИТХ-ын ажлын тайлан бичих аргачлалын тухай”, “ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдааны материал бүрдүүлэх тухай”, “багийн ИНХ-д арга зүйн зөвлөгөө үзүүлэх талаар”, “Төрийн дээд шагнал болон Алдарт эхийн одонгоор шагнуулах хүмүүсийн тодорхойлолт материал бүрдүүлэх тухай”, “Төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах талаар”, “Албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн стандарт архивын талаар”, “Тогтоол шийдвэрийн биелэлт тооцох тухай” сэдвүүдээр хичээл зааж, харилцан ярилцаж, сумын ИТХ, багийн ИНХ-ын ажил дүгнэх үзүүлэлт, “Аймгийн тэргүүний багийн ИНХ-ыг шалгаруулах” байнгын болзол зэргийг боловсронгуй болгох талаар санал солилцож чөлөөт ярилцлага зохион байгуулсан нь илүү үр дүнтэй ажил боллоо.

НӨУБ-ын анхан шатны нэгж багийн ИНХ-ын үйл ажиллагааг сайжруулах, бэхжүүлэх, багийн ИНХ-ын дарга түүний тэргүүлэгчдийн үйл ажиллагааг тогтмолжуулан сайжруулах, чадваржуулах зорилгоор “Багийн ИНХ-ын ажлын дэвтэр”-ийг шинэчилэн аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн ажлын албанаас хэвлүүлэн хүргүүллээ. Ажлын дэвтэрт багийн ИНХ-ын эрх хэмжээг тусгасан хуулийн заалтууд, багийн ИНХ-ын үлгэрчилсэн байнгын дэг, Тэргүүний багийн ИНХ шалгаруулах болзол, багийн хүн, ам, эдийн засаг, нийгмийн бүхий л үзүүлэлтүүдийг тусгасан судалгааг хамруулсан бөгөөд тухайн дэвтрийг багийн ИНХ-ын дарга нар бүрэн эрхийнхээ хугацаанд хэрэглэж, багийн ИНХ-ын хуралдааны материал болгон сумын архивт хадгалах юм.

Аймгийн ИТХ болон Тэргүүлэгчдийн хуралдаанаас гарсан тогтоол, шийдвэрүүдийн биелэлтийг сум, баг, холбогдох байгууллагуудаас гаргуулан авч Ажлын албанд нэгтгэн дүгнэж үзэхэд: албан байгууллагуудад холбогдолтой 110 тогтоолын 201 заалтыг заалт тус бүрээр тооцож гаргахад санхүү, төрийн сангийн чиглэл 83.6, боловсрол, соёлын чиглэл 72.0, өмч, хөрөнгө 71.1, хууль хяналтын байгууллагынх 64.7, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэл 63.4, эрүүл мэндийн салбарын чиглэл 50.0 хувьтай буюу аймгийн дүнгээр 68.6, сумын дүнгээр 64.9 хувийн биелэлттэй байна.

Аймгийн ИТХ-аас тус онд явагдсан Ерөнхийлөгчийн болон орон нутгийн ИТХ-ын төлөөлөгчийг нөхөн сонгох сонгуулийн үйл ажиллагаанд зохих хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж зохион байгууллаа.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн саналын дагуу Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны баталсан шийдвэрээр Ерөнхийлөгчийн сонгуулийн аймгийн Нутаг дэвсгэрийн хороо 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас санал болгосноор 17 сумын сонгуулийн салбар хороодод 111, 93 хэсгийн хороодод 853 хүний бүрэлдэхүүнтэй байхаар байгуулж салбар хороонд ажиллагсдын 41.4 хувь нь МАХН-аас, 42.3 хувь нь АН-аас, 16.3 хувь нь нам бус, хэсгийн хороонд ажиллагсдын 43.9 хувь нь МАХН-аас, 44.7 хувь нь АН-аас, 11.4 хувь нь нам бус төлөөлөлтэй байхаар аль нэг улс төрийн нам хүчин давамгайлахгүй байх хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллаа.

Ерөнхийлөгчийн сонгуулиар аймгийн дүнгээр нэрсийн жагсаалтад 45122 сонгогч бүртгэгдсэнээс 33552 сонгогч буюу 74.3 хувь нь санал хураалтад оролцсоноос 1565 сонгогч буюу 4.66 хувь нь саналаа урьдчилан, 1611 сонгогч буюу 4.86 хувь нь зөөврийн битүүмжилсэн хайрцгаар саналаа өглөө. Санал тэмдэглэсэн 33552 хуудаснаас 461 хуудас буюу 1.37 хувь нь хүчингүйд тооцогдож, хүчинтэй 33091 саналаас МАХН-аас нэр дэвшигч Н.Энхбаярын төлөө 14251 буюу 42.47 хувийн, АН-аас нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн төлөө 18791 буюу 56.01 хувийн санал тус тус өгч 49 буюу 0.14 хувь нь санал тэмдэглээгүй байна.

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль болон орон нутгийн Хурлын сонгуулийн хуулийн дагуу аймаг, сумын ИТХ-аас чөлөөлөгдсөн төлөөлөгчдийг нөхөн сонгох сонгуулийг тухайн шатны хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны шийдвэрийн хүрээнд аймгийн сонгуулийн хороог 9, 12 сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас баталсан сумын сонгуулийн салбар хороодод 72, 38 хэсгийн хороодод 236 хүний бүрэлдэхүүнтэй байхаар намын төлөөллийг тэнцвэртэй байдлаар байгуулж ажиллууллаа.

Өнгөрч буй 2009 онд Монгол Улсын Ерөнхийлөгчид Төрийн дээд шагналаар шагнуулахаар 108 хүний тодорхойлолтыг өргөн мэдүүлж Монгол Улсын Ардын жүжигчин 1, Гавьяат механикжуулагч 1, гавьяат тамирчин 1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон 3, Алтан гадас одон 12, Хөдөлмөрийн хүндэт медаль 8, Шударга журам медаль 1 иргэн хүртэж,

Алдарт эх I, II одонгоор 108 эх, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр аймгийн Хүндэт иргэнээр 2, Хүндэт тэмдгээр 98 хүн шагнагдсан байна.

Аймгийн ГХУСАЗЗ-ийн хурлыг 5 удаа хийж зохицуулах зөвлөлийн ажлын мэдээллийг 2 удаа, малын хулгайтай тэмцэх асуудлаар цагдаагийн газрын дарга, хошууч П.Оростогоо, Буянт сумын малын хулгайтай тэмцэх зөвлөлийн дарга М.Пүрэв нарын илтгэл, онцгой байдлын үеийн хохирол хөнөөлийг багасгах талаар Онцгой байдлын хэлтсийн дарга Я.Буянтөрийн мэдээлэл хэлэлцлээ.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг багасгах зорилгоор бүх сумын ГХУСАЗ салбар зөвлөл, байгаль хамгаалах чиг үүрэгтэй төр, төрийн бус байгууллага, төслийн газруудын ажилтан сонгуультны сургалт, семинар явуулж бүсийн сумдын ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Нийгмийн хэв журмыг хамгаалах олон нийтийн байцаагчдын талаар онцгой анхаарч олон нийтийн байцаагч ажиллуулаагүй 4 суманд байцаагч ажиллуулах чиглэл өгч Булган суманд 2, бусад сумдад тус бүр нэг байцаагч ажиллах болж тэднийг ажлын хувцастай болгон, үнэмлэхжүүлж, нэгдсэн 2 өдрийн сургалтад оролцуулж, сургалтад оролцож чадаагүй байцаагчдыг аймагт ирүүлэн аргачилсан сургалт семинараар хангаж ажиллаа. Олон нийтийн байцаагчдаас Үенч, Эрдэнэбүрэн, Мөст сумын байцаагчид бусдаасаа илүү санаачилгатай, үр дүнтэй ажиллаж байна. Олон нийтийн байцаагчдын сарын урамшууллыг 2010 онд 10000 төгрөгөөр нэмэгдүүлж, сурталчилгаа, мэдээллийн зардалд бага ч гэсэн төсөв хуваарилсан болно. Сумын ИТХ, ГХУСАЗСЗ, Засаг дарга нар олон нийтийн байцаагчтай гэрээ байгуулан үр бүтээлтэй ажиллуулахын зэрэгцээ ажиллах боломжоор хангахад нь зохих туслалцаа, дэмжлэг үзүүлж байх нь зүйтэй.

Аймгийн ИТХ, Засаг дарга түүний албад нийгмийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн байгууллагууд, ГХУСАЗЗ ялангуяа аймгийн Цагдаагийн газар, нутгийн удирдлагын байгууллагуудын идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд 2009 оны байдлаар бүртгэгдсэн гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 145 хэргээр буюу 29.7 хувиар буурсан байна.

Хулгайлах гэмт хэрэг 35.0, иргэдийн өмч хулгайлах гэмт хэрэг 28.5, мал хулгайлах гэмт хэрэг 65.5 хувь буурсан үзүүлэлттэй байна.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 16.6 хувь, амиа хорлосон буюу золгүй байдлаар нас барсан хэрэг 6-аар өсөж гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй хэрэг буурсан хэдий ч 31 хэрэг бүртгэгдээд байгаа болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар илүү үр өгөөжтэй ажлууд зохион байгуулах шаардлага байсаар байна. Энэ бол ганц хуулийн болон цагдаагийн байгууллагын үүрэг төдий биш нутгийн удирдлагын бүхий л байгууллагын анхаарч ажиллах гол цэг байлган 2010 онд гэмт хэрэг зөрчилгүй байгууллага, хамт олон баг, сум болох зорилт тавьж эрч хүчтэй ажиллавал зохино.

Аймгийн хэмжээгээр улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан Ерөнхий Боловсролын сургуулиудад 9 сарын 10-ны өглөөний хичээлийн эхний цагийг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн талаар тайлбар, таниулгын хичээл явуулж, “Хар өдрүүд” зохион бичлэгийн уралдаан, “Лхүмбийн хэрэг”, “Намын эсэргүү бүлэг”, “Сэхээтний төөрөгдөл” сэдэвт уулзалт, ярилцлага, “АХА”, “Дэвжээ” тэмцээнүүдийг зохион байгуулж, замын хөдөлгөөнд оролцож байгаа техникүүд гэрлээ асаан оролцож, сүм хийд буяны ном хурж, хэлмэгдэгсдийн ар гэрийг хүлээн авч уулзаж ярилцах, тэдний санал сэтгэгдлийг сонсох, хэвлэлийн бага хурал зохион байгуулах, зарим иргэдэд гарын бэлэг, тусламж дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг аймгийн болон сумын салбар комиссууд зохион байгуулж явууллаа.

Аливаа асуудлын гарцыг оновчтой тодорхойлж, хэрэгжүүлэх хугацааг зөв олж аймаг, сум, багийн Хурлын байгууллагууд “тухайн нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн асуудлуудыг хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэж болно” гэсэн Үндсэн хуулийн заалтыг мөрдлөг болгож тус тусын ажил, асуудлаа хуулийн хүрээнд төр засгийн бодлоготой уялдуулан зөв зохион байгуулж, нутаг дэвсгэрийн хөгжил, иргэдийн сайн сайхан амьдралын төлөө ажиллах нь нэн тэргүүний зорилт болж байна.

1.Нутаг дэвсгэрийн цогцолборын хөгжлийг түргэтгэх үүрэгтэй бүх шатны хурал, түүний төлөөлөгчид, удирдлагууд үйл ажиллагаагаа өөрчлөн иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан 2010 оныг НӨУБ-ын үндсэн чиглэл, Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөрийн 55-аас доошгүй хувийг биелүүлэх жил болгох зорилт дэвшүүлж ажиллацгаая.

Санхүүгийн хүндрэл тохиолдсон, хөрөнгийн хуримтлал бага, санхүү, төсвийн хүрэлцээ хэрэгцээ шаардлагын өсөлт хөгжилтийг бүрэн хангах боломжгүй ч санаачилж хийвэл зохих их ажил бидэнд тулгамдсан зорилт болж байна.

2.Ховд аймгийг үйлдвэржүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, уул уурхайн салбарт тулгуурласан үйлдвэрлэл, орон нутгийн түүхий эд, мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүнийг боловсруулах жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд онцгойлон анхаарч 2010 оны бүтээн байгуулалтын ажилд ИТХ-ын тэргүүлэгчид, Засаг даргын Тамгын газар холбогдох агентлаг, гүйцэтгэгч, захиалагч, ашиглагч байгууллагууд хүч анхаарал тавьж өөрөөс шалтгаалах бүхнийг хийвэл зохино.

Энэ нь ажлын зөв эхлэл буюу хөрөнгө оруулалтын тендер зарлах, үнэлгээ хийх, дүгнэх, гүйцэтгэлийг зохион байгуулах, түүний үр дүнд хяналт тавьж, хүлээж авах ажиллагааны цогц арга хэмжээнээс шалтгаалах тул өнөөдрийн иргэдээс байнга гарч буй шүүмжлэлд дүгнэлт хийж нээлттэй, шударга тендерийн системийг тогтоон, эцсийн үр дүнд хүлээх хариуцлагыг тодорхой эзэнтэй болгож хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна.

3.ИТХ, гүйцэтгэх засаглал, иргэд бүгдээрээ 2010 оныг “Байгаль орчин - бидний орон гэр, хөгжил тулгуур” уриан дор үйл ажиллагаагаа зохион байгуулж, байгалийн баялгийг зөв зохистой ашиглан амьдрал ахуйгаа дээшлүүлэн, цэцэглэн хөгжихийн үндсэн нөхцөл болсон газар нутаг, онгон эх байгалиа унаган төрхөөр нь хадгалан, баялгийг нь хамгаалж зүй зохистой ашиглуулах, нөхөн сэргээх, зарим газар нутгуудыг улсын боон орон нутгийн тусгай хамгаалалт, хэрэгцээнд авах, байгаль хамгаалахад иргэд, тэдний хамтын байгууллагын оролцоог нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулж ажиллах жил болгоё. Өөрөөр хэлбэл 2010 он **“Байгаль орчин – тогтвортой хөгжил”**-ийг дэмжих жил байх болно.

4.Сүүлийн жилүүдэд малын тоо толгой өсөж, тэр тусмаа сүрэгт эзлэх ямааны жин хэт ихэссэнтэй холбогдуулж бэлчээрийн даац хүрэлцэхгүй, хур бороо орохгүйгээс үр шимтэй өвс ургамлын гарц муудаж, ган гачиг их тохиолдох давтамж ойртсоноос болж малчид мал сүргээ өсгөн үржүүлэх уламжлалт арга ажиллагаа хүндрэлтэй тулгараад байна. Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйгаа эрхэмлэн малын чанарт биш тоонд анхаарч өсгөж үржүүлэхийн төлөө өдөр, шөнийг умартан нойр хоолгүй зүтгэж амьдрах уу, байгаль цаг уурт дасан зохицсон ашиг шим арвин эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж байгальдаа захирагдах биш, байгалийн хур шим, өвс ургамлыг өөрийн арга ухаан, хөдөлмөрийн үр шимээрээ бий болгож бие, сэтгэл тэнүүн хоршиж амьдрах асуудлыг бид хэлэх биш бодит ажил болгох цаг нэгэнт ирсэн байна.

Аймгийн хэмжээнд үлгэр жишээ суурин, эрчимжсэн мал аж ахуйг бий болгож, түүнийг түшиглэн туршлага судлуулах, сургаж дадлагажуулан малчдын аж ахуй, үр ашгийг дээшлүүлэх асуудлыг нэн тэргүүнд хийж гүйцэтгэх хэрэгтэй байна.

5.Мал сүргийг хашаажуулах, энгийн уурхайн худаг гаргах, булаг шанд тохижуулах өндөр уулын бүсэд орон нутгийн авто зам гаргах, бэлчээрийн болон хүн амын усан хангамжийг сайжруулах, хадлан тариалангийн талбайг нэмэгдүүлж, мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн боловсруулах, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээ, гэрээгээр өвөлжөө хаваржаа гаргах, эзэмшүүлэх, зам засах, хадлан бордоо бэлтгэх хувцас гутал, гэрийн бүрээс оёх, орон сууцны барилга барих, мал маллах, төллүүлэх, сүү сааль эрхлэх, ноос арьс суран эдлэл, тоноглол үйлдвэрлэх, оторчдын хоол хүнс бэлтгэх чиглэлээр өрхийн үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх, мэргэжсэн үйлчилгээ үйлдвэрлэл эрхлэгчийг сургаж дадлагажуулах замаар өөрөө өөрийн амьдралыг тэтгэгч ажилгүйдэл ядуурлаас ангижрахын төлөө эрчимтэй ажиллах жил болгоё.

“Монгол улсын иргэн бүр айл, өрх, сум, суурин бүхэлдээ тулгамдсан асуудлаа шийддэг, тийм шийдэлд бүтээлч оролцогч нь байж чаддаг болж байж л Монгол улс бүхэлдээ хөгжил дэвшилд хүрнэ, Монголын хөгжил дэвшил бол Монголын төрийн төлөвлөгөө, хөтөлбөрөөс биш Монгол хүн бүрийн зорилго, төлөвлөгөөнөөс хамаарна. Ядуу хүн, айл өрх бүр ядуурлаас гарах төлөвлөгөөтэй байх ёстой. Ажилгүй нь ажилтай болох, ажилтай нь

бүтээмжээ улам нэмэгдүүлэх зорилго тавих ёстой. Ингэж л байж Монголын хөгжил бүтэн болж, нийгмийн эв зохис бүрэлдэж чадна” гэж Монгол улсын төрийн тэргүүн Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслол дээр хэлсэн үгэндээ дурдсан билээ. Бид, иргэн бүр ийм л зорилго, тэмүүлэлтэй байж өөрөө өөрийгөө хөгжүүлж, өөрөө өөрийгөө ядуурлаас гаргах болно, бүгдийг дээрээс харж, алгаа тосож, хэн надад ямар халамж, ямар мөнгө өгөх бол гэж зүгээр суухын оронд би өөрөө юу хийж чадах вэ ямар ажил хийх вэ, яаж мөнгө олох вэ гэдгийг эрэлхийлж, түүнийгээ ажил хэрэг болгох нь чухал байх болно.

6.Төрийн сонгуулиар итгэл хүлээж сонгогчдын олонхын санал авч сум, аймгийн хуралд төрийн түшээгээр сонгогдсон төлөөлөгчийн үйл ажиллагааг сайжруулах нь нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг дээшлүүлэх амин сүнс нь билээ. Итгэл өгч сонгосон боловсон хүчин та биднээс ард түмний хүлээлт, амьдралын тулгамдаж буй асуудал бүрийг шийдэх үүрэг өдөр тутам нэмэгдэж байгаа гэдэгт байнга дүгнэлт хийж ажиллах хэрэгтэй. Хүндээ ойртож, иргэддээ хүрч тэдний санал хүсэлтийг байнга сонсож, үнэтэй санал зөвлөгөөг нь ажил хэрэг болгож ажиллах нь төрийн алба хашиж байгаа хэн бүхний үүрэг билээ. Төрийн ажил бол хүний төлөөх үйлчилгээ гэдгийг хором төдий ч мартаж болохгүй. Тэр тусмаа иргэн бүрийг ажилтай, өрх бүрийг амьжиргаатай болгоход нөөцөө дайчлан ажиллая.

Иргэдээ ажил, хөдөлмөр, амьдралын баталгаа, аюулгүй байдлыг бүрэн хангаж чадахгүй, бас шаардуулж байгаа нь аймаг, орон нутгийг удирдаж байгаа та бидний ажлын дутагдал бөгөөд үүний бурууг бусад руу, эдийн засгийн хямрал руу эсвэл бие бие рүүгээ түлхэх бус гагцхүү аймаг орон нутгийнхаа хөгжил цэцэглэлт, ард иргэдийнхээ хүсэн хүлээж буй амьдралын нөхцөлийг бий болгохын төлөө хамтран бүхий л хүч бололцоогоо дайчлан, санаачилгатай ажиллахыг иргэд маань та бидэнд үүрэг болгож, үр дүнг хүлээж байна.

7.Багийн ИНХ-уудыг батлагдсан дэгийнхээ дагуу хэлэлцэх асуудлыг иргэд өөрсдөө сонгон хэлэлцэх түүний бэлтгэлийг тэргүүлэгчид, Засаг дарга хангадаг, сумын ИТХ-ын тэргүүлэгчид, Засаг даргын Тамгын газар, уг багаас сонгогдсон аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчид, шеф албан газар, ТББ-уудын туслалцаа дэмжлэгтэйгээр багийн тулгамдсан асуудал /тухайлбал: өвөлжөө, хаваржаа, 4 улирлын бэлчээрийн хуваарь, мал эрүүлжүүлэх, таваарлаг үржлийн мал өсгөх, сүргийн бүтэц сайжруулах, сүргийн үйлдвэрлэлийн бүтэц сайжруулах, өрхийн үйлдвэрлэл хөгжүүлэх, хоршоо, малчдын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг сайжруулах аргаар ядуурлыг арилгах, хүний хөгжлийг хангах,тохижсон хот, айл, биеэ даагч өрх бүлийг нэмэгдүүлэх тухай/ хэлэлцэж 2010 оныг багийн ИНХ-ыг төгөлдөржүүлэх жил болгон өөрчлөн шинэчилье.

8.Сумын ИТХ үйл ажиллагааны үндсэн чиглэлээ биелүүлэхийн тулд эдийн засаг, нийгмийн хөгжилтэй уялдсан хөгжлийн тулгамдсан асуудлыг сонгож хэлэлцэн оновчтой шийдвэр гаргахад иргэдийн оролцоо, идэвхийг өрнүүлж, үйл ажиллагаа, шийдвэрээ байнга сурталчлан нээлттэй ил тод байдлыг хэрэгжүүлэх он болгоё. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид

ажлаа болон шийдвэрээ ил тавьж мэдээлэхийн сацуу улирал бүр ажлаа нийт иргэдэд мэдээлдэг болох, тэргүүлэгчид, төлөөлөгчид, багийн ИНХ-ын ажлыг оновчтой үзүүлэлтээр амлалт үүргийн биелэлтийн хамт зэрэгцүүлэн дүгнэж, төлөөлөгчид тойргийн сонгогчдын гүнд орж, ажил амьдралтай нь танилцахын зэрэгцээ төр засаг, орон нутгийн бодлогыг сурталчлан тайлбарлагч болцгооё. Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчид, тэргүүлэгчид улс төржихөөс илүүтэй иргэдийн болон цаг үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн төлөө үзэл бодлоо уралдуулж ажиллахын хамт хөгжлийн хэтийн бодлоготой холбоотой ажил, асуудлыг хэлэлцэхэд голлон анхаарвал зохилтой. Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд жилд 2-оос доошгүй удаа мониторинг үнэлгээ өгч хамтран ажиллах, орон нутгийнхаа онцлог, бэрхшээлийг судалж, цаашид өөрчлөн сайжруулах бодлого чиглэлийг боловсруулан ажиллах нь хурлын үйл ажиллагааны шинэчлэлийн нэг чиглэл байх болно.

9. Аймаг, сумын ИТХ-ын онцгой эрхэд хамаарах төсвийн орлого санхүүжилтийн бодлого үйл ажиллагааг өөрчилж батлагдсан санхүүгийн нөөц /орлого, санхүүгийн дэмжлэг/ - д багтаан тухайн жилийн хөгжлийн бодлогоо хэрэгжүүлж сахилгажуулах жил болгоё.

Үр ашиг багатай илүү зарцуулалтыг тэтгэж нэмэгдэл санхүүжилт авах хандлага үзэл бодол, практик үйл ажиллагаанаас татгалзах нь аймаг, сум, өөрийгөө санхүүжүүлэх чадавхыг дээшлүүлэх зорилттой уялдаж байна. Үүний тулд ажлын байр нэмэгдүүлэх замаар иргэдийн орлогын баазыг өргөтгөх өргөн боломж байгааг оновчтой зохион байгуулбал зохино. Орлогын тоо төлөвлөгөө бүхэн хэрэгжүүлэх эзэн хугацаатай байхын дээр санхүүжилтийн талаар аймгийн Аудитын газар, Мэргэжлийн Хяналтын Газрын шалгалт үзлэгээр илэрсэн зөрчил ирэх онд давтагдах учиргүй бөгөөд хуулиас гадуур иргэд, байгууллагаас татвар, хураамж, үйлдвэрлэл, үйлчилгээний өртөг, чанарын үнэлгээнээс давсан үнэ авдаг, үр ашиггүй зүйлд төрийн сан хөмрөгийг зарцуулдаг газар, байгууллагын албан тушаалтнууд бохир бодол, урт гар, явуургүй ажиллагааг эцэс болгохыг анхааруулж байна. Төрийг хуурч мэхлэхийг хичээгчдийн явах зам, хугацаа богиносгож байгааг сануулж, хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулахыг ард иргэд шаардаж, хариуцлагын тогтолцоог бүх шатанд сайжруулахыг хүлээж байна.

Төрийн албаны иргэдэд хүргэх үйлчилгээ нээлттэй, ил тод, шуурхай, хуулийн хүрээнд, шударга байх зарчмыг төрийн алба, албан хаагч бүрийн өдөр тутмын гүйцэтгэж буй ажилд хэрэгжүүлж, дэвшүүлсэн зорилт, хүрсэн үр дүнг нь бодиттой үнэлж, хариуцлага тооцох тогтолцоо нь биеллээ олох шаардлагатай байна.

10. Шүүх, прокурор, цагдаа зэрэг хууль хяналтын байгууллагууд өөрийн хариуцсан ажлаа чанартай, шударга гүйцэтгэж, хаана дэг журамтай байна тэнд ард иргэд амгалан тайван аж төрж, хөдөлмөрлөнө гэдгийг үндэслэн санаачилгатай ажиллахыг тэмдэглэсэн байна.

Аймгийн ИТХ-ын нутгийн удирдлага, хүний эрх, хууль зүйн байнгын хороогоор дээрхи илтгэлийг хэлэлцээд 2009 онд хэрэгжүүлсэн ажлын дүнг хангалттай гэж дүгнээд аймаг, сум багийн хурлын ажлыг идэвхижүүлэн иргэдийн оролцоотой үнэлж дүгнэх, төлөөлөгчдийн тойрогтоо ажиллах нөхцөлийг бүрдүүлж дэмжлэг үзүүлэх, сумдад хуралдааны танхимыг чөлөөт цагт эрх зүйн танхим болгон ашиглах, Такешкен боомтод хүний эрх зөрчигдөж байгааг хамгаалах, хөрөнгө оруулалтын тендерийн шударга явуулж, гүйцэтгэгчийн хариуцлагыг өндөржүүлэх зэрэг ажилд анхаараалаа хандуулж хэрэгжүүлж ажиллахыг санал болгосон байна.

Хуралдаан “Хурлын байгууллагын ажлын үр нөлөөг дээшлүүлэх тухай” тогтоолыг баталсан байна.

“Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2009 оны биелэлт аймгийн эдийн засаг нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн тухай” аймгийн Засаг дарга Г.Нямдаваа итгэлдээ 4 бүлэг 48 дэд хэсэг 256 асуудал бүхий аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн үйлдвэрлэл дэд бүтэц, хүнс ХАА, байгаль орчны бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилт 29,8 хувь, нийгмийн бодлогын хүрээнд 32,1 хувь, санхүү эдийн засгийн бодлогын хүрээнд 29,1 хувь, төрийн байгуулалт, эрх зүйн хүрээнд 32,7 хувиар биелж 2009 оны дүнгээр 31,0 хувийн биелэлттэй байна.

Төрийн албан хаагчдын баримтлах 9 зарчмыг баталж мөрдсөнөөр төрийн ажлын үйлчилгээг сайжруулах, шударга байдлыг бий болгох нөхцөлийг бүрдүүллээ.

Нийгмийн бодлогын хүрээнд оюунлаг Ховд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэн Алтай, Зэрэг, Чандмань, Эрдэнэбүрэн сумын соёлын төв, Дарви сумын цэцэрлэг, Жаргалант сумын 6,8 дугаар цэцэрлэгийн өргөтгөл, Буянт өрхийн эмнэлгийн өргөтгөл, Усан спортын төвийг ашиглалтанд оруулж Ховд, Дөргөн сумын эмнэлэг, Эрдэнэбүрэн, Дуут, Булган, ХААИС-ийн дотуур байр, ХоИС-ийн хичээлийн байр, Хөгжил МСҮТ-ийн хичээл дадлагын байр зэрэг 25 барилгад их засвар хийж Жаргалант суманд 50 ортой эмнэлгийн барилга, 320 хүүхдийн суудалтай хичээлийн байр, Мөст сумын 520 хүүхдийн суудалтай хичээлийн байр, Ахмадын ордон, Зэрэг сумын дотуур байр, Баруун бүсийн хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэнгийн барилгуудын ажил эхлүүлсэн байна.

ЕБС-ийг 12 жилийн сургалтын хөтөлбөрт шилжих хөтөлбөрөөр 1,2,7 дугаар ангийн хүүхдүүдийг сургаж сургалтын нөхцөлийг сайжруулсанаар сургуулийн насны хүүхдүүдийн хамран сургалт 95,6 хувьд хүрсэн байна.

Нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн зорилтын хүрээнд 10 сумыг 2-оос дээш эмчтэй болгож нийт 569 ор ашиглаж 350,0 мянган хүнд үзлэг хийж, 11719 хүн хэвтэж эмчлүүлсэн байна. Халдварт өвчний 370 тохиолдол бүртгэгдэж өмнөх жилээс 33,8 хувиар буурсан байна.

Ажил идэвхитэй эрж байгаа 2100 хүнийг бүртгэн 2088 хүнийг ажлын байраар хангасанаас 1342 хүн шинэ ажлын байраар хангагдсан байна.

2009 онд орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 167,4 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10,0 тэрбум төгрөг, зээл, тусламж, төсөл хөтөлбөрөөр 1,4 тэрбум төгрөг, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 2,8 тэрбум төгрөг нийт 15,8 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлжээ.

2009 оныг “Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил”-ийн хүрээнд Манхан-Мөстийн 35 квт-ын ЦДАШ дэд станц, БНХАУ-ын Такашкен боомтоос Монгол Улсын хил хүртэлх 18 км, улсын хилээс Булган сум хүртэлх 45 км 35 квт-ын ЦДАШ дэд станцыг байгуулж Дөргөний УЦС-ыг ашиглалтанд оруулсан байна. Хөшөөтийн уурхайн 345,7 км зам тавих ажиллагаа үргэлжилж нийт хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн 80,0 хувийг дэд бүтцийн салбарт зориулж зарцуулсан байна.

2008 оны гүйцэтгэлээр 115,1 тэрбум төгрөгийн дотоодын нийт бүтээгдхүүн үйлдвэрлэж нэг хүнд 1286,6 мянган төгрөг оногдож байна.

Үйлдвэрлэлийг дэмжиж нийт 86 төсөл арга хэмжээнд 856,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна.

Мал аж ахуйд салбарт 2230,5 мянган мал тоологдож халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 2,5 сая мал, паразит өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 1296,8 мянган малыг хамааруулан бэлчээрийн усан хангамжийг сайжруулахаар 17 худагийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр гаргажээ.

Газар тариалангийн салбарт 2796 га талбайд тариалалт хийж үр тариа 1008,7 тн, төмс 8503,6 тн, хүнсний ногоо 6985,2 тн тэжээлийн ургамал 1657,5 тн нийт 18,7 мянган тн ургац хураасан байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2009 онд дэвшүүлсэн 129 зорилт арга хэмжээний биелэлт 84,6 хувийн биелэлттэй хэрэгжсэн байна.

2010 онд ЕБС-ийн хамралтын хувийг 97,5 хувьд, сургалтын стандарт хангалтыг 98,5 хувьд, сургуулийн өмнөх боловсрол олголтын хамралтыг 75,0 хувьд туус тус хүргэж Мөст суманд 520 хүүхдийн, Зэрэг суманд сургуулийн дотуур байр, Жаргалант суманд 320 хүүхдийн бага сургуулийг ашиглалтанд оруулж аймгийн төвд 960 хүүхдийн сургуулийн барилгыг эхлүүлэх, 1600-аас доошгүй түр болон бүр ажлын байрыг бий болгох, жижиг дунд үйлдвэрлэлийн сангаас 1,0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож нэг хүнд ногдох ДНБ-ийг 1500 төгрөгт хүргэх, аймгийн төвд 2 км хатуу хучилттай зам тавьж Манхан-Ховдын чиглэлийн 80 км хатуу хучилттай замын ажлыг эхлүүлж Хөшөөтийн замын ажлыг үргэлжлүүлэх, 100 айлын орон сууц барих, Буянт суманд усны алдагдлыг бууруулах 11,6 км суваг татах зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн тухай илтгэлдээ тэмдэглэсэн байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн дүнг аймгийн ИТХ дахь МАХН-ын бүлэг хэлэлцээд 2009 онд дэвшүүлсэн зорилтыг хангалттай хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн ба цаашид төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлэх, ажилгүйдэл,

ядууралыг бууруулах, байгалийн баялагийн ашиглалтыг сайжруулан ашиглагчидтай гэрээ байгуулах, мал аж ахуйн болон газар тариалангийн салбарт эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэхэд анхаарах шаардлагатайг тэмдэглэжээ.

Мөн Ардчилсан намаас авилга, ажилгүйдэл, ядууралын түвшин өндөр байгаа, мал аж ахуйн түүхий эдийн үнэ ханш, унаж малчдын мал банкны барьцаанд орсон, төрийн удирдах албан тушаалтануудаас үүдэлтэй төрийн ажлын шударга байдал алдагдсан, төрийн албаны шударга өрсөлдөөн үгүй болж шалгалтыг шударга бус авдаг болсон, хөрөнгө оруулалтын тендер шалгаруулалт шударга бус, эмнэлгийн үйлчилгээ доголдолтой зэргийг үндэслэн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хангалтгүй хэрэгжиж байна гэж дүгнэж байгааг хуралдаанд танилцуулсан байна.

Хуралдаан “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2009 оны биелэлтэд үнэлэлт өгөх тухай” 4/09 тогтоолоор аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2009 онд хэрэгжүүлсэн ажлыг хангалттай гэж дүгнэж 2010 оныг “Байгаль орчин-тогтвортой хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж тодорхой зорилтуудыг дэвшүүлэн түүнийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасан байна.

“Аймгийн төсвийн 2009 оны урьдчилсан гүйцэтгэл, 2010 оны төсөл, 2008 оны гүйцэтгэлийн тухай” аймгийн Засаг даргын тамгын газрын санхүү эдийн засаг бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Д.Алтангэрэл илтгэлдээ ...Тайлант жилд татвар төлөгчдийн тоо 1975 татвар төлөгчөөр нэмэгдэж нийт 14884-д хүрч, татвар төлөлтийн ажиллагаанд ахиц гарсан, байгууллагуудын нягтлан бодох хүртгэлийн хөтөлөлт сайжирч санхүүгийн сахилга дээшилсэнээр санхүүгийн салбарт хямралттай байгаа ч гэсэн дэвшүүлсэн зорилдтууд хэрэгжиж хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр орон нутгийн төсөвт 2,3 тэрбум төгрөг оруулахаас 2,6 тэрбум төгрөг оруулж орон нутгийн зарлагаар 3,7 тэрбум төгрөг, улсын төсвийн байгууллагуудын зарлага 19,6 тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүлсэн байна.

2010 онд бүх шатанд санхүүгийн сахилгыг бэхжүүлсэнээр орон нутгийн нийт орлогоор 4,2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх үүнээс татварын орлогоор 2,6 тэрбум төгрөг, нийт зардлыг 25,8 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн болон 2008 оны төсвийн гүйцэтгэлийг орлогыг 1,3 тэрбум төгрөг, зарлагыг 4,5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгааг илтгэсэн байна.

“Аймгийн аудитын газрын 2009 оны ажлын тайлан, орон нутгийн 2010 оны төсвийн төсөлд төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж орлого нэмэгдүүлэх талаар өгөх саналын тухай” аймгийн Ерөнхий аудитор Ч.Цэрэнчимэд илтгэлдээ 153 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулсанаар 42,5 хувь буюу 65 тайлан “Зөрчилгүй” стандарт, 52,3 хувь буюу 80 тайлан “Хязгаарлалттай санал дүгнэлт”, 4,6 хувь буюу 7 тайлан нь “Сөрөг санал дүгнэлт”, 0,6 хувь буюу 1 тайлан нь “Дүгнэлт өгөхөөс татгалзсан” тус тус дүгнэлт өгсөн байна. Санхүүгийн тайлангийн аудитад хамаарагдсан 153 байгууллагын дүнгээр 3205,6 сая

төгрөгийн алдаа илэрүүлсэнээс 25,5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 82,9 сая төгрөгийн авлага, 20,7 сая төгрөгийн бараа материал, 522,9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 11,4 сая төгрөгийн өр төлбөр, 677,6 сая төгрөгийн өмчийн дансдын гүйлгээг, төсвийн урсгал орлогыг 173,4 сая төгрөг, зарлагыг 353,5 сая төгрөгөөр илүү буюу дутуу дүнгээр илэрхийлсэнээс тайлангийн үеийн үр дүн буюу төсвийн ашиг, алдагдал 913,9 сая төгрөгөөр буруу тооцогдсон байна.

Тус онд 7 сум 39 байгууллага, 4 орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийж 671,7 сая төгрөгийн зөрчил төлбөр илрүүлсэнээс 80,0 сая төгрөг нь төлбөр, 591,7 сая төгрөг нь зөрчил байсаныг тайландаа дурдаад 2010 онд орон нутгийн орлогыг 34,9 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн үр ашиг, арвилан хэмнэлтийг 183,8 сая төгрөгөөр сайжруулах бололцоотой байна гэсэн санал дүгнэлтийг оруулсан байна.

Дээрхи 2 итгэлийг төсөв, санхүү эдийн засгийн бодлогын байнгын хэсгээс хэлэлцэж орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх нөөц бололцоог дүүрэн ашиглах, хөрөнгө оруулалтын зарлах, үнэлэх, хүлээн авах ажлын хэсгийг салгаж иргэний нийгмийн төлөөлөлийг оролцуулах, санхүүгийн сахилга зөрчсөн төсөв захирагчид, нягтлан бодогч нарт хатуу хариуцлага тооцох, Хөшөөтийн уурхайн орон нутгийн түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан төлбөрийг бүрэн тооцож авах, тодорхой зориулалттай сангуудын хөрөнгийг эргэлтэнд оруулж үр ашгийг дээшлүүлэх, түгээмэл тархацтай баялагийн орлогыг тусгай санд төвлөрүүлэн аймаг орон нутгийн хөгжилд тусгайлан зарцуулах тухай саналыг хуралдаанд оруулсан байна.

Хуралдаан “Орон нутгийн 2009 оны тодотгосон төсөвт өөрчлөлт оруулах тухай” 4/11 тогтоолоор төсвийн нийт орлогыг 306,5 сая төгрөгөөр, зарлагыг 253,0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж “Орон нутгийн 2010 оны төсөв батлах тухай” 4/13 тогтоолоор аймгийн 2006 оны төсвийн орлогын доод хязгаарыг 2869,2 сая төгрөгөөр үүнээс татварын орлогыг 2593,5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 4185,1 сая төгрөгөөр, сумдын төсвийн орлогын доод хязгаарыг 1551,9 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэгийг 1206,6 сая төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 70,2 сая төгрөгөөр баталжээ.

Мөн 4/14 дүгээр тогтоолоор эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Засаг даргатай 2010 онд нийлүүлэх бүтээгдхүүний санхүүжилтийн 21565,7 сая төгрөгийг сайшаан дэмжсэн байна.

Хуралдааны “Тайланд үнэлэлт өгч санал дэмжих тухай” 4/16 тоот тогтоолоор “Аймгийн ИТХ-ын эдийн засгийн хорооны дүгнэлт, төлөөлөгчдийн саналыг үндэслэн аймгийн Аудитын газрыг 2009 онд хууль эрх зүйн хүрээнд ажил хэргээ “Хангалттай сайн биелүүлсэн” гэж дүгнэж 2010 оны орон нутгийн төсвийн орлогыг 34,9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, зардлын үр ашгийг 183,8 сая төгрөгөөр сайжруулсаныг дэмжсэн байна.

“Газар зохион байгуулалтын 2009 оны ажлын дүн, иргэдэд газар өмчлүүлэх болон газар зохион байгуулалтын 2010 оны төлөвлөгөөний тухай” аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Д.Баатарсүрэн илтгэлдээ ... аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2008 онд, бусад сумуудын төвийн кадастрийн зураглалыг 2009 онд зохих мэргэжлийн байгууллагуудаар хийлгэж 2009 онд 5829 иргэнд 889,91 га газрыг үнэгүйгээр, 1 иргэнд 0,2 га газрыг тариалангийн зориулалтаар худалдаж өмчлүүлээд байна.

2010 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ 3364,08 га, үүнээс гэр бүлийн хэрэгцээнд 163,87 га, гэрээгээр авто гражийн газар 0,72 га, газрыг элэгдэл, эвдрэл, доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх газар 1463,6 га, чацаргана тариалах зориулалтаар эзэмшүүлэх 249,5 га, эрчимжсэн мал аж ахуйн зориулалтаар 412,5 га, шинээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх 2485,391 га, газрыг байршил, хэмжээ зориулалтаар төлөвлөгөөнд тусгуулах санал оруулсан байна.

Тус илтгэлтэй холбогдуулан үйлдвэрлэл дэд бүтэц, хот байгуулалтын хорооноос аймгийн төвд газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу зохион байгуулалт хийх, кадастрийн зураглалтай болгох, газрын зөрчил бүхий газрыг цэгцлэх, газрын нэгдмэл сангийн тооллогыг хийх, газрын албаныг мэргэжлийн боловсон хүчээр бэхжүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх, газрын төлбөрийг бүрэн ногдуулж хураах, аймгийн төвд аймгийн Засаг дарга болон сумын Засаг даргын мэдлийн газрын хил заагийг тогтоож мөрдөх зэрэг саналыг хуралдаанд оруулжээ.

Хуралдаан илтгэлийг хэлэлцээд 4/17 дугаар тогтоолоор газар зохион байгуулалтын 2010 оны төлөвлөгөөнд иргэнд өмчлүүлэх газрыг 163,87 га, гэрээгээр авто гражийн газар 0,72 га, газрыг элэгдэл, эвдрэл, доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх газар 1463,6 га, чацаргана тариалах зориулалтаар эзэмшүүлэх 249,5 га, эрчимжсэн мал аж ахуйн зориулалтаар 412,5 га, шинээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх 2485,391 га, газар байхаар, 2010 оныг газрын зөрчил маргааныг арилгах жил болгохоор баталжээ.

Аймгийн ИТХ-ын 4 дүгээр хуралдаанд нийт 25 төлөөлөгчийн 19 буюу 76,0 хувь нь оролцож урилгаар 142 хүн оролцсоноос төсвийн байгууллагын ажилтан 125, иргэд 17 байгаа ба хуралдаанд 24 хүн үг хэлж, нийт 6 асуудал хэлэлцэн 18 тогтоол баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 5 дугаар хуралдаан

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 116 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын 5 дугаар хуралдааныг 2010 оны 6 дугаар сарын 30-ний өдөр хуралдуулж

- 1.Аймгийн ИТХ-ын 9,18 дугаар тойргийн сонгуулийн дүн, төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай
2. Зохион байгуулалтын асуудал

3. Бэлчээр ашиглалтын өнөөгийн байдалд хийх дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай илтгэл

4. Бэлчээрийг эрх зүйн болон эдийн засгийн хөшүүрэгээр зохицуулах арга замын тухай илтгэлүүдийг хэлэлцүүлэхээр зарласан байна.

Аймгийн ИТХ-ын 2010 оны 6 дугаар сарын 25-ний өдрийн хуралдааны “тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 169 дүгээр тогтоолоор “Аймгийн ИТХ-ын 5 дугаар хуралдааны тов зарлах тухай” 166 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж хэлэлцэх асуудлыг дараахь байдлаар баталсан байна. Үүнд:

1.Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчийг нөхөн сонгох сонгуулийн дүн, төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай

2. Аймгийн ИТХ-ын даргыг чөлөөлөх тухай

3. Аймгийн ИТХ-ын даргыг сонгох тухай

4. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг чөлөөлөх тухай

5. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчийг чөлөөлж, сонгох тухай

6. Бэлчээр ашиглалтын өнөөгийн байдалд хийх дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай илтгэл

7. Бэлчээрийг эрх зүйн болон эдийн засгийн хөшүүрэгээр зохицуулах арга замын тухай

8. Аймгийн 2010 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай илтгэлүүдийг хэлэлцүүлэхээр зарласан байна

Хуралдаанд аймгийн ИТХ-ын дарга О.Ширэндэв эрүүл мэндийн байдлын улмаас хуралдаан удирдах боломжгүй байгаа тул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч Т.Баярсайханаар удирдуулах санал болгосоноор шийдвэрлэн аймгийн ИТХ-ын 2004 оны 2 дугаар хуралдаанаас баталсан дэгийг мөрдөж ажлын албаны нарийн бичгийн даргаар Б.Сандагсүрэн аймгийн ИТХ-ын Ажлын албаны ажилтан, У.Цэрэнтогтох, Ч.Улаанхүү, Г.Пүрэвганди аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн түшмэл, редакцийн комиссоор Ч.Цэрэнчимэд аймгийн Ерөнхий аудитор, Б.Шоовдой Ховдын мэдээ сонины ажилтан, тэмдэглэл хөтлөгчөөр Б.Энхтуяа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны ахлах ажилтан нар ажилласан байна.

Хуралдаанаас гарах тогтоол шийдвэрийн ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Багдалаар ахлуулан 11 хүний бүрэлдхүүнтэй байгуулжээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, аймгийн Сонгуулийн хорооны дарга Ч.Багдал “Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг нөхөн сонгох сонгуулийн дүн, төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай” илтгэлдээ... Орон нутгийн Хурлыг сонгох 2008 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдан бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа аймгийн ИТХ-ын 9 /Мөст сум/, 18 /Жаргалант сум 3 баг/ дугаар тойрогуудад нөхөн сонгууль явуулах эрх зүйн орчин үүсч аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 4 дүгээр сарын

15-ны өдрийн 66 дугаар тогтоолоор төлөөлөгчийг нөхөн сонгох сонгуулийг 2010 оны 5 дугаар сарын 2-ний өдрийн “ням” гаригт явуулахаар товийг зарлаж сонгуулийн бэлтгэл ажлыг хангаж зохион байгуулж 2 сумын сонгуулийн хороодыг байгуулж хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр олон нийтэд мэдээлэн 2 сумын сонгуулийн хороонд 10 хүн, 8 хэсгийн хороонд 54 хүн тус тус ажиллажээ.

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох нөхөн сонгуулийн 9 дугаар тойргийн сонгогчдын нэрийн жагсаалтад нийт 1741 сонгогч бүртгэгдсэнээс 1341 сонгогч буюу 77.2 хувь нь, 18 дугаар тойргийн сонгогчдын нэрийн жагсаалтад нийт 2688 сонгогч бүртгэгдсэнээс 1847 сонгогч буюу 68.71 хувь нь санал хураалтад тус тус оролцсон байна.

Санал хураалтаар нийт сонгогчдын 9 дүгээр тойрогт МАХНамаас нэр дэвшигч Ш.Батсүхийн төлөө 892 сонгогч буюу 67.0 хувь, Ардчилсан намаас нэр дэвшигч З.Лувсангийн төлөө 442 сонгогч буюу 33.0 хувь, 18 дугаар тойрогт МАХНамаас нэр дэвшигч Д. Мөнхзулын төлөө 1096 сонгогч буюу 60.58 хувь, Ардчилсан намаас нэр дэвшигч М.Амарсанаагийн төлөө 707 сонгогч буюу 39.8 хувь нь тус тус санал өгсөн байна.

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг нөхөн сонгох сонгуулийн дүнгээр санал хураалтанд оролцсон сонгогчдын олонхийн буюу 9 дүгээр тойрогт 67.0 хувийн санал авсан МАХНамаас нэр дэвшигч Шагдар овогтой Батсүх, 18 дугаар тойрогт 60.58 хувийн санал авсан МАХНамаас нэр дэвшигч Даваажанцан овогтой Мөнхзул нарыг аймгийн ИТХурлын төлөөлөгчөөр сонгогдсонд тооцож, төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх саналыг хуралдаанд оруулж байгааг тэмдэглэсэн байна.

Хуралдааны “Төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай” 5/02 дугаар тогтоолоор Ш.Батсүхийн, 5/03 дугаар тогтоолоор Д.Мөнхзулын төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрсөн байна.

Хуралдаанд эрүүл мэндийн улмаас ИТХ-ын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай аймгийн ИТХ-ын дарга О.Ширэндэвийн ирүүлсэн хүсэлтийг хэлэлцэж 5/04 дугаар тогтоолоор чөлөөлж тогтоолд түүний аймаг, орон нутгийн хөгжлийг хангах, НӨУБ-ыг төлөвшүүлэхэд өөрийн авьяас билиг, оюун ухаанаа зориулж үр бүтээлтэй ажиллаж байсныг тэмдэглэж зохих эмчилгээний зардлын тусламж дэмжлэг үзүүлэхийг Тэргүүлэгчдэд даалгасан байна.

Аймгийн ИТХ-ын даргыг сонгохтой холбогдуулан ИТХ-д суудалтай МАХН, АН-ын бүлгүүд завсарлага авч хуралдаан үргэлжилж АН-аас нэр дэвшүүлэхгүй байхаар шийдвэрлэн МАХН-аас Халтай овогтой Батболдын нэрийг дэвшүүлсэнийг хуралдаанд танилцуулсан байна.

Аймгийн ИТХ-ын даргыг сонгох тооллогын комиссыг төлөөлөгч Д.Түмэндэмбэрэлээр ахлуулан төлөөлөгч Ч.Чинбат, Б.Ганзориг нарыг оролцуулан байгуулж ажиллуулжээ.

Тооллогын комиссын “Санал авсан дүнгийн тухай” 01 тогтоолоор нийт 30 төлөөлөгч санал хураалтанд оролцсоноос 24 буюу 80,0 хувь нь Х.Батболдын төлөө санал өгсөнөөр аймгийн ИТХ-ын даргаар сонгогдсонд тооцож хуралдаанд танилцуулан хуралдааны 5/06 дугаар тогтоолоор Х.Батболдыг аймгийн ИТХ-ын даргаар сонгосон байна.

Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч Ч.Болд амьдралын шаардлагаар Улаанбаатар хотод гэр бүлээрээ шилжиж төрийн тусгай албанд ажиллах болсон тул аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгчээс чөлөөлж өгөх хүсэлтийг ирүүлсэнийг хэлэлцэн 5/07 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөс, 5/08 дугаар тогтоолоор Тэргүүлэгчээс тус тус чөлөөлжээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийг сонгохоор МАХН-аас төлөөлөгч С.Батмөнх, А.Хишигсүрэн нарын, төлөөлөгч А.Батмөнх өөрийн нэрийг дэвшүүлсэнээр санал хураалт явуулж санал хураалтанд оролцсон 28 төлөөлөгчийн 16 буюу 52,2 хувийн санал авсан А.Батмөнх, 14 буюу 51,8 хувийн санал авсан А.Хишигсүрэн нарыг аймгийн ИТХ-ын хуралдааны 5/09 дугаар тогтоолоор Тэргүүлэгчээр сонгосон байна.

“Бэлчээр ашиглалтын өнөөгийн байдалд хийх дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” аймгийн Засаг дарга Г.Нямдаваа илтгэлдээ ...хөдөөгийн ард иргэдийн амьдралын амин чухал асуудал бөгөөд бэлчээрийн менежментийн асуудлыг боловсронгуй болгох, зохистой ашиглах, хамгаалах асуудлыг 17 сум 62 багийн 1129 хүн хамаарагдсан хэлэлцүүлсэн байна.

Дэлхий дахинаа хурдацтай явагдаж буй цаг агаарын өөрчлөлтийн улмаас зуд болон байгалийн гамшигийн давтамж ойртож байгаа нөхцөлд хүний зохисгүй үйл ажиллагаанаас бэлчээр доройтож ургамалын биологийн төрөл зүйл цөөрч байна.

Тухайлбал сүүлийн 3 жилд 100 га хадлан, бэлчээрийн талбайд ноогдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 3 дахин нэмэгдсэн, 1990 онд нийт малын 29,3 хувийг ямаа эзэлж байсан бол 2009 оны байдлаар 55,7 хувь эзлэх болсон нь шууд нөлөөлөл болсон байна. Мөн бэлчээрийн ашиглалтанд усан хангамж нөлөөлж сүүлийн жилүүдэд 57 гол горхи, булаг шанд ширгэсэнээр ихээхэн хэмжээний ашиглалтгүй бэлчээрийг бий болгожээ. Бэлчээрийн дундач ургацаар тооцоход 1,8-2,2 сая мал багтах боломжтой байтал малын тоо 3,8 сая хонин толгойд хүрч хэтэрсэн байна.

Иймд цаашид бэлчээр ашиглалтыг улам боловсронгуй болгож хөдөөгийн малчин өрхийн амьдралын баталгааг тогтвортой байлгаж сайжруулах зорилгоор “Аймгийн бэлчээр ашиглалтын менежментийн дунд хугацааны төлөвлөгөө 2010-2012 “-ний төсөлийг хэлэлцүүлэхээр санал болгож байгааг тэмдэглэсэн байна.

“Бэлчээрийг эрх зүйн болон эдийн засгийн хөшүүрэгээр зохицуулах арга замын тухай” аймгийн ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч Д.Цэвээнравдан илтгэлдээ...Монгол орны нийт бэлчээрийн 70 орчим хувь нь доройтож цаашид сэргэхэд хүндрэл учирч улс орны хөгжилд

сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрч малчдын амьдрал, орлого улам бүр муудаж байна. Иймд бэлчээрийн тухай хуулиар бэлчээрийн төлбөр хураамж, сүргийн зохистой харьцааг хуульчлах шаардлагатай байна. Үүнд малыг бог малд шилжүүлсэнээр говийн бүсэд 5000 төгрөг, төвийн бүс нутагт 7500 төгрөгийн бэлчээрийн татварыг тогтоох, үүнийг улсын тусгай хамгаалалтын газар нутагт 2 дахин нэмэгдүүлэн тооцох, бэлчээрийн хураамжийг Улаанбаатар хотоос 50 км дотор 1,5, аймгийн төвөөс 15 км дотор бол 1,3, сумын төвөөс 5 км дотор байвал 1,2 гэсэн илтгэлцүүлээр нэмэгдүүлэн тооцох, 5 ам бүлтэй малчин өрхөөс богд шилжүүлсэнээр 500 бог малыг хураамжаас чөлөөлөх г.м саналуудыг дэвшүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны хорооноос “Бэлчээр ашиглалтын өнөөгийн байдалд хийх дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” илтгэлийг хэлэлцээд ... Бэлчээр ашиглалтын өнөөгийн байдалд хийх дүгнэлт цаашид анхаарах асуудлыг нийтийн оролцоотой хэлэлцсэн, мал сүргийн зохистой харьцааг тогтоох, малын тоо биш чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, мал аж ахуйг дэмжиж тэжээлийн үйлдвэр байгуулах, бэлчээрийг хот, айл, хэсэг бүлгээрээ эзэмшүүлэх, хил залгаа сумдын бэлчээр ашиглалтын маргааныг шийдвэрлэх, уул урхайн зам дагуух бэлчээрийн доройтолыг сэргээх, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хангах арга хэмжээг авах, малчдад суурин аж ахуйн давуу талын сургалт, сурталчилгааг зохион байгуулах зэрэг санал, дүгнэлтийг хуралдаанд оруулжээ.

Мөн эдийн засгийн байнгын хорооноос “Бэлчээрийг эрх зүйн болон эдийн засгийн хөшүүрэгээр зохицуулах арга замын тухай” илтгэлийг хэлэлцээд илтгэлд дэвшүүлсэн санааг дэмжих, татвар тогтоох эрхийг сумдын ИТХ, Засаг даргад олгох, аймаг, сумын хоорондын бэлчээр ашиглалтын зөрчилд хариуцлага хүлээлгэдэг болгох, сум, багт хадлангийн бүс тогтоох, мал аж ахуйн үйлдвэрлэлийг 240 хоног эрхэлдэг өрхийг малчин өрхөд тооцох, саналыг хуралдаанд оруулсан байна.

Хуралдааны 5/10 дугаар тогтоолоор “Аймгийн бэлчээр ашиглалтын менежментийн дунд хугацааны төлөвлөгөө /2010-2012/-г баталж, 5/11 дугаар тогтоолоор “Бэлчээрийг эрх зүйн болон эдийн засгийн хөшүүрэгээр зохицуулах арга замын тухай” илтгэлийг дэмжиж УИХ, Засгийн газарт уламжлан эрх зүйн зохицуулалт хийхэд санал болгохыг аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт даалгаж баталсан байна.

Аймгийн ГХБХБГ-ын дарга У.Батзаяа “Аймгийн 2010 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” илтгэлдээ .. иргэдэд газрыг гэр бүлийн зориулалтаар үнэгүй өмчлүүлэх ажлыг эрчимжүүлэх, бэлчээрийн зохион байгуулалтыг сайжруулах болон газар эзэмшил, ашиглалтын зөрчлийг арилгах зорилгоор 2010 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дараахь өөрчлөлт оруулахаар санал болгосон байна.

Үүнд:

1.Арьс ширний үйлдвэрийн цэвэрлэх байгууламж барихад 2,5 га газар

2. Өлөнгийн цехийг шилжүүлэн байгуулахад 0,08 га

3. тээвэр авто замын газрын хүн тээвэр үйлчилгээний зориулалтаар 0,08 га нийт 2,66 га газрыг баталуулах саналыг оруулсан байна.

Тус илтгэлийг аймгийн ИТХ-ын үйлдвэрлэл, дэд бүтэц, хот байгуулалтын хорооны хуралаар хэлэлцэж дэмжиж байгааг хуралдаанд оруулжээ.

Хуралдаан 5/12 дугаар тогтоолоор дээрхий 2,66 га газрыг 2010 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт болгон оруулж баталжээ.

Хуралдаан “Хороодын бүрэлдхүүнд өөрчлөлт оруулах тухай” 5/13 дугаар тогтоолоор нийгмийн бодлогын хороонд төлөөлөгч Ш.Батсүх, эдийн засгийн хороонд төлөөлөгч Д.Мөнхзул, Ш.Батсүх, үйлдвэрлэл, дэд бүтэц, хот байгуулалтын хороонд төлөөлөгч Д.Мөнхзул нарыг бүрэлдхүүнд оруулан баталжээ.

Хуралдааны төгсгөлд төлөөлөгч Д.Цагаанцоож дулааны “Бадамлах дөл” компаний асуудлыг хэлэлцэхээр санал гаргасаныг хуралдааны дэгийн дагуу боловсруулаагүй асуудал тул нийт төлөөлөгчдийн олонхийн саналаар хэлэлцэх боломжгүй гэж шийдвэрлэжээ.

Аймгийн ИТХ-ын 5 дугаар хуралдаанд нийт 31 төлөөлөгчийн 28 буюу 96,6 хувь нь оролцож урилгаар 69 хүн оролцсоноос төсвийн байгууллагын ажилтан 57, иргэд 12 байгаа ба хуралдаанд 25 хүн үг хэлж нийт 8 асуудал хэлэлцэн 13 тогтоол баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 6 дугаар хуралдаан

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 254 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын 6 дугаар хуралдааныг 2010 оны 12 дугаар сарын 23,24-ний өдөрүүдэд хуралдуулж

1. Орон нутгийн ИТХ-ын төлөөлөгчдийг нөхөн сонгох сонгуулийн дүн төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай

2. Аймгийн ИТХ-аас 2010 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан цаашдын зорилтын тухай илтгэл,

3. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2010 оны биелэлт, аймгийн эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн тухай илтгэл

4. Аймгийн төсвийн 2010 оны урьдчилсан гүйцэтгэл, 2011 оны төсөл, 2009 оны төсвийн гүйцэтгэлийн тухай илтгэл

5. Аймгийн Аудитын газрын 2010 оны ажлын тайлан, орон нутгийн 2011 оны төсвийн төсөлд төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж, орлого нэмэгдүүлэх талаар өгөх саналын тухай илтгэл

6. Аймгийн газар зохион байгуулалтын 2010 оны ажлын дүн, иргэнд газар өмчлүүлэх болон газар зохион байгуулалтын 2011 оны төлөвлөгөөний тухай илтгэлүүдийг хэлэлцүүлэхээр зарласан байна.

Аймгийн ИТХ-ын 2010 оны 12 дугаар сарын 8-ний өдрийн хуралдааны 256 дугаар тогтоолоор “23,24-ний өдөр” гэсэнийг “27,28-ний өдөр” гэж, төсвийн илтгэлийг “Аймгийн 2010 оны төсөвт оруулах нэмэлт өөрчлөлт, төсвийн жилийн урьдчилсан дүн, 2011 оны төсвийн төсөл, 2009 оны гүйцэтгэлийн тухай” гэж өөрчлөн найруулсан байна. Мөн Аймгийн ИТХ-ын 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны 263 дугаар тогтоолоор хэлэлцэх асуудлын 4 дүгээрт “Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татварын хэмжээг батлах тухай” асуудлыг хэлэлцүүлэхээр нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Хуралдаан аймгийн ИТХ-ын 2008 оны 2 дугаар хуралдаанаас баталсан дэгийн заалтыг мөрдөж хуралдаж ажлын албаны нарийн бичгийн даргаар аймгийн ИТХ-ын Ажлын албаны ажилтан Б.Сандагсүрэн, У.Цэрэнтогтох, Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн түшмэл Л.Оюунцэцэг, Хөгжлийн бодлогын хэлтсийн түшмэл П.Алтанхуяг, редакцийн комиссоор аймгийн Ерөнхий аудитор Ч.Цэрэнчимэд, Ховдын мэдээ сонины сурвалжлагч Б.Шоовдой, тэмдэглэл хөтлөгчөөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны ахлах ажилтан Б.Энхтуяа нар ажилласан байна.

Хуралдаанаас гарах тогтоол шийдвэрийн ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Багдалаар ахлуулан 14 хүний бүрэлдхүүнтэй байгуулжээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, аймгийн Сонгуулийн хорооны дарга Ч.Багдал “Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг нөхөн сонгох сонгуулийн дүн, төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай” илтгэлдээ ...Орон нутгийн Хурлыг сонгох 2008 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдан бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа аймгийн ИТХ-ын 10 /Мөнххайрхан сум/, 19 /Жаргалант сум Буянт, Цамбагарав, Магсаржав баг/ дүгээр тойрогуудад нөхөн сонгууль явуулах эрх зүйн орчин үүсч аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 172 дугаар тогтоолоор 10 дугаар тойргийн төлөөлөгчийг сонгох нөхөн сонгуулийг 2010 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр, 2010 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн 232 дугаар тогтоолоор 19 дүгээр тойргийн төлөөлөгчийг сонгох нөхөн сонгуулийг 2010 оны 11 дүгээр сарын 28-ний өдрийн “ням” гаригт тус тус явуулахаар нөхөн сонгуулийн товийг зарлаж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 232 дугаар тогтоолоор өмнөх орон нутгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох нөхөн сонгуулиар ажилласан 9 хүний бүрэлдэхүүнтэй аймгийн сонгуулийн хороог үргэлжлүүлэн ажиллуулахаар шийдвэрлэж Мөнххайрхан сумын сонгуулийн хороонд 5 хүн, 4 хэсгийн хороонд 36 хүн, Жаргалант сумын сонгуулийн хороонд 5 хүн, 3 хэсгийн хороонд 21 хүн тус тус намуудын төлөөлөлтэйгээр ажиллаа.

Мөнххайрхан сумын 10 тойрогт 1235 сонгогч бүртгэгдсэнээс 906 сонгогч буюу 73.3 хувь нь санал хураалтад оролцсон, Жаргалант сумын 19 дүгээр 3602 сонгогч бүртгэгдсэнээс 2592 сонгогч буюу 71.96 хувь нь санал хураалтад оролцсон байна.

Санал хураалтаар нийт сонгогчдын 10 дугаар тойрогт МАХН-аас нэр дэвшигч Х.Болдбаатарын төлөө 559 сонгогч буюу 62.32 хувь, Ардчилсан намаас нэр дэвшигч С.Бүрнээгийн төлөө 338 сонгогч буюу 37.68 хувь, 19 дугаар тойрогт МАН-аас нэр дэвшигч Ц.Бат-Эрдэнийн төлөө 1574 сонгогч буюу 61.68 хувь, Ардчилсан намаас нэр дэвшигч Б.Бат-Энэрэлийн төлөө 977 сонгогч буюу 38.29 хувь нь тус тус санал өгсөн бөгөөд сонгогчдын олонхийн буюу 10 дүгээр тойрогт 62.32 хувийн санал авсан МАХН-аас нэр дэвшигч Хуягийн Болдбаатар, 19 дүгээр тойрогт 61.68 хувийн санал авсан МАН-аас нэр дэвшигч Цэрэннадмидын Бат-Эрдэнэ нарыг аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсонд тооцож, төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх саналыг хуралдаанд оруулсан байна.

Хуралдааны “Төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай” 6/02 дугаар тогтоолоор Х.Болдбаатарын, 6/03 дугаар тогтоолоор Ц.Бат-Эрдэнийн төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрсөн байна

Аймгийн ИТХ-ын дарга Х.Батболд “Аймгийн ИТХ-аас 2010 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, цаашдын зорилтын тухай” илтгэлдээ ... Нутгийн өөрөө удирдах байгууллага нь иргэдийн өргөн оролцоотой аймаг, сум, багийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг тодорхойлох, бодлого боловсруулан, биелэлтийг нь зохион байгуулах, иргэдийн сайн сайхан амьдралыг баталгаажуулах, гаргасан шийдвэрийн биелэлтийг хянаж шалгах зэргээр үйл ажиллагаа нь жил ирэх тутам төлөвшиж байна.

ИТХ-ын хуралдаанд төлөөлөгчдийн ирц 96.6 хувиас дээш болон бүрэн бүрэлдэхүүнтэйгээр хуралдаж, хуралдаанд 69 хүн урилгаар оролцсоноос 57 нь төсвийн байгууллагын ажилтан, 12 нь иргэд байна. Хуралдаанд давхардсан тоогоор нийт 25 хүн үг хэлж, санал шүүмжлэл гаргасан ба хуралдаанаас нийт 13 тогтоол, “Аймгийн бэлчээр ашиглалтын менежментийн дунд хугацааны төлөвлөгөө /2010-2012/ батлан гаргалаа. Мөн “Бэлчээрийг эрх зүйн болон эдийн засгийн хөшүүргээр зохицуулах арга замын тухай” илтгэлд тусгагдсан бэлчээрийн зохицуулалтын үзэл баримтлал, хураамж түүнийг тогтоох арга замыг холбогдох хууль тогтоомжид тусгуулан шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын чөлөөт цагт Тэргүүлэгчид сард гурваас доошгүй удаа хуралдаж 33 удаа хуралдаж аймгийн ИТХ, Засаг даргын сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл, хөтөлбөрт тусгагдсан бодлого арга хэмжээг ажил хэрэг болгох, эдийн засаг нийгмийн салбаруудын хөгжлийн зорилтыг цаг алдалгүй, шуурхай шийдвэрлэх, санхүүгийн нөөц, өмч хөрөнгийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх төрийн дээд шагналд тодорхойлох, төрийн захиргааны болон үйлчилгээний ажилтны гүйцэтгэх хариуцлагыг сайжруулах зэрэг асуудлууд хэлэлцэж 270 тогтоол гаргаж, түүний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих”, “хоршоо хөгжүүлэх”, “Малын тэжээл”, “Атрын гурав дахь аян”, “Ногоон хувьсгал -2”, “Жендерийн тэгш

байдлыг хангах “Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах арга хэмжээ” зэрэг аймгийн дэд хөтөлбөрүүд баталлаа.

Аймгийн ИТХ-ын 2010 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 10 бүлэг 81 асуудал тусгаж баталсанаас 79 асуудал биелэгдэж нэмж 12 төрлийн цаг үеийн тулгамдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэн биелэлтийг хангахад хяналт тавьж ажиллаж байна.

Тайлангийн жилд аймагт 2010 онд хийгдэх хяналт, шалгалтын график, аймгийн эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2011 -2013 оны төсвийн хүрээний мэдэгдэлд өгөх санал, орон нутгийн өмчийн тооллогын дүн, авах арга хэмжээний тухай, аймагт 2010 онд явагдах сургалт, семинар, уулзалт, зөвлөгөөний төлөвлөгөө, нийтээр тэмдэглэх ой, тэмдэглэлт өдөр, спорт, урлагийн арга хэмжээний төлөвлөгөө, орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоот байгууллагуудын 2010 оны орлого зарлага, цалингийн сан, дүйцүүлэх албанд цэрэг татах төлөвлөгөө норматив зэрэг асуудал, өвөлжилтийн байдал, байгаль цаг уурын хүндрэл, бэрхшээлийг даван туулахад аймгийн нөөцийн хүрэлцээтэй байдал, цаашид авах арга хэмжээний тухай аймгийн Засаг даргын мэдээлэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн биелэлт болон орон нутгийн өмчийн асуудлууд, Төрийн дээд шагналд тодорхойлох, аймгийн Хүндэт иргэн, Хүндэт тэмдгээр шагнах, Иргэдийн санал хүсэлт, өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэх зэрэг тулгамдсан болон стратеги, үйл ажиллагааны олон чухал асуудал арга хэмжээг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Тайлангийн хугацаанд Тэргүүлэгчдийн өргөтгөсөн хуралдааныг 2 удаа бүсчлэн зохион байгуулж хуралдаанд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, зөвлөхүүд, хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасаг, агентлагийн дарга нар, сумдын ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, 2 тэргүүлэгч, илтгэл мэдээлэл тавих Засаг дарга нар оролцсон болно.

Алтай суманд зохион байгуулсан бүсчилсэн хуралдаанд Булган, Үенч, Мөст, Мөнххайрхан, Цэцэг, Манхан сумууд оролцож, “Багийн ИНХ-аас зохион байгуулж буй ажлын арга барил, үйл ажиллагааны үр дүн, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, багийн ИНХ-ыг чадавхжуулах талаар зохиож байгаа ажлын тухай” Мөст сумын Давст багийн ИНХ-ын даргын мэдээлэл, “Сумын ИТХ-аас орлого нэмэгдүүлж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх чадварыг бий болгох талаар авч хэрэгжүүлж буй ажил, цаашдын зорилтын тухай” Алтай сумын ИТХ-ын даргын мэдээлэл, “Байгаль орчин тогтвортой хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажил, байгаль хамгаалахад нутгийн иргэд, нөхөрлөл, малчдын бүлгийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх талаар зохиож буй ажлын тухай Цэцэг сумын Засаг даргын илтгэл, “Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааны үр дүн, цаашид хэрэгжүүлэх бодлогын тухай” Үенч сумын ИТХ-ын даргын мэдээлэлийг тус тус хэлэлцэж, “Орлого нэмэгдүүлж өөрөө өөрийгөө санхүүжүүлэх тухай”, “Багийн ИНХ-ын үр нөлөөг дээшлүүлэх зарим арга хэмжээний тухай”, Ажил эрчимжүүлэх тухай” тогтоолуудыг гарган хэрэгжүүлж ажиллаж байна.

Дөргөн суманд зохион байгуулсан Тэргүүлэгчдийн өргөтгөсөн хуралдаанд Зэрэг, Дарви, Чандмань, Дөргөн, Мянгад, Буянт, Дуут, Ховд, Эрдэнэбүрөөн, Жаргалант сумууд оролцож, “Сумын ИТХ-аас Төлөөлөгчдийн өдөр зохион байгуулж буй арга барил, үр дүнгийн талаар “Дуут сумын ИТХ-ын даргын илтгэл, “Багийн ИНХ-ын үйл ажиллагааг сайжруулах, бэхжүүлэх талаар зохиож байгаа ажлын үр дүнгийн тухай” Дөргөн сумын ИТХ-ын даргын мэдээлэл, “Сумын ИТХ-аас иргэд, төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, тэдний үүсгэл, санаачлагыг дэмжих талаар зохиож буй ажлын тухай Эрдэнэбүрөөн сумын ИТХ-ын даргын илтгэл, “Аялал жуулчлал хөгжүүлэх, нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих талаар хэрэгжүүлж буй ажил, цаашдын зорилтын тухай Чандмань сумын Засаг даргын илтгэлийг тус тус хэлэлцэж, “Аялал жуулчлал хөгжүүлэх тухай”, “ТББ-ын үйл ажиллагааг дэмжих, түншлэж ажиллах арга хэмжээний тухай”, “Төлөөлөгчдийн өдөр” үйл ажиллагааны тухай тогтоолуудыг гаргаж хэрэгжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулагдаж байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдааныг бүсчлэн сумдад зохион байгуулах нь аймаг, сумын ИТХ-ынхан ажлын арга барилаас харилцан суралцах, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид сум, байгууллагын үйл ажиллагаатай газар дээр нь танилцан иргэдтэй уулзаж ярилцах, санаа бодлыг нь сонсож бодлого тодорхойлоход тусган, хууль тогтоол, гаргасан шийдвэрийг сурталчлах олон талын ач холбогдолтой үр дүнтэй ажил боллоо.

Аймгийн ИТХ-аас 2009-2010 онд бодлогын чанартай 59 тогтоолын 176 заалтыг заалт тус бүрээр тооцож гаргахад Удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын чиглэл 68.4, Боловсрол, соёлын чиглэл 86.6, Эрүүл мэндийн чиглэл 90.7, Хүнс, хөдөө аж ахуй жижиг дунд үйлдвэрийн чиглэл, 73.0, Санхүү, төрийн сангийн чиглэл 75.3, Хууль, эрх зүйн чиглэл 50.0 хувь буюу аймгийн дүнгээр 75.3 хувийн биелэлттэй байна.

Аймгийн ИТХ-ын бүтцийн 5 хороо ажлаа төлөвлөн, ИТХ-ын хуралдааны болон Тэргүүлэгчдийн хуралдааны шийдвэрийг судлан дүгнэлт гаргах, сурталчлах, биелэлтийг зохион байгуулах, үр дүнг хянаж шалгах, үнэлгээ өгөх, мониторинг хийх талаар үйл ажиллагаагаа хэрэгжүүллээ.

Мерси Кор олон улсын байгууллагатай хамтран аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн мэдлэг, мэдээллийг нь нэмэгдүүлж, санал санаачилгыг нь өндөржүүлэх зорилгоор “Байгалийн нөөцийн менежмент, байгаль орчны үнэлгээ тогтоох аргачлал”, “Хүний нөөцийг хөгжлийн хандлагад уялдуулан зохион байгуулах нь “ сэдэвт сонирхолтой сургалтыг зохион байгууллаа.

Мөн Конрад Аденауэрын сан, Улс төрийн боловсролын академийн Ховд дахь салбар бусад төсөл хөтөлбөрийн газруудтай хамтран багийн ИНХ-ын дарга, сум, аймгийн ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, аймгийн ИТХ-ын Төлөөлөгчид оролцсон НӨУБ-ын сонгуультан, ажилтнуудын аймгийн III зөвлөгөөнийг зохион байгуулж, Нутгийн өөрөө удирдах байгууллагыг цаашид хөгжүүлэн төлөвшүүлэх зорилтыг дэвшүүлсэн Нутгийн өөрөө

удирдах ёсны байгууллагын ажилтан, сонгуультнуудад хандсан зөвлөмж гарган хэрэгжүүлж байна.

Аймгийн ИТХ-аас аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зардал олгох журмын дагуу 2010 онд төлөөлөгч бүрт 1.0 сая төгрөг баталж дэмжлэг үзүүлснээр төлөөлөгч бүр тойрогтоо хүрч ажиллаж иргэд сонгогчдод хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг сурталчилах, тулгамдаж буй асуудлаар санал солилцох, олон түмний санал санаачилгыг дэмжиж тодорхой асуудлуудыг шийдвэрлэх талаар олон хэлбэрийн арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.

Тайлангийн хугацаанд аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн өдрийг 4 дүгээр сард зохион байгуулж “Аймгийн байгаль орчны талаар хэрэгжүүлж буй бодлого, түүний үр дүнгийн тухай” аймгийн Засаг даргын мэдээлэл, 8 дугаар сард “Аймгийн эдийн засаг нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2011 оны төсвийн төсөл боловсруулсан дүн”, “ЕБС, цэцэрлэгийн байгууллагуудын үйл ажиллагааны өнөөгийн байдал, 2010-2011 оны хичээлийн жилийн бэлтгэл хангалт, цаашид анхаарах асуудал”-ын тухай, 10 дугаар сард зохион байгуулж аймгийн өвөлжилтийн бэлтгэл ажлын тухай аймгийн Засаг даргын мэдээллийг хэлэлцэж, хэлэлцэж буй асуудал тус бүрээр төлөөлөгчид асуулт асууж, цаашид хэрэгжүүлж зохион байгуулах ажил, асуудлын талаар үнэтэй зөвлөгөө, санал дүгнэлт гаргасныг ажил хэрэг болгох зорилгоор санал шүүмжлэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөг Тэргүүлэгчдийн хурлдаанаар хэлэлцэж батлуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж хэрэгжүүлээд байна.

ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанаас сумдын ИТХ, багийн ИНХ, түүний Тэргүүлэгчдийн ажлыг жигд сайжруулах, арга зүйн удирдлагаар хангаж тэдгээрийн бодлого, үйл ажиллагааны чанарыг өөрчлөн хөгжүүлэхэд байнга дэмжлэг үзүүлж байна. ИТХ-ын ажлын чанар, хүртээмжийг дээшлүүлэх, Нутгийн өөрөө удирдах байгууллагын үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар Чандмань, Дуут, Мөнххайрхан, Эрдэнэбүрэн, Мөст, сумын Хурал бусдаасаа илүү санаачлагатай ажиллаж байна. Мөст сумын Давст багийн ИНХурал /дарга нь Соронзон/-ийн ажлын арга барилыг манай нийт багийн хурлууд өөрийн онцлогт тохируулан хэрэгжүүлэхэд олон шинэлэг ажил зохиож иргэдийн сэтгэлд хүрч идэвхийг өрнүүлэх боломжтой гэж дүгнэж байна.

2010 оны байгаль цаг уурын хүндрэлээс аймгийн хэмжээнд 465.0 мянган мал хорогдож аймгийн эдийн засагт 16.0 орчим тэрбум төгрөгийн гарз хохирол учирч 803 малчин өрх малгүй болж хүнд бэрхшээлийг бий болголоо. Одоогийн байдлаар малгүй болсон 17 сумын 803 өрхөд 240.9 сая төгрөгийн дэмжлэг, 9 сумын 165 өрхөд 280.5 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлж нийт 968 өрх малжуулах арга хэмжээнд хамруулан 45 өрхийг бусад үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллахаар шилжүүлсэн байна.

Дээрхи байгалийн бэрхшээлийн улмаас 2010 оны эцэсээр 1616.0 мянган мал тоологдон оны эхний мал 652.3 мянган толгойгоор буурсан байна.

Аймгийн дүнгээр 2010 онд 2654.4 га талбайд тариалалт хийж 23.9 мянган тн ургац хурааснаас төмс 12.9 мянган тн, үр тариа 935 тн, хүнсний ногоо 830 тн, тэжээлийн ургамал 1768 тн, техникийн ургамал 10.5 тн тус тус хураасан нь өмнөх оноос тариалсан талбайг 358.4 га-гаар ургац 5.2 мянган тн-оор илүү хураасан байна.

Аймгийн хэмжээнд 900 гаруй жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагууд ажиллаж хүлээгдэж буй гүйцэтгэлээр аж үйлдвэрийн салбар 3415.9 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 3301.9 сая төгрөгийн борлуулалт хийж барилгын салбар 14.3 тэрбум төгрөгийн барилга угсралт их засварын ажил бусад салбарт 7.3 тэрбум төгрөгийн ажил үйлчилгээ гүйцэтгэлээ.

Жижиг дунд үйлдвэрлэлийг шинээр бий болгох, хүчин чадлыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг өргөтгөн тогтвортой байдлыг бий болгох зорилгоор 16 сумын 42 төсөлд 249.0 сая төгрөг, аймгийн төвд 60 төсөлд 601.0 сая төгрөг нийт 850.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүллээ.

Аймгийн хэмжээгээр 2010 оны урьдчилсан тооцоогоор ДНБ үйлдвэрлэл 114.2 тэрбум орчим төгрөгөөр тооцогдож нэг хүнд ногдох хэмжээ 1382 төгрөг болж байна.

Сум бүр хөгжлийн бодлогыг оновчтой тодорхойлон түүнийг хэрэгжүүлэх санхүүгийн нөөцөө бүрдүүлэхэд өөрийн давуу талыг ашиглан орлого нэмэгдүүлэн өөрөө өөрийгөө санхүүжүүлэх бодлогын шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Орон нутгийн төсөвт нийт 2870.4 сая төгрөгийн урсгал орлого оруулахаас урьдчилсан дүнгээр 2972.7 сая төгрөг төвлөрч 102.3 сая төгрөгөөр Үүнээс татварын орлогоор 2593.4 сая төгрөг оруулахаас 2683.9 сая төгрөг оруулж төлөвлөгөө 90.5 сая төгрөгөөр, татварын бус орлогоор 275.7 сая төгрөг оруулахаас 288.7 сая төгрөг оруулж төлөвлөгөө 13.0 сая төгрөгөөр тус тус давж биелүүлэхээр байна.

Орон нутгийн төсвөөс 619.5 сая төгрөгийн зарлагыг санхүүжүүлэхээс гүйцэтгэлээр 621.3 сая төгрөгт хүрлээ.

Тус онд аймаг улсын төсөвт нийт 619.5 сая төгрөгийн орлого оруулахаас 621.3 сая төгрөг оруулж төлөвлөгөө 1.8 сая төгрөгөөр буюу 0.2 хувиар давж биелэхээр байна. Орон нутаг дахь улсын төсвийн байгууллагуудын төсвийн зарлага 22623.3 сая төгрөгт хүрэхээр байна.

Тайлангийн хугацаанд орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 155.0 сая төгрөгийн, аймагт эрх нь шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5241.7 сая төгрөгийн, Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар 15.0 сая төгрөгийн, улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар 8630.7 сая төгрөгийн зээл, тусламж, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 3307.8 сая төгрөгийн, хувийн хэвшлийн хөрөнгө

оруулалтаар 1851.8 сая төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжиж нийтдээ 19686.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Орон нутгийн төсвийн орлогоос давсан 780.0 сая төгрөгийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн Халал аргаар мах боловсруулах үйлдвэрлэл шинээр барихад 350.0 сая төгрөг, Шим ус компаний цэвэрлэх байгууламжийн гарч байгаа усыг ашиглан ойн зурвас байгуулахад 101.2 сая төгрөг, орон нутгийн өмчийг нэмэгдүүлэхэд 72.0 сая төгрөг, хэвлэл мэдээлэлийн байгууллагуудын чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр 9.0 сая төгрөг, бусад хөтөлбөр арга хэмжээ болон сум, байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад 319.8 сая төгрөгийг хуваарилан олголоо.

Орон нутгийн өмчийн тооллогын дүнгээр нийт 85997,3 сая төгрөгийн хөрөнгө тоологдсоноос, барилга байгууламж 70041,2 сая төгрөг, тоног төхөөрөмж 6545,4 сая төгрөг, тээврийн хэрэгсэл 1568,9 сая төгрөг, тавилга эд хогшил болон бусад үндсэн хөрөнгө 7841,7 сая төгрөгийг тус тус эзэлж байна.

Энэ онд орон нутгийн өмчит “Ховдсуварга” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулан, 1,6 тэрбум төгрөгийн хөрөнгийг бүртгэн авч ажил үйлчилгээг жигдрүүлэхэд дэмжлэг болгож 10,0 сая төгрөгийг аймгийн өмчийн сангаас олголоо.

Хувийн өмчийн оролцоотой Нэвт рашаан орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон шинээр ашиглалтанд орсон Усан спортын төвийг Мянган угалзат үйлдвэрийн газартай нэгтгэж үйл ажиллагааг жигдрүүлсэнээр амралтын газарт амрагчдын тоо 2 дахин нэмэгдэж усан бассейний хэвийн ажиллагаа хангагдан иргэдийн ая тухтай амрах газар болон өргөжиж байна.

Мөн Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 2010 оны орлого, зарлагын төлөвлөгөөг орлогоо нэмэгдүүлж, зардлаа хямдруулж, үр ашигтай ажиллахаар баталсанаар орон нутгийн аж ахуйн тооцоот байгууллагуудын санхүүгийн үр ашиг сайжирч хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1135.0 сая төгрөгийн орлого олж 30.9 сая төгрөгийн ашигтай ажиллаж байна.

Аймгийн өмчийн албанаас 5 удаагийн дуудлага худалдаа зохион байгуулж 9 барилга, объект, 13 тээврийн хэрэгсэлийг 51423.0 мянган төгрөгийг орлогыг аймгийн өмчийн санд бүрэн төвлөрүүлээ.

Сурагчдын суралцах, хөгжих нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Боловсрол, соёлын байгууллагуудыг хөгжүүлж, удирдлагаар хангаж байгаа арга барилын тухай Зэрэг сумын Засаг даргын итгэл. аймгийн Засаг дарга болон Боловсрол, соёлын газрын хүсэлтийг судлах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж дүгнэлтийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцээд “Сумын боловсрол соёлын газрын үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай”, “Хүүхэд хөгжүүлэх төлбөртэй сургалтын журам” “Төсвийн тухай” тогтоолууд гаргаж, биелэлтийг тооцон ажиллаж байна.

Энэ хичээлийн жилд цэцэрлэгт нийт 5707 хүүхэд хүмүүжиж СӨБ-ын хамран сургалт 72.3 хувьд хүрч өмнөх оноос 3.3 хувь өссөн байна. 2010-2011 оны хичээлийн жилд 23 сургуулийн 653 бүлэгт өдрөөр 19592 хүүхэд, эчнээгээр 7 бүлэгт 125 хүүхэд, залуучууд, дүйцсэн хөтөлбөрөөр 19 бүлэгт 830 хүүхэд, залуучууд ерөнхий боловсрол эзэмшиж байна. Бага боловсролын хамран сургалт 91,1 хувьд хүрч өмнөх оноос 1,8 хувь өсөж, суурь боловсролын хамран сургалт 90,7 хувьтай боллоо.

Дотуур байрны хангамжийг сайжруулж, сурагчдын сурах орчин бүрдүүлэх зорилгоор Зэрэг сумын сургуульд шинээр 100 хүүхдийн, Буянт суманд 150 хүүхдийн дотуур байр тус тус ашиглалтанд оруулж, сурагчдын дотуур байрны нийт ор 2010 онд 2000 болж өмнөх оноос 250 ороор нэмэгдүүлсэн бол 2010-2011 оны хичээлийн жилд дотуур байрны орыг 2295-д хүргэхээр төлөвлөгөө, төсөвт тусгаад байна.

Боловсролын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, суралцагсадын суралцах, хөгжих орчинг бүрдүүлэх зорилгоор 2010 онд 4.546.3 сая төгрөгийн барилга, их засвар, тоног төхөөрөмж нийлүүлэх зэрэг 26 нэр төрлийн ажлууд хийгдсэн нь өмнөх оноос 628.0 сая төгрөгөөр, 1047.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн нь өмнөх оноос 657.1 сая төгрөгөөр нэмэгдэж, Манхан сумын сургуулийн 8 ангийн сургуулийн өргөтгөл, Мөст сумын 520 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, Жаргалант сумын 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, Мөнххайрхан сумын сургуулийн спорт заалны барилга, Дөргөн сумын 100 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга, Дарви сумын сургуулийн барилгын өргөтгөл, Буянт сумын сургуулийн дотуур байрны барилгууд баригдаж байна.

Орон нутгийн үйлдвэрлэл үйлчилгээний гаруудад шаардлагатай ажлын байраар хангах зорилтын хүрээнд Хөгжил МСҮТөвийн үйл ажиллагаа жигдэрсэнээр 2010-2011 оны хичээлийн жилд 17 мэргэжлээр 1570 хүүхэд суралцаж байгаа нь өмнөх оноос 13.4 хувь, буюу 2008 онтой харьцуулахад 3 дахин нэмэгдсэн байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар эрүүл мэндийн чиглэлээр хүн ам, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн “Сэтгэцийн эрүүл мэнд II дэд хөтөлбөр”, аймгийн донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах баруун бүсийн чуулганы шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Цус цусан бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдлыг хангах ажлын төлөвлөгөө”-г батлан гаргаснаар хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, нийгэм хамт олонд тулгуурласан тусламж үйлчилгээний хүрээг өргөжүүлэх, сэтгэц зан үйлийн эмгэгийг бууруулах, цус цусан бүтээгдэхүүний чанартай найдвартай эх үүсвэр, эм, тариа, урвалж орчин үеийн технологийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр эмнэлгийн байгууллагуудыг хангахад баримтлах бодлого, чиглэлүүдийг тодорхойлон хэрэгжүүллээ.

Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардлагатай байгаа техник хэрэгсэл, тоног төхөөрөмж авах зардлыг батлан гаргасан нь эмнэлгийн тусламж үйлчилгээг шинэ шатанд гаргах, үйлчлүүлэгч, иргэдийн сэтгэл ханамжид нийцсэн чанартай, хөнгөн шуурхай үйлчилгээг бий болгоход гол дөхөм болно гэж үзэж байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Алтай суманд болсон өргөтгөсөн хуралдаанаар “Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааны үр дүн, цаашид хэрэгжүүлэх бодлогын тухай” Үенч сумын ИТХ-ын даргын мэдээллийг сонсож сумдад эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгааг газар дээр нь үзэж танилцан цаашид ямар чиглэлээр хэрхэн ажиллаж болох тухай бодлого боловсруулж аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдэд танилцуулах үүргийг аймгийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга болон Эрүүл мэндийн газрын даргад өглөө.

Энэ онд аймгийн хэмжээнд 337418 хүнд үзлэг хийж, 20476 хүнийг хэвтүүлэн эмчилж, 1917 эх төрж 2020 эхийг шинээр хяналтанд авсан нь төрөлт урьд мөн үеийнхээс 110 тохиолдлоор буурч 0-1 насны хүүхдийн эндэгдэл 9, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 2 тохиолдлоор нэмэгдэж, эхийн эндэгдэл 1 тохиолдол гарч, халдварт өвчин өнгөрсөн мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна.

Энэ онд нийгмийн халамж, үйлчилгээний чиглэлээр дэвшүүлсэн зорилтууд бүрэн хэрэгжиж иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд зохих хувь нэмэр боллоо. Ажилгүй ажил идэвхтэй эрж буй 1074 хүн бүртгүүлснээс 830 орчим хүнийг ажлын байраар хангаж 1600 иргэнийг шинэ ажлын байраар зуучиллаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 32 төсөлд 83.0 сая төгрөг, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Булган, Алтай, Үенч сумдын 15 малчинд нийт 54.0 сая төгрөгийн санхүүжилтээр мал худалдан авч өгөх ажлыг зохион байгуулсан нь аж ахуй эрхлэлтийг нэмэгдүүлэн түр ажлын байраар хангахад зохих хувь нэмэр оруулж байна

Нийгмийн халамжийн тэтгэвэр 1853 хүнд 974.6 сая төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 3621 хүнд 753.6 сая төгрөг, нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх тусламж хөнгөлөлт 55,9 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ 25,4 сая төгрөг, ахмад настанд үзүүлсэн тусламж хөнгөлөлт 4306 хүнд 438,0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 110,5 сая төгрөг, алдар цолтой ахмад настанд 104,9 сая төгрөг, жирэмсэн хөхүүл эхчүүдийн мөнгөн тэтгэмжид 506,6 сая төгрөг, алдарт эхийн одонд 717,4 сая мянган төгрөг, хүний хөгжлийн сангийн хишиг, хувь 85218 хүнд 8000,1 сая төгрөг, нийгмийн даатгалын сангаас 9336 тэтгэвэр авагчдад, 10.2 тэрбум төгрөг, 1956 даатгуулагчдад жирэмсний болон амаржсаны 411.9 сая, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжинд 299.7 сая, 121 хүнд ажилгүйдлийн тэтгэмжинд 125.6 сая, оршуулгын тэтгэмжинд 307 хүнд 103.5 сая төгрөг нь хүүхэд багачууд, ахмад настан болон нийгмийн эмзэг бүлгийн ард иргэдийн орлогын тодорхой түвшинд эх үүсвэр болж

тэдний амьдрал ахуйг тэтгэхэд дэмжлэг боллоо. Аймгийн нийгмийн даатгалын хэлтэс энэ оныг “Цахим нийгмийн даатгал”-ын жил болгон зарлаж 5888.2 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөтэйгээс 5947.1 сая төгрөгийн орлого хуримтлуулж төлөвлөгөөг 101.0 хувь буюу 58.9 сая төгрөгөөр давуулан биелүүлж иргэдийн нийгмийн хамгаалалыг хамрагдах хүрээг өргөтгөж байгаа ч албан байгууллагуудад 151.9 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсч байгаа нь иргэдийн зарим хэсэг болон нийгмийн эмзэг бүлгийн нийгмийн халамж үйлчилгээний хүртээмжид сөрөгөөр нөлөөлж байгааг онцгойлон анхаарч шуурхай шийдвэрлэх шаардлагатай байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанаас 2010 оны 8 сард явуулсан бүртгэл судалгаагаар /бүрэн бус мэдээгээр/ 55 гаруй төрийн бус байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна.

“Нээлттэй, ил тод, шударга, тунгалаг-Төр”, “Хариуцлагатай, тунгалаг –Иргэний нийгэм”, “Хүчирхэг, бүтээлч тунгалаг –Хувийн хэвшил”-ийн хамтын ажиллагааг хэрэгжүүлснээр орон нутгийн нийт иргэдийн эв нэгдлийг эрхэмлэн дээдлэж, нийтлэг хүсэл, язгуур эрх ашиг сонирхолд нийцүүлэн Төр, Иргэний нийгмийн зөвлөл, Хувийн хэвшлийнхний гурван талт хамтын ажиллагаа, түншлэлийн гэрээг байгуулан ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Сумын ИТХ-аас иргэд, Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, тэдний үүсгэл санаачлагыг дэмжих талаар зохиож байгаа ажлын тухай” Эрдэнэбүрэн сумын ИТХ-ын дарга А.Бадамдоржийн илтгэлийг хэлэлцээд “Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, түншилж ажиллах арга хэмжээний тухай” аймгийн Засаг дарга, Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт 3 заалт, Төрийн бус байгууллагын идэвхтэн, сонгуультаан нарт 4 заалт бүхий тогтоолыг батлаж, холбогдох байгууллага, аж ахуй нэгж, ИНБ-уудад хүргэж, биелэлтийг тооцон ажиллаж байна.

ИТХ-ын дэргэдэх Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл 23 гишүүнтэйгээр жилийн ажлын төлөвлөгөөнд төлөвлөсөн 66 асуудлын 64-ийг бүрэн биелүүлж Зөвлөлийн хурлыг 7 удаа хуралдуулж Мянгад, Мөнххайрхан, Үенч сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлүүдийн ажлын мэдээлэл, аймгийн цагдаагийн газрын ажил үүрэг хариуцсан тасгуудын ажлын мэдээллийг сонсож зөвлөмж, тэмдэглэлээр үүрэг өгч, Архидан согтуурахаас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай төсөл боловсруулах аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар тогтоол гаргууллаа ажиллаа. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн ажлын албатай хамтарч бүх сумын ГХУСАЗСЗ-ийн болон зарим багуудын ажилтай танилцаж арга зүйн удирдлагаар хангаж, Мянгад, Дөргөн, Эрдэнэбүрэн, Ховд, Манхан, Чандмань, Зэрэг, Мөнххайрхан сумын ГХУС ажлыг зохицуулах зөвлөлүүдийг шинэчлэн байгуулж

зөвлөлийн хурлыг хийлгүүлэн хэрхэн ажиллах талаар арга зүйн зөвлөгөө өгсөн явдал нь ГХУСАЗСЗ ийн хувьд шинэлэг, хүртээмжтэй ажил байсан юм.

Сумын ГХУСАЗСЗ-ийн удирдлагуудад 2 удаа 2-4 цагийн семинар, сургалт багийн ИНХ-ын дарга нарт багаас ГХУС, нийгмийн хэв журмыг хамгаалах сэдвээр 4 цагийн сургалт зохион байгуулав. ГХУС ажлын тухай сумын зөвлөлийн дарга нартай биечлэн уулзаж арга зүйн удирдлагын туслалцаа үзүүлж байсны дотор Алтай, Булган, Чандмань сумын ИТХ-ын дарга нартай 2, бусад сумдын удирдлагуудад 3-5 удаа шинэ мэдлэг, мэдээлэл өгөх ярилцлага уулзалт хийсэн байна.

Аймгийн ИТХ, Засаг даргын Тамгын газар, Шүүх, Прокурор, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтран “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн газар, Боловсрол соёлын газар, Онцгой байдлын хэлтэс, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс ойролцоогоор их дээд, ерөнхий боловсролын сургуулиудын удирдлага, оюутан сурагчдын өөрөө удирдах байгууллага, архи согтууруулах ундааны үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн аймгийн зөвлөгөөн, сургалт хэлэлцүүлгийг 11 дүгээр сарын 7-нд “Архидан согтуурахаас сэргийлэх ажлыг эрчимжүүлэе” илтгэлийг аймгийн Засаг дарга ГХУСАЗСЗ –ийн дэд дарга Г.Нямдаваа тавьж хэлэлцүүлэв. Уг зөвлөгөөнд Ховд их сургуулийн Оюутны холбоо, Жаргалант сумын 12 жилийн 1 дүгээр сургуулийн сурагчдын байгууллагууд үүрэг авч уриалга гаргалаа. Уг зөвлөгөөн сургалт хэлэлцүүлгийн дүнг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж 227 дугаар тогтоол гаргасан бөгөөд “Амар, тайван амьдралын төлөө хамтдаа” уриан дор архидан согтуурахаас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх нэг жилийн аянг зарлаж уг ажлыг эрхлэн явуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргаар удирдуулан байгуулж, үйл ажиллагаа нь эрчтэй эхлээд байгаа бөгөөд ард иргэд зөв зүйтэй ажил гэж сэтгэл ханамжтай хүлээж авч байна. Нэг жилийн аянг бүх сум, байгууллагууд эрч хүчтэй эхлүүлж удирдлагууд энэ талаар нилээд санаачлагатай ажиллаж байгаагаас гадна олонх сум, байгууллагууд оролцсон “Дэвжээ” тэмцээнээр аяны нээлтийг эхлүүлсэн нь чухал үр өгөөжтэй байлаа. “Дэвжээ” тэмцээнд Дөргөний “Маск”, Цаст Алтай цогцолбор сургуулийн “Тэсрэлт” Мөнххайрхан сумын “Ирээдүйн хөтөч” Алтай сумын “Залуу лидерүүд” Дуут сумын “Зэлмэ” Ховд их сургуулийн “Үнэний дэнс” Эрдэм дээд сургуулийн “Эрдэм”, Мөст сумын Мөстийн бахархал” Чандмань сумын “4 хүч” Эрдэнэбүрэн сумын “Арга билэг” багууд амжилттай оролцсоны дотор Цаст Алтай сургуулийн баг шалгарч шилжин явах цом, алтан медаль, өргөмжлөл 400,0 мянган төгрөгөөр, Эрдэм дээд сургууль II, Ховд сумын баг III байр эзэлж мөнгө хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдаж бусдыгаа хошуучилсан бөгөөд дээрх сум байгууллагууд олон сайхан ажлыг эхлүүлсэн байна.

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа түүнийг цаашид боловсронгуй болгох асуудлууд” сэдвээр ИТХ, ЗДТГ, Шүүх, Прокурор, Цагдаагийн

газар, Ховд их сургуультай хамтран ГХУСАЗЗ-ийн санхүүжилтээр зохион байгуулсан онол практикийн бага хуралд аймаг сумын ГХУСАЗЗ болон иргэд, байгууллагын ажилтай холбоо бүхий 20 гаруй илтгэл тавигдсаны дотор ГХУСАЗЗ, Ховд их сургуулийн багш оюутан Шүүх Прокурор, Цагдаагийн газрын ажилтнуудын илтгэл шалгарсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг 300 байгаа нь 2009 оныхоос 80 хэрэг буюу 21.1 хувь, 2008 оныхоос 219 хэрэг буюу 42.2 хувь буурсан байна. Өнгөрсөн оноос хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 9.1 хувь буюу 18 хэргээр, хулгайлах гэмт хэрэг 34.6 хувь буюу 44 хэргээр, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 81.2 хувь буюу 13 хэргээр амиа хорлосон буюу золгүй байдлаар нас барсан гэмт хэрэг 50.0 хувь буюу 8 хэргээр, гэмт хэрэгт 355 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 12.0 хувь буюу 51 хүнээр согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 5 хэргээр, хүүхэд оролцсон гэмт хэрэг 33.0 хувь буюу 4 хэргээр буурсан үзүүлэлттэй байгаа нь эерэг үр дүн бий болгожээ. Харин мал хулгайлах гэмт хэрэг 21, танхайн гэмт хэрэг 26 бүртгэгдсэн нь өмнөх оны түвшинд тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 14 хэргээр бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 2 буюу 54.0 хувь өссөн байна. Гэмт хэргийн улмаас иргэн аж ахуйн нэгжид учруулсан хохирол өмнөх оноос 41.2 хувь буурч 223.2 сая төгрөг болсны 60.0 хувь буюу 149.0 сая төгрөгийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн нь цагдаагийн газар тэдгээрийн бие бүрэлдхүүний үр нөлөөтэй арга ажиллагааны тодорхой үр дүн гэж онцлон тэмдэглэж байна.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг сум бүр хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж хэлмэгдэгсдийн төрөл, төрөгсөд, үр хүүхдүүдтэй уулзаж хүндэтгэл үзүүлэх, санал хүсэлтийг сонсож ярилцах, улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийг сурталчлах, уг хуулийн үзэл санааг нийт иргэдэд хүргэж, тайлбарлах зэрэг ажлуудыг зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулиудын 9 дүгээр сарын 10-ны өглөө хичээл эхлэхийн өмнө сурагч, багш, ажилчид хэлмэгдэгсдийн гэгээн дурсгалыг хүндэтгэж, эхний цагийн хичээлийг улс төрийн хэлмэгдүүлэлтийн учир шалтгаан хор холбогдлыг тайлбарлан таниулах хичээл явууллаа.

2010 онд Монгол Улсын Ерөнхийлөгчид Төрийн дээд шагналаар шагнуулахаар 181 хүний тодорхойлолтыг өргөн мэдүүлсэнээс Монгол Улсын хүний гавьяат эмч 3, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон 6, Цэргийн Гавьяаны Улаан Тугийн одонгоор -4, Алтан гадас одон 49, Хөдөлмөрийн хүндэт медаль 50, Цэргийн Хүндэт Медаль - 2, Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медхлиар 562 бүгд 676, Алдарт эх I одонгоор 6, II одонгоор 115 эх, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр аймгийн Хүндэт иргэнээр 1, Хүндэт тэмдгээр 333 хүн тус тус шагнагдсан байна.

Аймгийн Нутгийн өөрөө удирдах байгууллагыг бүрдүүлж буй эрхэм хүндэт Төлөөлөгчид болон бодлогын хэрэгжүүлж буй төрийн албаны ажилтанууд орон нутгийн

хөгжлийг эрчимжүүлэн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар бид бүхний хамтын ажиллагааны хамгийн эрчимтэй ажиллах жилтэй золгож байна.Өөрөөр хэлбэл дэвшүүлсэн зорилтын өнгөрсөн хугацааны дундуурыг гүйцээж илүү их үр дүнг бий болгохыг олон түмэн биднээс хүсэн хүлээж байгаад дүгнэлт хийж цаашид дараахь зорилтуудыг хэрэгжүүлэхээр дэвшүүлж байна. Үүнд:

1. Бүх шатны нутгийн удирдах байгууллагын ажилтан, сонгуультан бүр өнгөрч буй 2 жилийн хугацаанд туршилгажиж, орон нутгийн амьдралын талаар гүнзгий мэдээлэлтэй, тулгамдсан асуудал болон хөгжлийн гарцыг тодорхойлон дүгнэсэн оновчтой бодлого чиглэлтэй болсон тул бүрэн эрхийн үлдэж буй хугацаандаа өмнөх хийж гүйцэтгэсэн ажлаа дүгнэн цаашид бүх шатанд ажлаа эрчимжүүлэн бүтээлчээр ажиллах шаардлагатай байна. 2010 онд Аймгийн НӨУБайгууллагын ажилтан, сонгуультаны III зөвлөгөөнөөс нийтээрээ хэлэлцэж шийдвэрлэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд төлөөлөлийн байгууллагын удирдлага бүр манлайлж иргэдийн санал, санаачилгаа, идэвхтэй оролцоонд тулгуурлан нөөц боломжийг зөв зохицуулан зохион байгуулж иргэн, өрх айл бүрийн амьдралыг дээшлүүлэхийн төлөө хүч бололцоогоо дайчлан эрчимтэй ажиллаж бодит үр дүн гаргацгая

2. Ирж буй 2010 онд ҮЭЧХөдөлгөөний 100 жил, Ардын хувьсгалын 90 жил, Аймаг байгуулагдсаны 80 жил , Ховд хот байгуулагдсаны 250 жилийн босго жилийн түүхт ойнуудыг угтаж олон үндэстэн ястан Ховдчуудын бүтээлч хөдөлмөрч уламжлалыг өрнүүлэн 2010 оныг **“Их бүтээн байгуулалт - -эрчимтэй хөгжлийн жил”** болгон зарлаж, баг, сум, байгууллага, аймгийн хэмжээнд оруулж буй хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулан иргэдийн ажил, амьдралын ая тухтай орчинг бүрдүүлэхэд бодлогоо төвлөрүүлэн хамтын өндөр зохион байгуулалттай ажиллацгаая.

3.Аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн гол салбаруудын нэг мал аж ахуйн салбарт тооны үзүүлэлтээр хөгжлийг хэмжиж дүгнэж байсан ажлын арга барилыг өмнөх жилийн байгалийн хүндрэл хатуухан дүгнэж сургамжийг хайрласан билээ. Бид сургамжаас дүгнэлт хийж малчидад мал аж ахуйгаас учирсан хохиролын үр дагаварыг богино хугацаанд арилгаж байгаль цаг уур болон зах зээлийн амьдралын шалгуурт нийцсэн, эрүүл, үр ашигтай мал сүргийг эрхэмлэсэн, хамтын хөдөлмөр зохион байгуулалтанд тулгуурласан, аж ахуй болгон хөгжлийн бодлогыг тодорхойлон эрчимжүүлье. Үүнд сумдад шинээр байгуулагдаж буй мал үржлийн нэгжүүд нэгдсэн бодлого чиглэлтэй санаачилгатай ажиллаж Монгол мал хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхитэй ажиллахыг анхааруулья.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн салбарт сүүлийн жилүүдэд өсөлт бий болж үрийн шинэ сортууд тариалалтанд нэвтэрч амжилт гарсан ч түүний ажиглалт, судалгаа, шинжилгээний ажил орхигдсон, анхан шатанд мэргэжлийн удирдлага дутагдаж байгаа нь илүү үр дүнд хүрэх боломж алдагдсаар байна. Иймд тус үйлдвэрлэлийн салбарыг шинжлэх ухаан, техник, технологийн ололт, дэвшилтэй уялдуулан хөгжүүлэх хөтөлбөрийг

хэрэгжүүлэх талаар онцгой анхаарлаа хандуулан боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах ажлыг түргэтгэх шаардлагатай байна.

4.Сүүлийн 2 жилд төрөөс төрийн болон хувийн хэвшлийн байгууллагыг дэмжих талаар тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийж төрийн үйлчилгээ бизнесийн оршинг сайжруулах талаар олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа ч төрийн үйлчилгээ төгс бус бизнесийн ажиллагаа тогтвортой бус байдал үргэлжилсээр хөрөнгийн үр ашиг хангалтгүй байна. Үйлдвэрлэл үйлчилгээний салбарт оруулсан хөрөнгө оруулалтын ашиглалтын үр дүнг хамтын түншлэлээр төр захиргааны байгууллагууд , төсөл хэрэгжүүлэгчид, иргэд болон иргэний нийгмийн байгууллагын оролцоотой үнэлж дүгнэн дэмжлэг үзүүлэн бий болсон боломж нөөцийг цаашид нэмүү өртөг шингээсэн бүтээгдхүүн ажил үйлчилгээний өсөлт болгон өөрчилж үр ашгийг дээшлүүлье

5.Эдийн засаг,нийгмийн салбарт оруулж буй хөрөнгө оруулалтын үр ашгийн хангалтгүй байдал тухайн салбарт ашиглаж буй шинэ техник технологийн түвшингээс хамааралтай ч мэргэжлийн ажилчин хүний нөөцөөс илүү хамааралтай байгаа нь амьдралд нотлогдсоор байна. Иймд бүх шатны ИТХ,Засаг дарга,төрийн, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагууд иргэн бүрийг хуулиа дээдлэдэг үзэл бодлыг төлөвшүүлэн гэгээрүүлж хөгжүүлэх нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэн хүний хөгжлийг бий болгож орон нутгийн хөгжилд давуу тал болгон ашиглацгаая

6.Төрийн албаны ажил үйлчилгээг иргэдэд ойртуулан сэтгэл ханамжтай байхаар олон талт арга хэмжээ тухайлбал нэг цэгийн үйлчилгээ, нээлттэй өдөр, иргэнийг сонсох өдөр, иргэдийн эрх зүйн зөвлөгөө өгөх танхим зэрэг шинэлэг ажиллагааг бий болгон ажиллаж зохих үр дүнд хүрч байгаа ч олон нийтийн зүгээс , хөнгөн шуурхай, шударга, хүртээмжтэй үйлчилгээ дутаж байгааг байнга шүүмжилсээр байгаа нь төрийн бүх шатны байгууллагуудад ажил гүйцэтгэх ур чадвар, ёс зүйн алдаа дутагдал байгааг илтгэж байна. Иймд төр иргэд олон түмэндээ төрийн үйлчилгээг хамгийн өндөр мэдлэг чадвар, ёс суртахуунтай, хүний төлөө ажилладаг ажилтанаар гүйцэтгүүлэхээр сонгодогийг төрийн албанд ажиллаж буй ажилтан албан хаагчид ухамсарлавал зохино. Нийт төрийн байгууллагууд гагцхүү дээрхи зарчмыг баримтлан ажилтануудын ажлын зохион байгуулалт, ёс зүй, сахилгийг бий болгож хариуцлагын тогтолцоотой ажиллахыг бүх шатны аймаг, сум, баг, байгууллагын удирдлагуудад анхааруулж байна.

7.Аймгийн хэмжээнд бүх төрлийн гэмт хэргийн гаралт жилээс жилд буурч нийгмийн хэв журмыг хангах ажилд нааштай үр дүн гарч байгаа ч бидний хүсэн хүлээж буй түвшинд харахан хүрэхгүй байгаа гол шалтгаан нь архидан согтуурах гаж үзэгдэл буурахгүй байгаагаас олон төрлийн гэмт хэрэг гарах нөхцөл болсоор байна. Ялангуяа хүн амд ногдох согтуурах үйлчилгээгээр үйлчилдэг цэгийн тоо өссөн хэмжээгээр үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж түүний дотор бидний хойш ирээдүй болсон оюутан сурагчдын тоо нэмэгдэж байгаа

тухай судалгаа, дүгнэлтэд холбогдох байгууллагууд онцгойлон анхаарч арга хэмжээ авах шаардлагатай байна. 2011 онд “Амар тайван амьдралын төлөө хамтдаа” уриан дор гэмт хэрэг зөрчилгүй хамт олон сум, баг, байгууллага, аж ахуйн нэгж болох хөдөлгөөн өрнүүлэн амжилтанд хүрцгээе.

8.Иргэдийн амар амгалан ажиллаж амьдрах нийгмийн дэг журмыг хангаж ёс зүйг төлөвшүүлэхэд шүүх, прокурор, цагдаа болон хууль, хяналтын байгууллагуудын ажлын шударга, эрч хүчтэй ажиллагаанаас шууд хамааралтай байх тул дээрхий байгууллагууд хүрсэн амжилтаа бататгаж илүү их амжилт бүтээлээр дүүрэн ажиллахыг онцлон тэмдэглэсэн байна.

Тус илтгэлийг аймгийн ИТХ-ын нутгийн удирдлага, хууль зүй, хүний эрхийн хороогоор хэлэлцээд Хурлын байнгын хороодыг идэвхижүүлэх, батлагдсан хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийх, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлж тавилга, тоноглол бэлтгэх зардлыг багасгах, шугам сүлжээ, орон сууц ашиглалтын конторын үйл ажиллагааг хэвийн байдалд оруулах, малчдын хөдөлмөр бүтээлийг үнэлж аймгийн сайн малчинг 25 болгож шалгаруулах тухай санал дүгнэлтийг хуралдаанд оруулжээ.

АЙМГИЙН ИТХ-ЫН ҮІ ХУРАЛДААНЫ

ТОГТООЛ

2010 оны 12 дугаар сарын 27-ны өдөр
Ховд

№ 6/04

“Их бүтээн байгуулалт – эрчимтэй хөгжлийн жил” болгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн зүйлийн 59 дүгээр зүйлийн 59.2, 62 дугаар зүйлийн 62.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалт, “Аймгийн ИТХ- аас 2010 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, цаашдын зорилтын тухай” аймгийн ИТХ- ын дарга Х.Батболдын илтгэлийг хэлэлцээд аймгийн ИТХ- ын ҮІ хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Аймгийн ИТХ- ын ҮІ хуралдаанд хэлэлцүүлсэн “Аймгийн ИТХ- аас 2010 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, цаашдын зорилтын тухай” ИТХ- ын дарга Х.Батболдын илтгэлд хийсэн дүгнэлт, дэвшүүлсэн зорилтыг сайшааж, аймгийн ИТХ- ын 2010 онд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

2. Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний 100, Ардын хувьсгалын 90, аймаг байгуулагдсаны 80 жилийн ой угтан 2011 оныг аймаг хэмжээнд “Их бүтээн байгуулалт – эрчимтэй хөгжлийн жил” болгон зарласугай.

3.Аймгийн ИТХ- ын дарга /Х.Батболд/, Засаг дарга /Г.Нямдаваа/ нарт үүрэг болгох нь:

1/ Аймгийн хэмжээнд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт дэвшүүлсэн зорилтоос хоцорч байгаад дүгнэлт хийж, “Их бүтээн байгуулалт – эрчимтэй хөгжлийн жил”-д хийх ажлыг аймаг, сум, баг, байгууллага, аж ахуйн нэгж бүрээр тодруулан тооцоолж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг хангах, аж үйлдвэрийн салбарыг хурдацтай хөгжүүлэн парк байгуулах иж бүрдлийг бий болгох, барилга хөрөнгө оруулалтыг эрчимтэй өсгөн, үр ашгийг нь дээшлүүлэх, үйлчилгээний төрөл хүртээмж чанарыг сайжруулахад онцгойлон анхаарч бодлогоо төвлөрүүлэн хэрэгжүүлэх

2/ Нийгмийн салбарын хөгжлийн хүрсэн түвшинг дээшлүүлэн сургуулийн хичээлийн байрны хүчин чадлыг нэмэгдүүлэх, дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчлэх, эмнэлгийн байгууллагуудын оношилогоо шинжилгээний тоног төхөөрөмжийн хүч чадлыг нэмэгдүүлэн, ашиглалтыг сайжруулж, эдгээр салбарын мэргэшсэн боловсон хүчний хангамжийг дээшлүүлэн үйл ажиллагааг сайжруулахад түлхүү анхаарал тавьж хэрэгжилтийг хангах

3/ “Их бүтээн байгуулалт – эрчимтэй хөгжлийн жил”-д иргэн, өрх, хамт олон, байгууллага, аж ахуйн нэгж, баг, сумын хийх ажлын даалгавар, чиглэлийг боловсруулан хүргүүлэхийн зэрэгцээ, Баруун бүсийн тулгуур төв - Ховд хотод асфальт бетон хучилттай зам барих, иргэдийн хашаа, гудамжны гэрэлтүүлэг, зохион байгуулалт, өнгө үзэмжийг сайжруулах ажлыг эрчимжүүлэн нийтийн эзэмшлийн зам талбай, байгууллагын орчим, айл, өрхийн хашаанд ойжуулах, мод тарих ажлыг аж ахуйн нэгж, иргэдэд хуваарилан тодорхой тоо, чанарын үзүүлэлт бүхий даалгавар гарган тэдэнд мэргэжлийн болон техникийн дэмжлэг үзүүлэх замаар Ховд хотын өнгө үзэмжийг эрс сайжруулан ногоон хот болгох

4. Аймгийн ИТХ-ын дарга /Х.Батболд/-д ДААЛГАХ нь:

1/ Аймгийн НӨУБайгууллагын ажилтан сонгуультны II зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэн сумын ИТХ, багийн ИНХ-ын үйл ажиллагаанд үзүүлэх мэргэжил арга зүйн удирдлага, туслалцааг нэмэгдүүлэн, сум багийн нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэн, чадавхижуулах, хурлын ажлын үр нөлөөг дээшлүүлэх, хариуцлагыг ухамсарлан бүтээлчээр ажилд хандаж сумын нийгэм эдийн засгийн хөгжилд болон иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд бодит ажлыг санаачлан хийдэг болгон хөгжүүлэх

2/ Байгаль экологийн доройтол нэмэгдэж цөлжилт идэвхжиж байгааг судлан аймаг, сум, багийн түвшинд хийх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөг иргэдийн тухайн шатны хурлаар хэлэлцүүлэн байгаль орчны доройтол, цаг уурын өөрчлөлтийн нөлөөллийн хохирлыг багасгах, байгалиа нөхөн сэргээх, ойжуулах, усны эх булгийг хамгаалах, нутаг бэлчээрийг малчид-иргэдийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалуулах арга хэмжээ авах

3/ Аймаг, сумын ИТХ-ын бүрэн эрхийн хугацаанд дэвшүүлсэн зорилтыг бүрэн биелүүлэхэд Төлөөлөгчдийн үйл ажиллагааг эрчимжүүлэн сум, аймгийн хөгжилд түлхэц үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх, хурлын байгууллагаар дамжуулан хөгжлийн бодлого тодорхойлох, хэрэгжүүлэхэд сонгогчдыг манлайлан ажиллуулахаар зохион байгуулах

4/ Иргэний боловсрол төлөвшлийн гол асуудал болох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах ойрын болон ирээдүйн зорилтыг тодорхойлон түүнийг хэрэгжүүлэх асуудлаар аймгийн зөвлөгөөн, сургалт, хэлэлцүүлгийг II улиралд багтаан зохион байгуулах

5/Аймаг, сум, багийн НӨУБ-д ажиллаж байгаа сонгуультнуудын мэргэжил, боловсролыг дээшлүүлэх, мэдлэг, мэдээллээр хангах сургалт семинарт хамруулах, туршлага судлуулах ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлэх

6/ Багийн ИНХ-ын дарга нарыг унаагаар хангах боломжийг судлан Тэргүүлэгчдэд танилцуулах

5. Сумын ИТХ-ын дарга, багийн ИНХ-ын дарга нарт зөвлөх нь:

1/ Аймгийн НӨУБайгууллагын ажилтан сонгуультны II зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэн орон нутагт хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөгжлийн болон тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд иргэн бүрийн оролцоог идэвхижүүлэн хүний хөгжлийг бий болгох талаар бодлогоо тодорхойлон хэрэгжүүлэх

2/ 2011 оныг “Амар тайван амьдралын төлөө хамтдаа” хөдөлгөөнийг олон нийтийн оролцоотой эрчимтэй зохион байгуулж, “Их бүтээн байгуулалт – эрчимтэй хөгжлийн жил” -ийн хүрээнд иргэн, хамт олны идэвхийг өрнүүлэн нөөц боломжиндоо тулгуурласан аж ахуйг өргөтгөх, үйлдвэрлэл үйлчилгээг нэмэгдүүлэх, өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, байгаль орчноо сэргээн хамгаалах, ажиллаж амьдрах орчноо сайжруулан тохижуулах зэрэг зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлж иргэн, айл өрхийн амьдралыг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах

ХУРЛЫН ДАРГА

Х.БАТБОЛД

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, аймгийн нийгэм эдийн засгийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн тухай” аймгийн Засаг дарга Г.Нямдаваа итгэлдээ Ирж буй түүхэн оныг угтаж аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг эрчимжүүлсэнээр хэрэгжүүлэх таатай боломж бүрдэж нийт дүнгээрээ 64,2 хувийн биелэлттэй байна.

Сар бүрийн 25-ны өдрийг “Иргэдээ сонсох өдөр” болгон зохион байгуулж иргэдтэй шууд харилцах 105 дугаарын утсыг нээн ажиллуулж аймгийн ЗДТГ-ын 5 хэлтэс, 16 сум, 18 байгууллага, 50 гаруй багийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийсэн байна.

Нийгмийн бодлогын хүрээнд 2010 онд шинээр 8 багт гэр цэцэрлэг олгон цэцэрлэгийн хамран сургалт 78,4 хувьд хүрч 23 сургуулийн 653 бүлэгт 19592 хүүхэд өдрөөр суралцан, 955 хүүхэд залуучууд эчнээ болон дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд хамаарагдаж бага

боловсролын хамран сургалт өмнөх оноос 1,8 хувиар нэмэгдэж 19 сургуулийг эмчтэй болгож, “Баруун бүсийн хүүхдүүд” урлагийн наадмыг зохион байгуулж 200 гаруй хүүхэд багачууд оролцож, математикийн улсын олимпиадыг акедемич, нэрт математикч Т.Жанлавын нэрэмжит болгон явуулж 160 гаруй багш, 350 гаруй сурагч оролцсон бөгөөд боловсролын салбарт шинэ барилга болон их засварт 4,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Зэрэг, Буянт сумын дотуур байр, Манхан сумын сургуулийн өргөтгөл, Мөст сумын сургуулийн барилгуудыг шинээр барьж, Чандмань, Эрдэнэбүрэн, Зэрэг, Булган сумын 1 дүгээр сургуулийн хичээлийн байр, Үенч сумын сургуулийн дотуур байр, Цэцэг, Дуут сумын цэцэрлэгийн барилгад их засвар хийж 27 цэцэрлэг, 2 сургуулийн гал тогоог цахилгаан тоног төхөөрөмжөөр ханган, 14 сургуульд компьютерийн лаборатори олгожээ.

Эрүүл мэндийн байгууллагууд 337,4 мянган хүнд үзлэг хийж, 20,5 мянган хүнийг хэвтэн эмчлүүлж хүүхдийн эндэгдэл болон халдварт өвчний гаралт буурсан байна. 14 сумын хүн эмнэлэг 2 буюу түүнээс дээш их эмчтэй болжээ.

Нийгмийн халамжийн хуулиудын хүрээнд халамжийн сангаас 2,1 тэрбум төгрөг, даатгалын сангаас 6,7 тэрбум төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, хүний хөгжлийн сангаас 7,1 тэрбум төгрөг тус тус олгожээ.

ДНБ-ний 114,2 тэрбум төгрөгт хүрч нэг хүнд 1382 төгрөг ногдож тайлангийн жилд 2,6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөө 0,3 тэрбум төгрөгөөр давж орон нутгийн урсгал зарлага 5,1 тэрбум төгрөг, улсын төсвийн байгууллагуудын санхүүжилтэнд 22,6 тэрбум төгрөг, нийт хөрөнгө оруулалтанд 17,8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн байна.

2010 онд үйлдвэрлэлийн салбарт 2,9 тэрбум төгрөгийн бүтээгдхүүн үйлдвэрлэж 3,7 тэрбум төгрөгийн борлуулт хийсэн байна. Газар тариалангийн салбарт 2654,4 га газарт тариалалт хийж 23,9 мянган тн ургац хурааж хөтөлбөрийн хүрээнд 175,6 га талбайд чацаргана тариалж 80 тн ургац хураасан байна. Мал аж ахуйн салбарт бий болсон хүндрэлийг богино хугацаанд арилгахаар бодлого тодорхойлон ажиллаж бэлчээр ашиглалтыг сайжруулахаар суулийн 2 жилд 36 худгийг шинээр гарган 14 сумын 80 цэгт усны хайгуулын ажлыг хийж 15,0 мянган га талбайг ашиглах боломж бүрдүүлжээ.

БНХАУ-ын Тайкешкен боомтоос хил хүртэлх 18,7 км ЦДАШ, хил-Булган сумын 35 кв-тын 50 км ЦДАШ ашиглалтанд орж Мянгад, Зэрэг, Мөнххайрхан сумын 04-ийн шугам шинэчилж, хотын дулааны тохируулгыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн, бохир, цэвэр усны шугамыг засварыг өргөтгөн 550 метр шугам шинээр татаж насос суурилуулсанаар даралтыг нэмэгдүүлж, 142 айлын орон сууц баригдаж ашиглалтанд орсон зэргээр үйлдвэрлэл дэд бүтэц, хүнс ХАА, байгаль орчны бодлогын хүрээнд 65,0 хувь, нийгмийн бодлогын хүрээнд 63,0 хувь, санхүү эдийн засгийн бодлогын хүрээнд 69,2 хувь, төрийн

байгуулалт эрх зүйн хүрээнд 64,0 хувь дунджаар 64,2 хувийн биелэлттэй байгааг тэмдэглэжээ.

2011 онд сургуулийн насны хүүхдийн хамран сургалтыг 97,5 хувьд, сургуулийн өмнөх насны хүүхдийн хамралтыг 75,0 хувьд, сургалтын стандарт хангалтыг 98,5 хувьд хүргэж Жаргалант суманд 320 хүүхдийн бага сургууль, Мөнххайрхан сумын сургуулийн спорт заал, Дөргөн сумын цэцэрлэг, Мөст сумын соёлын төвийн барилгыг ашиглалтанд оруулж, Прогресс сургуулийн 960 хүүхдийн суудалтай хичээлийн байр, Булган суманд 320 хүүхдийн хичээлийн байр, Мянгад сумын соёлын төвийн барилгын ажлыг эхлүүлэх, аймгийн төвд дулааны 2 дахь эх үүсвэрийг байгуулах ТЭЗҮ, зураг төсвийг бэлэн болгох, ЖДҮ-ийн сангаас 1,0 тэрбум төгрөгийн зээл олгох, Дарви, Жаргалант суманд гурилын, Буянт суманд цардуулын, Жаргалант суманд хүнсний ногоо боловсруулах үйлдвэр байгуулах, 1600-аас доошгүй ажлын байр бий болгох, 100 айлын орон сууц барьж ашиглалтанд оруулах, үйлдвэрлэл үйлчилгээг тогтворжуулан ДНБ-ийг 8,0 хувиар өсгөж нэг хүнд ногдох хэмжээг 2800 ам.долларт хүргэх зорилтуудыг дэвшүүлсэнийг илтгэсэн байна.

Аймгийн ИТХ-ын нийгмийн бодлого болон хүнс, ХАА, байгаль орчны хороогоор аймгийн Засаг даргын илтгэлийг хэлэлцээд ... Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хангалттай хэрэгжиж байна гэж дүгнээд түүхт ойннуудыг угтаж аялал жуучлалыг хөгжүүлэх, мал аж ахуйн салбарт учирсан хохиролыг бүрэн арилгах арга хэмжээ авах, хүнсний ногоо хадгалах зоорийг нэмэгдүүлэх, аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ордуудыг тогтоох, аймаг, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн хөрөнгө оруулалтыг хийх, нарийн мэргэшлийн 1 эмчийг жил бүр гадаадад сургах зэрэг асуудлуудыг шийдвэрлэх нь зүйтэй гэсэн саналуудыг хуралдаанд оруулсан байна.

Мөн МАН-ын бүлгээс Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хангалттай хэрэгжиж байгааг дүгнээд цаашид хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх, ой угтаж хотын өнгө үзэмжийг сайжруулах хөрөнгө оруулалт хийх, иргэний нийгмийн байгууллагаар төрийн зарим чиг үүрэгийг гүйцэтгүүлэх, ДНБ-ийн нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, боловсрол, эрүүл мэндийн салбарт хийгдэх хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөх, эмнэлгийн байгууллагын тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан мэргэжилтэнүүдийг давтан сургахад анхаарч ажиллахыг санал болгосон байна.

Хуралдааны “Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2010 оны Үндсэн чиглэлийн биелэлтэнд үнэлэлт өгөх тухай” 6/5 тогтоолоор Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, 2010 онд аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэж 2010 оныг “Их бүтээн байгуулалт-эрчимтэй хөгжлийн жил” болгон зарласан байна.

Хуралдаанд Аймгийн ЗДТГ-ын санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Д.Алтангэрэл “Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэх тухай” илтгэлдээ ... Монгол Улсын Их Хурлаас авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татварын хуулинд өөрчлөлт оруулж баталсан хязгаарт багтаан аймгийн ИТХ-аас татварын хувь хэмжээг батлахаар хуульчилсаны дагуу татварын ногдуулалт, төлөлтийн суурь судалгаа, орлого олох ажил үйлчилгээний нөхцөлийг харгалзан татварын хэмжээг тогтоохоор төсөл оруулж байгаа ба тус төслөөр суудлын авто машины татварын хэмжээ жилдээ 6,0-15,0 мянган төгрөгөөр, ачааны авто машин даацаас шалтгаалан 5,0-30,0 мянган төгрөгөөр нэмэгдэж байгааг тэмдэглэсэн байна.

Хуралдааны “Татварын хэмжээг өөрчлөн тогтоох тухай” 6/06 тогтоолоор Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татварын жилийн албан татварын хэмжээг тогтоож 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөхөөр баталсан байна.

Аймгийн төсвийн 2010 оны урьдчилсан гүйцэтгэл, 2011 оны төсөл, 2009 оны гүйцэтгэлийн тухай аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү, эдийн засгийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Д.Алтангэрэл илтгэлдээ . . . Монгол улсын эдийн засаг дахь сэргэлт аймгийн санхүүгийн байдалд тааламжтай нөхцөлийг бий болгосоноор нийт аж ахуйн нэгжүүд 26,8 тэрбум төгрөгийн борлуулалт хийж 130,5 сая төгрөгийн ашигтай ажиллаж санхүүгийн сахилга дээшилсэнээр орон нутгийн төсөвт 2,8 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлээс 3,0 тэрбум төгрөгийн орлого, улсын төсөвт 0,6 тэрбум төгрөгийн орлого оруулахаас 0,6 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж орон нутгийн урсгал зарлага 5,0 тэрбум төгрөг, орон нутгийн улсын төсөвт байгууллагуудын зарлага 22,6 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Тайлангийн хугацаанд орон нутгийн замын сангийн хөрөнгөөр 155,0 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 484,2 сая төгрөг, улсын төсөв болон бусад хөрөнгийн эх үүсвэрээр 19,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгджээ, . 2010 онд төсвийн байгууллагуудын ажиллагсадын цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбогдон орсон өөрчлөлтөөр орон нутгийн төсөвт 482,6 сая төгрөгийн, улсын төсөвт байгууллагуудад 1,3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Орон нутгийн төсөвт 2011 онд 6,2 тэрбум төгрөгийн орлого олж орон нутгийн төсөв 6,2 тэрбум төгрөг, улсын төсөвт байгууллагууд 26,2 тэрбум төгрөг зарцуулахаар, хөрөнгө оруулалт орон нутгийн төсвөс 0,8 тэрбум төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 19,3 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн саналыг хуралдаанд оруулж байгааг илтгэсэн байна.

Аймгийн Ерөнхий аудитор Ч.Цэрэнчимэд “Аудитын газрын 2010 оны ажлын тайлан, орон нутгийн 2011 оны төсвийн төсөлд болон төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх талаар өгөх саналын тухай” илтгэлдээ . . . аймгийн ИТХ-д 315 бүтээгдхүүн нийлүүлэхээс 330 бүтээгдхүүн нийлүүлж 133, хувийн

аудитын байгууллагууд 24 нийт 157 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулах явцад 14,3 тэрбум төгрөгийн алдаа илэрүүлж 76 тайлан “Зөрчилгүй санал дүгнэлт”, 78 тайлан “Хязгаарлалттай санал дүгнэлт”, 3 тайлан нь “Сөрөг санал дүгнэлт”, өгч тайлангийн жилд 9 сум, 44 төсөвт байгууллагад гүйцэтгэлийн аудит хийж 634,4 сая төгрөгийн зөрчил төлбөр илэрүүлсэнээс 123,9 сая төгрөгийн төлбөр, 510,5 сая төгрөгийн зөрчил тооцогдсон байна. Гүйцэтгэлийн аудитаар аудитор шинжээчдийн 54 тайлан, 242 заалт бүхий 49 зөвлөмж, 161 акт 73 албан шаардлага бичигдсэн байна. 2011 онд орон нутгийн төсвийн орлогыг газрын төлбөрийг 47,5 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлогыг 5,5 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалыг 8,0 сая төгрөгөөр, нэр зааж ангилагдаагүй зардлыг 50,0 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын орлогыг 20,0 сая төгрөгөөр, байгалийн нөөц ашигласаны төлбөрийг 42,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зарцуулах, мөн оны эцсийн татварын өрийг барагдуулж төсвийн өрийг барагдуулах, орон нутгийн төсөвт байгууллагуудын удирдлагын хувьсах зардлыг 105,6 сая төгрөгөөр хорогдуулах, бараа ажил үйлчилгээ худалдан авах зардлын өгөөжийг нэмэгдүүлсэнээр 20,0 сая төгрөгийн эх үүсвэрийг сайжруулах, 2010 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмнэлт 44,8 сая төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэмнэлт 18,1 сая төгрөгөөр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төсвийн захирагчдаас нийлүүлэх бүтээгдхүүний зардлыг хэмнэж 20,0 сая төгрөгийн нэмэлт бүтээгдхүүнд зарцуулах, хөрөнгө оруулалтын хамтын сангаас төлөгдөөгүй байгаа хугацаа хэтэрсэн 122,7 сая төгрөгийг төлүүлэн үйлдвэрлэл үйлчилгээг нэмэгдүүлэхэд зарцуулах, 2009 оны төлөвлөгөөнөөс давах тооцоотой 756,7 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн томоохон хөрөнгө оруулалтанд зарцуулах санал дүгнэлтийг оруулсан байна.

Аймгийн ИТХ-ын эдийн засгийн хороогоор “Аймгийн 2010 оны төсөвт оруулах нэмэлт өөрчлөлт, төсвийн жилийн урьдчилсан дүн, 2011 төсвийн төсөл, 2009 оны төсвийн гүйцэтгэлийн тухай”, “Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татварын хэмжээг батлах тухай” “Аудитын газрын 2010 оны ажлын тайлан, орон нутгийн 2011 оны төсвийн төсөлд болон төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх талаар өгөх саналын тухай” илтгэлийг хэлэлцээд хуралдаанд хэлэлцүүлэхийг дэмжих, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татварын хэмжээг батлах тухай тогтоолын төсөлд мотоциклийн татварыг төлөвлөсөнөөс 500 төгрөгөөр нэмэгдүүлэх, 40,0 тн-оос дээшхи даацтай машины татварыг нэмэгдүүлэхийг судалж дараагийн хуралдаанд оруулах, орон нутгийн орлого нэмэгдүүлэх эх үүсвэрийг бүрэн дүүрэн ашиглах, үйлдвэрлэл үйлчилгээг бий болгоход чиглэсэн хөрөнгө оруулалтыг бий болгох, аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг тохиолдуулан аймгаа сурталчилах, төсвийн үр дүнгээр төсөв захирагчдыг урамшуулах, хариуцлага тооцох, төсвийн менежерүүд төсвийн болзошгүй эрсдэлээс

урьдчилан сэргийлэхээр ажлаа зохион байгуулах зэрэг санал дүгнэлтийг хуралдаанд оруулжээ.

Хуралдаанаас “Орон нутгийн төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай 6/07 дугаар тогтоолоор нийт орлогыг доод хязгаарыг 1243,3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 482652,5 мянган төгрөгөөр, сумдад олгох дэмжлэгийг 148638,1 мянган төгрөгөөр тус нэмэгдүүлжээ. Мөн дүгнэлт өгөх тухай 6/08 дугаар тогтоолоор эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Засаг даргатай 2010 онд нийлүүлэх бүтээгдхүүний санхүүжилтийг 1296389,1 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэнийг дэмжсэн байна.

“Орон нутгийн 2011 оны төсөв батлах тухай” 6/09 тогтоолоор аймгийн 2011 оны төсвийн орлогын доод хязгаарыг 5,4 тэрбум төгрөгөөр үүнээс татварын орлого 5,1 тэрбум төгрөг, нийт зарлагыг 6,2 тэрбум төгрөгөөр үүнээс цалингийн зарлага 2,8 тэрбум, хөрөнгө оруулалт 966,0 сая төгрөг, сумдын орлогын доод хязгаар 2,4 тэрбум төгрөг, санхүүгийн дэмжлэгийг 1,6 тэрбум төгрөг, сумдаас татан төвлөрүүлэх орлогыг 336,5 сая төгрөгөөр тус тус баталжээ. Мөн дүгнэл өгөх тухай 6/10 дугаар тогтоолоор эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Засаг даргатай 2010 онд нийлүүлэх бүтээгдхүүний санхүүжилтийг 24,0 тэрбум төгрөгөөр сайшаан дэмжсэн байна. Орон нутгийн төсвийн 2009 оны гүйцэтгэл батлах тухай 6/11 тогтоолоор төсвийн нийт орлогыг 3,4 тэрбум төгрөгөөр, зарлагыг 3,9 тэрбум төгрөгөөр баталсан байна.

Аудитын газрын даргын илтгэлийг хэлэлцээд тайланд үнэлэлт өгч санал дэмжих тухай 6/12 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын эдийн засгийн хорооны дүгнэлтийг үндэслэн аймгийн аудитын газар нь 2010 онд хууль эрх зүйн хүрээнд ажил үүргээ “Хангалттай сайн” биелүүлсэн байна дүгнэжээ.

“Аймгийн газар зохион байгуулалтын 2010 он төлөвлөгөөний биелэлт, 2011 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тухай” аймгийн ГХБХБГ-ын дарга У.Батзаяа илтгэлдээ ... аймгийн хэмжээнд газар өмчлүүлэх, ашиглах талаар иргэдээс 1832 өргөдөл ирүүлсэний 1832 өргөдлийг шийдвэрлэж 8007 иргэнд 1166,3 га газрыг үнэгүйгээр, 1 иргэнд 2 га газрыг тариалангийн зориулалтаар, 11685 иргэнд 71208,11 га, 195 төрийн байгууллагад 594,59 га, 415 аж ахуйн нэгжид 3823,53 га газрыг эзэмшүүлсэн, 119 иргэнд 54,11 га, 13 аж ахуйн нэгжид 3,5 га газрыг тус тус ашиглуулсан байна.

Газрын төлбөрөөр 2010 онд 52,9 сая төгрөг оруулахаас 58,5 сая төгрөг оруулжээ. Аймгийн дүнгээр 112643,7 га газар сөрөг нөлөөлөлд өртсөний 55494,0 га талхлагдсан, 56123,0 га мэрэгчдэд идэгдсэн, 1024,4 га газар бусад тохиолдолоор сөрөг нөлөөлөлд өртсөн байна.

Жаргалант сумын хэмжээнд нийт 302 зөрчил маргаан байгаагийн 155 нь амбаар, контейнер, 75 граж, 12 тор, 50 хашаа, 10 нь зөвшөөрөлгүй газрын илүү сунгалт хийсэн байгаагаас 46 зөрчил бүрэн шийдвэрлэгдсэн байна.

Аймгийн газар зохион байгуулалтын 2011 оны төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгжид үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлэх газрыг 74,93 га, гэр бүлийн хэрэгцээний өмчлүүлэх газрыг 568,88 га, гэр бүлийн хэрэгцээнд болон аж ахуйн нэгж байгуулагын байгууллагад төмс, хүнсний ногоо таримал ургамал тариалахад эзэмшүүлэх газрыг 381,20 га, төсөвт байгууллагын зайлашгүй хэрэгцээнд зориулан эзэмшүүлэх газрыг 14,50 га, зам шуга сүлжээний зориулалтаар ашиглуулах газрыг 1033,0 га, эрчимжсэн мал аж ахуйн зориулалтаар эзэмшүүлэх газрыг 89,5 га, ойжуулалт, жимс жимсгэнэ тариалах зориулалтаар эзэмшүүлэх газрыг 793,94 га, газрыг элэгдэл, эвдрэл, доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх газар 1181,70 га, байхаар төлөвлөгөөний саналыг илтгэсэн байна.

Тус илтгэлтэй холбогдуулан аймгийн ИТХ-ын үйлдвэрлэл дэд бүтэц, хот хот байгуулалтын хорооноос хэлэлцээд ажил үүргийн хүрээнд тодорхой ажлуудыг зохион байгуулсан боловч газрын төлбөрийг бүрэн аваагүй, бэлчээр ашиглалтаар авах арга хэмжээ бүрэн хэрэгжээгүйг тэмдэглээд газрын 302 зөрчил марганыг 2 үе шаттай бүрэн арилгах, Буянт сумын нарийн гол багийн 100 га, Ховд сумын 2 иргэний 2000 га газрыг төлөвлөлтөөс хасах, сумдын хилийн заагт газар олгож байгааг таслан зогсоох, дуудлагын худалдаагаар худалдах газрыг эртнээс төлөвлөн нийтэд ил тод мэдээлэх, 3 дугаар 10 жилийн сургуулийн багш нарын орон сууц барих газрыг олгох зэрэг асуудлуудыг тусгахыг хуралдаанд санал болгосон байна. Илтгэлийг хэлэлцээд “Газар зохион байгуулалтын 2011 оны ерөнхий төлөвлөгөө батлах тухай” 6/13 дугаар тогтоолоор 2011 оны төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгжид үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлэх газрыг 74,93 га, гэр бүлийн хэрэгцээний өмчлүүлэх газрыг 568,88 га, гэр бүлийн хэрэгцээнд болон аж ахуйн нэгж байгуулагын байгууллагад төмс, хүнсний ногоо таримал ургамал тариалахад эзэмшүүлэх газрыг 381,20 га, төсөвт байгууллагын зайлашгүй хэрэгцээнд зориулан эзэмшүүлэх газрыг 14,50 га, зам шуга сүлжээний зориулалтаар ашиглуулах газрыг 1033,0 га, эрчимжсэн мал аж ахуйн зориулалтаар эзэмшүүлэх газрыг 89,5 га, ойжуулалт, жимс жимсгэнэ тариалах зориулалтаар эзэмшүүлэх газрыг 793,94 га, газрыг элэгдэл, эвдрэл, доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх газар 1181,70 га, байхаар төлөвлөгөөг баталсан байна.

Хуралдаанаас байнгын хорооны бүрэлдхүүнд өөрчлөлт оруулах тухай 6/14 дугаар тогтоолоор нийгмийн бодлогын хорооны бүрэлдхүүнд А.Батмөнхийг, эдийн засгийн хорооны бүрэлдхүүнд Ц.Бат-эрдэнэ, Х.Болдбаатар, Хүнс, ХАА, байгаль орчны хорооны бүрэлдхүүнд даргаар А.Хишигсүрэн, гишүүнээр Х.Болдбаатар, үйлдвэрлэл, дэд бүтэц, хот байгуулалтын хорооны бүрэлдхүүнд Ц.Бат-эрдэнэ нарыг оролцуулан баталсан байна.

НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН,
СОНГУУЛЬТАНУУДЫН, АЙМГИЙН III ЗӨВЛӨГӨӨНИЙ
ЗӨВЛӨМЖ

Ховд аймгийн Нутгийн өөрөө удирдах байгууллагын ажилтан, сонгуультануудын, аймгийн III зөвлөгөөнөөр “НӨУБ-уудын шинэчлэл, цаашдын зорилтын тухай” аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Ч.Багдал, НӨУБ-Нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагааг боловсронгуй болгох тухай аймгийн Засаг дарга Г.Нямдаваагийн илтгэлийг хэлэлцээд зөвлөгөөнд оролцсон төлөөлөгчдийн гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн цаашид НӨУБ-ыг төлөвшүүлэн хөгжүүлэх зорилгоор дараах зөвлөмжийг гаргаж байна.

1.ИТХ, хурлын хороод, Тэргүүлэгчдийн ажлыг орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хууль тогтоомж, өөрийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд төвлөрүүлэн, зохион байгуулж, үр дүнг тухай бүр тооцдог болгон хэвшүүлэх.

2.Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн хугацаанд хийх ажлын үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг хангаснаар амьдрах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлж, төгөлдөржүүлэн, айл өрх бүрийг эдийн засаг, аж ахуйгаа бие дааж авч явах чадвартай болгож хөгжүүлэх, иргэдийн оюуны чадавх үнэлэмжийг дээшлүүлэх.

3.Бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, НӨУБ-ын ажилтан сонгуультны мэдлэг, мэдээллийг олон түмний санаа бодол, эрэлт хэрэгцээг судлан тусгаж, түүнийгээ сурталчлан мэдээлэх, биелэлтийг хангахад идэвхтэй оролцуулан, иргэд сонгогчтой ажиллах нөхцөлийг бүрдүүлж харилцааны амьд эргэх холбоог бий болгон тогтмолжуулах.

4.Нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэн шинэ санаачлага, дэвшилттэй ажлын арга барилыг харилцан мэдээлж, судлан өөрийн онцлогт тохируулан нэвтрүүлэх.

5.Нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааг оновчтой зохион байгуулж, Хурлын зүгээс тавих хяналтыг тогтмолжуулж, төрийн үйлчилгээний нээлттэй, хөнгөн шуурхай, чирэгдэлгүй, хүртээмжтэй байх зохион байгуулалтын оновчтой хэлбэрт шилжиж, албан тушаалтнуудын ажил хариуцах чадварыг эрс дээшлүүлэн, хариуцлага тооцох механизмыг боловсронгуй болгон хэвшүүлэх.

6.НӨУБ бүр иргэдийг суурь боловсролтой, эрүүл саруул, бүтээлч сэтгэлгээтэй, хөдөлмөрийн хамтын зохион байгуулалтаар эдийн засаг, аж ахуйгаа хөгжүүлэн, амьдралын баталгаагаа хангах бодлогыг тодорхойлон хэрэгжүүлж, хүмүүсийн амьдралын хандлагыг өөрчлөн олон үндэстэн, ястны уламжлалт соёл, зан заншлыг хамгаалан хөгжүүлж, хойч үедээ сургаж өвлүүлэн,иргэдийн нийгмийн сэтгэл зүй, аж төрөх ёсыг зөв төлөвшүүлэн хөгжүүлэх.

7.НӨУБ-аас гарах аливаа шийдвэр нь нутгийн ард иргэдийн ая тухтай ажиллаж, амьдрах орчин болон байгаль экологид сөрөг нөлөөгүй, хүнээ хөгжүүлж, эрх ашгийг нь

хамгаалсан, хөгжлийг бий болгохуйц эрх зүйн оновчтой зохицуулалттай байх зарчмыг тууштай баримтлан ажиллах.

8.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх нийтийн үйл хэрэг болгон, иргэдэд төрийн хуулийг хүндэтгэн, сахин биелүүлэх сэтгэлгээг төлөвшүүлэн, гэмт хэрэг, хэв журмын зөрчилгүй баг, хамт олон болох хөдөлгөөн өрнүүлэн, тэдний туршлагыг нийтэд түгээн дэлгэрүүлэх.

9.НӨУБ, төрийн бус, иргэний нийгмийн байгууллагын түншлэл, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж, төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх замаар хамтран ажиллаж, чадавхжуулан төлөвшихөд дэмжлэг үзүүлж, уялдаа холбоог сайжруулах талаар санаачлагатай ажиллах.

АЙМГИЙН III ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦОГСОД

Аймгийн ИТХ-ын 7 дугаар хуралдаан

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 5 дугаар сарын 30-ний өдрийн 66 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын 7 дугаар хуралдааныг 2011 оны 6 дугаар сарын 27-ний өдөр Ховд хотод хуралдуулж “Бүтээн байгуулалт-эрчимтэй хөгжлийн жил”-ийн ажлын явц, үр дүн, аймагт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтуудын үр дүн, гүйцэтгэлд тавих хяналт, цаашдын бодлогын тухай аймгийн Засаг дарга Г.Нямдаваагийн илтгэл, аймгийн газар зохион байгуулалтын 2011 оны ерөнхий төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай илтгэлийг тус тус хэлэлцэхээр товлон зарласан байна.

Хуралдаан аймгийн ИТХ-ын 2008 оны 2 дугаар хуралдаанаас баталсан байнгын дэгийг мөрдөж хуралдсан байна.

Төлөөлөгчдийн 100,0 хувийн саналаар хэлэлцэх асуудал, дотоод журам, ажлын албыг 2 дугаар тогтоолоор баталж хуралдааны ажлын албаны нарийн бичгийн даргаар Б.Баярсүх, С.Саранбаатар аймгийн ИТХ-ын Ажлын албаны ажилтан, У.Цэрэнтогтох аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн ажилтан, редакцийн комиссоор Б.Энхтуяа аймгийн ИТХ-ын Ажлын албаны ахлах ажилтан, Ч.Улаанхүү Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр Б.Сандагсүрэн аймгийн ИТХ-ын Ажлын албаны ажилтан нар ажилласан байна.

Хуралдаанаас гарах шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Багдалаар ахлуулсан 9 хүний бүрэлдхүүнтэй байгуулсан байна.

Аймгийн засаг дарга “Бүтээн байгуулалт-эрчимтэй хөгжлийн жил”-ийн ажлын явц, үр дүн, аймагт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтуудын үр дүн, гүйцэтгэлд тавих хяналт, цаашдын бодлогын тухай” илтгэлдээ ... Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний 100 жил, Ардын хувьсгалын 90 жил, аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг угтаж орон нутгийн хөгжилд түлхэц болохуйц бүтээлч ажлууд эрчимтэй өрнөж байна.

Мал аж хуйн салбарт өсөлт бий болж 585,8 мянган төл бойжуулж, МАА-н үйлдвэрлэлээс 6,0 мянган тн мах, 300,0 мянган ширхэг арьс, 270 тн ноолуур, 600,0 мянган тн ноос авч түүхий эдийн үнэ өндөр байгаа нь малчдын ахуй амьдралд тааламжтай орчин бүрдэж газар тариалангийн салбарт нийт 2599,1 га талбайд тариалалт хийсэн байна.

Аймгийн хэмжээд 2011 онд 178,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг эхлүүсэнээс 73,7 тэрбум төгрөг нь энэ онд хийгдэх бүтээн байгуулалтын ажил бөгөөд улсын төсвөөс 41, орон нутгийн төсвөөс 53 төсөл арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөсөнөөс 24 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж 29 төсөл арга хэмжээ хэрэгжих шатандаа байна. Үүнд баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг сайжруулах төслөөр Ховд-Манхан чиглэлийн 85,3 км, Тэмээн хүзүү-Бага улаан даваа чиглэлийн 110,8 км, хэвтээ тэнхлэгийн Манхан-Дарви чиглэлийн 100 км хатуу хучилттай авто зам, аймгийн төвийн авто замын шинэчлэл, нийтдээ 300 км ажлыг эхлүүлжээ.

Аймгийн төвийн авто замыг шинэчлэн сайжруулах, явган хүний зам шинээр хийхэд 1200,0 сая төгрөг, бага гүүрээс стадион хүртэлх зам, баруун бүсийн соёл амралтын хүрээлэнг байгуулахад 4,0 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж тендерийг шалгаруулсан байна. Ашиглалтанд оруулахаар төлөвлөгдсөн Жаргалант сумын 320 хүүхдийн сургуулийн барилга, Мөнххайрхан сумын спорт заал, Ахмадын өргөөний барилга, Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтийн ажлыг ойрын хугацаанд ашиглалтанд оруулах шаардлагатай байна. Бүтээн байгуулалтын ажлын хүрээнд аймгийн ДНБ 10,0 хувиар өсч 15,0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж нийт 2412 ажлын байр бий болохоос 751 ажлын байр бий болоод байна.

ЖДҮ-ийн сангаас олгосон 2,2 тэрбум төгрөгийн зээлийн хөрөнгөөр 39 ЖДҮ, цех шинээр байгуулагдаж, 151 иргэн, ААН үйл ажиллагааг өргөтгөж 279 ажлын байр шинээр бий болж 450 ажлын байр хадгалагдсан байна.

Цаашид хөрөнгө оруулалтын дутагдаж буй эх үүсвэрийг яаралтай шийдвэрлэх, хэрэгжиж буй ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, эрх бүхий байгууллагуудын ажлыг уялдуулах, ойг угтсан салбар хороодын ажлыг эрчимжүүлэх, төвлөрүүлэх хандив тусламжийг төвлөрүүлэх, төсөвт байгууллага айл өрх бүр тохжилтын ажлыг гүйцэтгэх, бүтээн байгуулалтын ажлын явцад бэрхшээл учруулж болзошгүй бензин шатахууны хангамжийг нэмэгдүүлэх, орон нутгийн зарим эрх мэдлийг өргөтгөх зэрэг ажлуудыг шийдвэрлэх шаардлагатай байгааг илтгэлдээ тэмдэглэсэн байна.

7 ДУГААР ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

Хөрөнгө оруулалтын үр ашгийг
дээшлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “д”, 19 дүгээр зүйлийн 19,1 дэх заалтыг тус тус

үндэслэн, аймгийн Засаг дарга Г.Нямдаваагийн “Их бүтээн байгуулалт-Эрчимтэй хөгжлийн жил”-ийн ажлын явц, аймагт хийгдэж буй хөрөнгө оруулалтын үр дүн, гүйцэтгэлд тавих хяналт, цаашдын зорилтын тухай илтгэлийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг дарга /Г.Нямдаваа/-д ДААЛГАХ нь

1.Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний 100, Ардын хувьсгалын 90, аймаг байгуулагдсаны 80 жилийн ой угтсан “Их бүтээн байгуулалт-эрчимтэй хөгжлийн жил”-ийн бүтээлч ажлын явц болон зарим хэрэгжилт нь удаашралтай хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэн, түүний гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналтыг өндөржүүлж, гүйцэтгэгчтэй байгуулсан бараа, ажил үйлчилгээг гүйцэтгэх гэрээний цаг хугацааны мөрдөлтийг хатуу баримталж чанарын өндөр түвшинд гүйцэтгүүлж хүлээн авах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

2.Аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, үндсэн хөрөнгийн ашиглалтыг уртасгах зорилгоор нийт төсөвт болон орон нутгийн өмчийн байгууллагуудын бүртгэлд буй үндсэн хөрөнгийн ашиглалтын насжилт, тухайн хөрөнгийн хөдлөлт, өөрчлөлтийг тогтоож, их засвар, шинээр хөрөнгө оруулалт хийх, ашиглалтаас хасахад харгалзах үзүүлэлт болгон ашиглаж хэвшүүлэх

3.Аймгийн эдийн засаг, нийгмийн салбар бүрт нэн шаардлагатай хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтыг зохих хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж нийтэд зарлан дараа төлбөрт тооцоогоор урьдчилсан гэрээгээр гүйцэтгүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх

4.Төсөл, хөтөлбөрүүд болон хувийн хэвшлийн байгууллагуудын хийж буй хөрөнгө оруулалтын ажилд батлагдсан бараа, ажил, үйлчилгээний батлагдсан стандарт, норм, нормативыг мөрдүүлэхэд арга зүйн тусламж үзүүлж түүний хэрэгжилтэнд тавих хяналтыг хэрэгжүүлэх.

5.Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тендерийн шалгаруулалтын ажлыг нийтэд улам нээлттэй болгож тухайн ажлын гүйцэтгэлийн чанар, стандартын нөхцөлийг хангуулахад захиалагчаас тавих хяналтыг эрс өндөржүүлэх

6.Бараа ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны тендерт шалгарсан гүйцэтгэгч байгууллагуудаас гүйцэтгэсэн ажил үйлчилгээг хүлээлгэн өгсөний дараа ашиглалтын явцад гарсан захиалагч, хэрэглэгчийн гомдлыг тухай бүр мэргэжлийн эрх бүхий байгууллагуудын оролцоотой шалган дүгнэлт гарган шийдвэрлэж шаардлагатай тохиолдолд хангалтгүй гүйцэтгэсэн ажил үйлчилгээг дахин хийлгэж хүлээж авдаг журам тогтоож, нэмэлт ажил үйлчилгээг гүйцэтгээгүй, гүйцэтгэсэн ажил үйлчилгээндээ батлагдсан стандарт, норм нормативийг зөрчсөн, дээрхи зөрчил дутагдлыг давтан гаргасан аж ахуйн нэгж,

байгууллагуудыг тухайн дутагдлыг арилгах хүртэл дараагийн тендерийн шалгаруулалтанд оруулахгүй байх арга хэмжээ авах.

7.Тендерт шалгарсан гүйцэтгэгчийн тухайн хөрөнгө оруулалт бараа, ажил үйлчилгээний засвар, үйлчилгээнд ашиглаж буй материал нь хүний эрүүл ахуй, байгаль орчны нөлөөллийн стандарт үзүүлэлт, шаардлагыг хангаж байгаа байдалд тавих хяналтыг сайжруулан холбогдох мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа, зохион байгуулалтыг хангаж, гүйцэтгэлийн явцын болон хүлээж авах үеийн хяналт, хариуцлагыг өндөржүүлж дээрхи ажиллагаанд алдаа гаргасан холбогдох албан тушаалтанд тооцох хариуцлагыг чангатгах.

8. Тухайн санхүүгийн жилд зураг, төсөв нь хийгдэж батлагдаагүй, баригдах газрын асуудал шийдэгдээгүй барилга объектыг хөрөнгө оруулалтанд санхүүжилт төлөвлөх, урьдчилан тендер зарлан шалгаруулах ажиллагаа явуулахгүй байх арга хэмжээ авах

9.Хөшөөтийн уурхайн төслийн хэрэгжилтийг түргэтгэж, хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний биелэлтийг хангах ажлыг эрчимжүүлэн МоЭнКо компаниас орон нутгийн төсөвт төлөх орлогыг бүрэн төвлөрүүлэн санхүүжилтийн эх үүсвэрийг хангаж ажиллах.

Хоёр. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлын явц, үр дүнг тухай бүр хэлэлцэж гүйцэтгэлийг эрчимжүүлж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

Гурав. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангуулж биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Ч.Багдал/, Засаг даргын Тамгын газрын дарга /Л.Батбаяр/ нарт хариуцуулсугай.

ХУРЛЫН ДАРГА

Х.БАТБОЛД

Аймгийн 2011 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай аймгийн ГХБХБГ-ын дарга У.Батзаяа илтгэлдээ ... аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтын бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэх, газрын дуудлагын худалдаа мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр явагдаагүй зэргээс шалтгаалан төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарсан байна.

Газрын албанаас маргаантай болон зөрчилтэй газрыг зохих журмаар цэгцлэх, газрын төлбөрийг шуурхай төвлөрүүлэх болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 2011 оны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд иргэн, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэх 73,03 га газрыг 26,0 га болгох, иргэн, аж ахуйн нэгжид үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлэх газрыг 5,54 га-гаар нэмэгдүүлэх, төсөвт байгууллагын зайлашгүй хэрэгцээнд зориулан эзэмшүүлэх газрыг 216,7 га бологож нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хуралдаанд илтгэсэн байна.

Тус илтгэлтэй холбогдуулан аймгийн ИТХ-ын үйлдвэрлэл, дэд бүтэц, хот байгуулалтын хорооноос хэлэлцээд иргэн, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэх газрыг 47,0 га-гаар бууруулах, Буянт сумын нутаг дэвсгэрт 200 га газарт оюутаны хотхон барих санал дээр сумаас санал авах, Буянт суманд гэр бүлийн хэрэгцээнд олгох 2500 га газрын талаар сумын иргэдээс санал авах, Хөшөөтийн уурхайн тээвэрлэж буй нүүрсийг сэлгэн ачиж буулгах талбайг Булган сумын Матагарын хөдөөд байгуулах, голомт банкинд олгох 0,0374 га газрыг дуудлагын худалдаагаар олгох, цэвэр усны станцаас дээш болон Бугат үзүүрээс доош газар торлож байгааг зогсоох арга хэмжээ авах, газрын зөрчил арилгах үүрэгийг бүрэн биелүүлээгүй тул шуурхай ажиллах тухай саналыг хуралдаанд оруулсан байна.

Илтгэлийг хэлэлцээд “Төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 7/03 дугаар тогтоолоор 2011 оны төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгжид үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлэх газрыг 74,93 га газрыг 0,5374 га-гаар нэмэгдүүлж Булган сумын Алагтолгой гэсэнийг Булган сумын Матагарын хөдөө гэж өөрчлөх, гэр бүлийн хэрэгцээний өмчлүүлэх газрыг 568,88 га газрыг 26,00 га болгон бууруулж, гэр бүлийн хэрэгцээнд болон аж ахуйн нэгж байгууллагын байгууллагад төмс, хүнсний ногоо таримал ургамал тариалахад эзэмшүүлэх газрыг 381,20 га газрыг 2500,0 га-гаар нэмэгдүүлэх, төсөвт байгууллагын зайлашгүй хэрэгцээнд зориулан эзэмшүүлэх 14,50 га газрыг 217,133 га-гаар нэмэгдүүлэн төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлтийг баталсан байна.

Тус 7 дугаар хуралдаанд 31 төлөөлөгчийн 29 буюу 96,6 хувийн ирцтэй хуралдаж 69 хүн урилгаар оролцсоноос 57 хүн төсвийн байгууллагын ажилтан, 12 иргэн оролцож 17 хүн үг хэлж 2 асуудал хэлэлцэн 3 тогтоол баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 8 дугаар хуралдаан

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 11 дүгээр сарын 07-ний өдрийн 129 дүгээр тогтоолоор аймгийн ИТХ-ын 8 дугаар хуралдааныг 12 дугаар сарын 2-ны өдөр хуралдуулж

1. “Аймаг, сумын Засаг дарга харьяалагдах нутаг дэвсгэр дахь төрийн захиргааны байгууллагуудаас зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох тухай” илтгэл

2. “Аймгийн 2011 оны төсөвт оруулах нэмэлт өөрчлөлт тухай” итгэлийг хэлэлцэхээр товлон зарласан байна.

Хуралдаанд үйлчлэх ажлын албаны нарийн бичгийн даргаар аймгийн ИТХ-ын Ажлын албаны ажилтан Б.Баярсүх, У.Цэрэнтогтох, аймгийн Аудитын газрын аудитор Н.Дэмбэрэлдорж, редакцийн комиссоор Б.Энхтуяа аймгийн ИТХ-ын Ажлын албаны ахлах ажилтан, Ч.Улаанхүү аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн ажилтан, тэмдэглэл хөтлөгчөөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны ажилтан Б.Сандагсүрэн нар ажилласан байна.

Хуралдаанаас гарах шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Багдалаар ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Д.Алтангэрэл “Аймаг, сумын Засаг даргад харьяалагдах нутаг дэвсгэр дахь төрийн захиргааны байгууллагуудаас зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох тухай” илтгэлдээ ... Монгол УИХ-аас улсын тэмдэгтийн хураамжийн хуулинд өөрчлөлт оруулсанаар аймгийн ИТХ-аас улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 29 заалтад тогтоосон хязгаарт багтаан хэмжээг тогтоохоор хуульчилсаны дагуу өмнөх мөрдөж байсан хураамжийн хэмжээг 20,0-75,0 хувиар тооцож тогтоохоор мэргэжлийн байгууллага, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн саналыг тусган оруулж байгааг илтгэсэн байна.

Илтгэлийг аймгийн ИТХ-ын эдийн засгийн хороогоор хэлэлцэн хүн ардын эрүүлийг хамгаалах зорилгоор архи, тамхинд олгох зөвшөөрөлийн хураамжийг дээд хязгаараар тогтоох, мал эмнэлгийн ажил үйлчилгээний зөвшөөрөлийн хураамжийг хамгийн доод хэмжээгээр тогтоох саналыг хуралдаанд оруулсан байна.

Хуралдаан “Хураамжийн хувь хэмжээ тогтоох тухай” 8/02 дугаар тогтоолоор аймаг, сумын Засаг даргад харьяалагдах нутаг дэвсгэр дахь төрийн захиргааны байгууллагуудаас зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоож 2011 оны 12 дугаар сарын 2-ний өдрөөс мөрдүүлэхээр баталсан байна.

Аймгийн ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Д.Алтангэрэл “Аймгийн 2011 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” илтгэлдээ ... Монгол Улсын Их Хурлаас орон нутгийн 2011 оны төсөвт Хөшөөтийн уурхай болон гар аргаар ашигт малтмал олзворлогчдоос 1586,6 сая төгрөг төвлөрүүлэхээр баталсаныг хууль эрх зүйн хүрээнд орсон өөрчлөлтийн дагуу өөрчилж санхүүгийн дэмжлэг болгосоноор Алтай, Булган, Үенч, Цэцэг сумын орлогын төлөвлөгөөнд тусгагдсан орлогуудыг хасаж санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр хувиарласан байна.

Төсвийн нэмэлт өөрчлөлтөөр орон нутаг дахь улсын төсвийн байгууллагуудын нийт зардал 1,8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 900,0 сая төгрөгийн төсөвтэй сүүний үйлдвэр хасагдаж малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжид 980,0 сая төгрөг төсвийн нэмэлт өөрчлөлтөөр батлагдсаныг илтгэсэн байна.

Илтгэлийг аймгийн ИТХ-ын эдийн засгийн хороогоор хэлэлцэн аймаг сумын төсвийн орлогыг бууруулж санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлсэн, эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Засаг даргатай 2011 онд нийлүүлэх бүтээгдхүүний санхүүжилтийг нэмэгдүүлсэнийг дэмжсэн саналыг хуралдаанд оруулсан байна.

Хуралдаан “Орон нутгийн 2011 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 8/03 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 1586,6 сая төгрөгөөр, Алтай, Булган, Үенч, Цэцэг, Ховд

төвлөрсөн төсвийн орлогыг 1586,6 сая төгрөгөөр тус тус бууруулж сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 1586,6 сая төгрөгөөр нэмэгдүүлж мөн 8/04 дүгээр тогтоолоор эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Засаг даргатай 2011 онд нийлүүлэх бүтээгдхүүний санхүүжилтийг 1557,7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэнийг сайшааж баталсан байна.

Хуралдаанд 31 төлөөлөгчөөс 23 буюу 74,2 хувь нь оролцож ний 91 хүн урилгаар оролцсоноос төсөвт байгууллагын ажилтан 79, иргэн 12 оролцсон ба 12 хүн үг хэлж 2 асуудал хэлэлцэн 4 тогтоол баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 9 дүгээр хуралдаан

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 12 дугаар сарын 07-ний өдрийн 149 дүгээр тогтоолоор аймгийн ИТХ-ын 9 дүгээр хуралдааныг 2011 оны 12 дугаар сарын 23-ний өдөр хуралдуулж

1. Аймгийн ИТХ-аас 2011 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан цаашдын зорилтын тухай илтгэл

2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2011 оны биелэлт, эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн тухай илтгэл

4. Аймгийн төсвийн 2011 оны урьдчилсан гүйцэтгэл, 2012 оны төсөл, 2010 оны төсвийн гүйцэтгэлийн тухай илтгэл

5. Аудитын газрын 2010 оны ажлын тайлан, орон нутгийн 2012 оны төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж, орлого нэмэгдүүлэх талаар өгөх саналын тухай илтгэл

6. Аймгийн газар зохион байгуулалтын 2011 оны ажлын дүн, иргэнд газар өмчлүүлэх болон газар зохион байгуулалтын 2012 оны төлөвлөгөөний тухай илтгэлүүдийг хэлэлцүүлэхээр зарласан байна.

Хуралдаан аймгийн ИТХ-ын 2008 оны 2 дугаар хуралдаанаас баталсан дэгийн мөрдөж ажлын албаны нарийн бичгийн даргаар аймгийн Г.Пүрэвганди, Ч.Улаанхүү аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн, А.Оюундэлгэр Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн, редакцийн комиссоор Б.Энхтуяа аймгийн ИТХ-ын Ажлын албаны ахлах ажилтан, Б.Шоовдой Нутгийн удирдлага сэтгүүлийн орон нутгийн ажилтан, тэмдэглэл хөтлөгчөөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны ажилтан Б.Сандагсүрэн нар ажилласан байна.

Хуралдаанаас гарах тогтоол шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Багдалаар ахлуулан 12 хүний бүрэлдхүүнтэй байгуулжээ.

Аймгийн ИТХ-ын дарга Х.Батболд “Аймгийн ИТХ-аас 2011 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан цаашдын зорилтын тухай” илтгэлдээ... Монгол оронд тулгар төр байгуулагдсан болон тусгаар улсаа олноо өргөж, сэргэн мандалын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг ардын хувьсгалаар үргэлжлүүлэн нийгмийн харилцаагаа өөрчилж ардын төрөө байгуулж

байсан он жилүүдийн түүхт тэгш ойн жилүүд Хүннү гүрэн байгуулагдсаны 2220 жил, үндэсний эрх чөлөөний 100, ардын хувьсгалын 90 жилийн ойтой аймаг байгуулагдсаны 80 жилийн ой хамт тохиож байгаа түүхэн онцлог жил 2011 он олон үндэстэн, ястан Ховдчууд эвсэг, баатарлаг, хөдөлмөрч уламжлалаа бататгаж их бүтээн байгуулалт эрчимтэй хөгжлийн зорилтыг амжилт бүтээлээр дүүрэн хэрэгжүүлсэн түүхэн бахархалтай он болж тэмдэглэж байна.

Тайлангийн жилд тохиосон аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг өндөр түвшинд зохион байгуулж явуулахад аймгийн ИТХ онцгойлон анхаарч аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, бүтээн байгуулалтын ажлуудыг өрнүүлэхэд бодлогоо төвлөрүүлж ажиллаа.

Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн хүрээнд аймгийн ИТХ-ын Хүндэтгэлийн хуралдааныг 2011 оны 07 дугаар сарын 28-нд зохион байгуулж хуралдаанд УИХ-ын дарга Д.Дэмбэрэл, УИХ-ын гишүүн С.Бямбацогт, Д.Загджав нар болон аймгийн хөдөлмөр бүтээлийн алдартнууд, байгууллага хамт олон болон иргэдийн төлөөлөл хүндэт зочноор оролцлоо. Хүндэтгэлийн хуралдаанаар Ховд аймгийн 80 жилийн түүхэн хөгжлийн тухай аймгийн ИТХ-ын дарга илтгэл тавьж, аймгийн шинэчилэн баталсан сүлд, далбааг хүндэтгэн залж байрлуулан, аймагт ажиллаж амьдарч байгаа Хөдөлмөрийн баатар Б.Лувсан, Д.Харай, Ц.Лхагва нарт аймгийн Хүндэт иргэн шагнал гардуулах ёслолын ажиллагаа явагдсан онцлог хуралдаан боллоо.

ИТХ-ын хуралдаанууд төлөөлөгчдийн ирц 74,2 хувиас дээш болон бүрэн бүрэлдэхүүнтэйгээр хуралдаж, хуралдаанд 160 хүн урилгаар оролцсоноос 128 нь төсвийн байгууллагын ажилтан, 32 нь иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, иргэд байна. Хуралдаанд давхардсан тоогоор нийт 25 хүн үг хэлж, санал шүүмжлэл гаргасан ба нийт 7 тогтоол батлан гаргалаа.

ИТХ-ын 7, 8 дугаар хуралдаанаас Их бүтээн байгуулалт, эрчимтэй хөгжлийн жилийн ажлын явцыг хэлэлцэж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ анхаарах асуудлуудын талаар ярилцаж холбогдох заалт бүхий тогтоол гаргаж орон нутгийн зарим төрлийн татвар хураамжийн хувь хэмжээг баталж татварын бааз суурийг өргөтгөж 2011 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулснаар төсвийн орлого бүрдүүлэлт санхүүжилтэнд учирсан хүндрэлийг залрууллаа.

Аймгийн ИТХ-ын чөлөөт цагт Тэргүүлэгчдийн хуралдааныг 29 удаа зохион байгуулж 145 асуудал хэлэлцэж, 124 тогтоол, 18 төлөвлөгөө, 4 журам, 4 хөтөлбөр, 1 зөвлөмж, 20 тэмдэглэлээс гаргаж холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлж хэрэгжүүлж ажиллаж байна. Тэргүүлэгчдийн хуралдаанаар аймгийн ИТХ, Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл, хөтөлбөрт тусгагдсан бодлого арга хэмжээг ажил хэрэг болгох, эдийн засаг нийгмийн салбаруудын хөгжлийн зорилтыг цаг алдалгүй, шуурхай шийдвэрлэх, санхүүгийн нөөц, өмч хөрөнгийн ашиглалт үр ашгийг

нэмэгдүүлэх төрийн дээд шагналд тодорхойлох, төрийн захиргааны болон үйлчилгээний ажилтны гүйцэтгэх хариуцлагыг сайжруулах зэрэг асуудлууд хэлэлцэж холбогдох шийдвэрийг гаргаж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас “Цөлжилттэй тэмцэх”, “Монгол мал”, “Ахуй үйлчилгээ хөгжүүлэх” зэрэг аймгийн дэд хөтөлбөрүүд баталлаа.

Аймгийн ИТХ-ын 2011 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 11 бүлэг 96 асуудал тусгаж баталсанаас 94 асуудал биелэгдэж нэмж 8 төрлийн цаг үеийн тулгамдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэн биелэлтийг хангахад хяналт тавьж ажиллаж байна.

Тайлангийн жилд аймгийн ИТХ болон Тэргүүлэгчдийн 2011 оны болон улирлын үйл ажиллагааны төлөвлөгөө, аймагт 2011 онд хийгдэх хяналт, шалгалтын график, орон нутгийн өмчийн тооллогын дүн, авах арга хэмжээний тухай, аймагт 2011 онд явагдах сургалт, семинар, уулзалт, зөвлөгөөний төлөвлөгөө, нийтээр тэмдэглэх ой, тэмдэглэлт өдөр, спорт, урлагийн арга хэмжээний төлөвлөгөө, 6 дугаар хуралдааны санал шүүмжлэлийн мөрөөр зохиох арга хэмжээний төлөвлөгөө, орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоот байгууллагуудын 2011 оны орлого зарлага, цалингийн сан, цэргийн дүйцүүлэх албыг хаалгах тухай, түрээсийн хэмжээг тогтоох тухай, өмч эзэмшүүлэх гэрээний загвар, биелэлт дүгнэх журам батлах тухай, Ховд суварга орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг төрийн гэрэгэд нэр дэвшүүлэх тухай, сумын ИТХ-уудын ажил дүгнэх тухай, жишиг баг шалгаруулах тухай, зөвлөгөөн спортын арга хэмжээний тухай, Чандмань сумыг төрийн дээд шагналд тодорхойлох тухай, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх тухай, давсан орлогыг зарцуулах тухай, аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг зохион байгуулах комисс байгуулах тухай, ой угтаж хийх бүтээн байгуулалтын ажлын төлөвлөгөө, жагсаалт батлах тухай, Ховд, Буянт голын сав газрын зөвлөлийн ажиллах түр журам батлах тухай, аймгийн сүлд, далбааг шинэчлэн батлах тухай, эрүүл мэндийн газрын стратеги төлөвлөгөө батлах тухай, багш нарыг аттестатчилах журам батлах тухай, иргэний танхим байгуулах тухай, нэрэмжит болгох тухай, хүн амын ундны усны талаар авах зарим арга хэмжээний тухай, Хөшөөт сангийн ажиллах журам батлах тухай зэрэг аймаг орон нутгийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан болон стратеги ач холбогдолтой асуудлуудыг авч хэлэлцэн тогтоол гаргаж хэрэгжүүлж байна. Мөн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт болон орон нутгийн өмчийн асуудлууд, Төрийн дээд шагналд тодорхойлох, аймгийн Хүндэт иргэн, Хүндэт тэмдгээр шагнах, иргэдийн санал хүсэлт, өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэх зэрэг үйл ажиллагааны олон чухал асуудал арга хэмжээг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Тайлангийн хугацаанд Тэргүүлэгчдийн өргөтгөсөн хуралдааныг 2 удаа бүсчлэн зохион байгуулж хуралдаанд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, зөвлөхүүд, хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасаг, агентлагийн

дарга нар, сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, тэргүүлэгч, багийн ИНХ-ын дарга, Засаг дарга нар оролцсон болно.

Чандмань суманд зохион байгуулсан бүсчилсэн хуралдаанд Зэрэг, Дарви, Чандмань, Дөргөн, Мянгад, Буянт, Дуут, Ховд, Эрдэнэбүрэн, Жаргалант сумууд оролцож “Бизнес инкубатор төвийн үйл ажиллагаа, цаашдын зорилт, суманд жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэхэд баримтлах бодлогын тухай” Чандмань сумын ИТХ-ын даргын илтгэл хэлэлцэж “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай” тогтоол, “Их бүтээн байгуулалт–эрчимтэй хөгжлийн жил”-ийн хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажил түүний үр дүнгийн тухай Дарви сумын Засаг даргын илтгэл, “Багийн ИНХ-ыг зохион байгуулж, иргэдийн оролцоог хангах талаар авч хэрэгжүүлж буй ажлын үр дүнгийн тухай” Буянт сумын Цагаан эрэг багийн Засаг даргын мэдээлэл, “аймгийн болон сумын ИТХ, Тэргүүлэгчдийн хуралдаанаас гарсан шийдвэрүүдийн биелэлтийг зохион байгуулж үр дүнг тооцож байгаа арга барилын тухай” Ховд сумын Засаг даргын илтгэл мэдээлэл хэлэлцэж тэмдэглэл гаргаж холбогдох сум, баг, байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлж үр дүнг тооцон ажиллаж байна. Энэ удаагийн бүсчилсэн хуралдаанд оролцогчид хэлэлцсэн асуудлын хүрээнд Чандмань сумын Бизнес инкубатор төвийн үйл ажиллагаатай биечлэн танилцсан нь сумдад бизнес инкубатор төв хөгжүүлэхэд санаа авахуйц чухал арга хэмжээ болсон бөгөөд үүнийг сум бүр онцлогтоо тохируулан хэрэгжүүлж үр дүнд хүрэх нь гагцхүү ажил хариуцаж байгаа албан тушаалтан, удирдлагуудаас ихээхэн шалтгаална гэдгийг энд онцлон тэмдэглэж байна.

Булган суманд болсон бүсчилсэн хуралдаанд Булган, Үенч, Мөст, Мөнххайрхан, Цэцэг, Манхан сумууд оролцож, “Байгаль орчноо хамгаалах, үр дүнтэй ашиглах, нөхөн сэргээх, цөлжилтийг бууруулах талаар хийж хэрэгжүүлж буй ажлын тухай” Булган сумын ИТХ-ын даргын мэдээлэл, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, суманд архидан согтуурах үйл ажиллагаатай тэмцэж, нийгмийн хэв журмыг хангах талаар хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, цаашдын зорилтын тухай” Үенч сумын Засаг даргын илтгэл, мэдээлэл, “ИТХ-ын хуралдаан болон Тэргүүлэгчдийн хуралдааны зохион байгуулалт, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, шийдвэрийн биелэлтийг хангаж буй ажлын тухай” Мөст сумын ИТХ-ын даргын илтгэл, мэдээлэл, “Багийн ИНХ-ыг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, үйл ажиллагааг нь сайжруулж буй арга барилын тухай” Манхан сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын илтгэл мэдээлэл хэлэлцэж “Байгаль орчны талаар авах зарим арга хэмжээний тухай”, ГХУСА-ыг эрчимжүүлэх тухай”, “Багийн ИНХ-ын ажлыг дэмжих тухай” тогтоолууд гаргаж хэрэгжүүлж байна. Энэ удаагийн хуралдаанд хэлэлцсэн илтгэлүүдээс бусад сумдад санаа авахуйц арга хэмжээ зохион байгуулж байгаа Булган сумын ИТХ-ын дарга, Манхан сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын илтгэлийг сумдад хүргүүллээ. Аймгийн ИТХ-ын ажлын албаны зүгээс бүсчилсэн хуралдааны хэлэлцэх асуудлыг сонгохдоо тухайн сумын хийж хэрэгжүүлж буй ажлуудаас бусад сумдад туршлага болохуйц, түүнийг

бусдад хүргэх, санаа авч сум, багийн онцлогт тохируулан хэрэгжүүлж үр дүнд хүргэх боломжтой асуудлуудыг олж тогтоож бусдаас харилцан суралцах боломжийг бий болгож байгаагаараа онцлогтой боллоо.

Мерси кор байгууллагын Ховд аймаг дахь төлөөлөгчийн газартай хамтран аймгийн ИТХ-ын төлөөлөгч, сумын ИТХ-ын дарга нарт “Орон нутгийн төрийн албан хаагчид, бизнесийг дэмжих байгууллагуудад бэлчээрийн болон байгалийн нөөцийн менежмент, газрын төлөвлөлт, зохион байгуулалтын талаар”, аймгийн ИТХ-ын төлөөлөгч, сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарт “орон нутгийн хэрэглэгчдийн малаас гаралтай бүтээгдэхүүний хадгалалт, бэлтгэл, худалдан авах үеийн аюулгүй байдалтай холбоотой мэдлэг боловсролыг дээшлүүлэх нь” сэдвүүдээр сургалт зохион байгуулсан нь үр дүнтэй үйл ажиллагаа болсныг тэмдэглэж байна.

Мөн Монголын нутгийн удирдлагын холбоотой хамтран сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарыг Улаанбаатар хотод 2-7 хоногийн сургалтанд хамруулж, Конрауд Адеунарын сангаас зохион байгуулсан сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарын Увс аймагт болсон бүсчилсэн сургалтанд нарийн бичгийн дарга нарыг хамрууллаа.

Аймгийн ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдийн санаачилгаар Нутгийн өөрөө удирдах байгууллагын ажилтан сонгуультнуудын дунд анх удаа Баруун бүсийн аймгуудын Нутгийн өөрөө удирдах байгууллагын ажилтан, сонгуультнуудын ажил төрлийн харилцан туршлага солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх, нийтийн эрүүл мэндийг хамгаалахад биеийн тамир спортын үр өгөөжийг нэмэгдүүлэн дэмжих зорилготой Нутгийн өөрөө удирдах байгууллагын ажилтан, сонгуультнуудын уулзалт, баруун бүсийн спортын анхдугаар тэмцээнийг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Нямжав болон Ховд, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын Нутгийн өөрөө удирдах байгууллагын ажилтан, сонгуультнууд 160 гаруй хүн оролцож, “Бүс нутгийн хөгжлийг хангах талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашдын бодлогын тухай” Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Нямжавын илтгэл, Баруун бүс нутгийг хөгжүүлэхэд хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүнд Нутгийн өөрөө удирдах байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааны тухай Ховд аймгийн Засаг дарга Г.Нямдаваагийн илтгэл, Сонгуулийн хуулийг боловсронгуй болгох талаар өгөх саналын тухай Говь-Алтай аймгийн ИТХ-ын дарга, Төсвийн хуулийг боловсронгуй болгох талаар өгөх саналын тухай Баян-Өлгий аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг боловсронгуй болгох талаар өгөх саналын тухай Увс аймгийн ИТХ-ын дарга нарын мэдээлэл сонсож харилцан ярилцаж, туршлага солилцон холбогдох хуулиудын өөрчлөлтийн талаар саналаа нэгтгэн УИХ, Засгийн газар, Монголын Нутгийн удирдлагын холбоонд хүргүүлээ.

Арга хэмжээний үеэр 10 төрлийн тэмцээн явуулж төрөл тус бүрээр эхний 3 байр эзлүүлэн өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнасан бөгөөд багийн амжилтаар Увс аймгийн ИТХ-ын хамт олон тэргүүн байрт шалгарч шилжин явах цом, мөнгөн шагналаар шагнагдаж дараа жилийн арга хэмжээг зохион байгуулж явуулахаар боллоо.

Аймгийн ИТХ-аас аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зардал олгох журмын дагуу төлөөлөгч бүрт 1.0 сая төгргийн дэмжлэг үзүүлснээр тойрогтоо хүрч ажиллаж иргэд сонгогчдод хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг сурталчилах, тулгамдаж буй асуудлаар санал солилцох, олон түмний санал санаачилгыг дэмжиж тодорхой асуудлуудыг шийдвэрлэх талаар олон хэлбэрийн арга хэмжээнүүдийг зохион байгуулсан болно.

Тайлангийн хугацаанд аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн өдрийн ажиллагааг 4 удаа хийснээс 4 дүгээр сард зохион байгуулж “Нийгмийн халамж, үйлчилгээний талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, цаашдын зорилтын тухай” Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн дарга Ц.Ганчимэгийн илтгэл, “Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, даатгалын хамралтын хувь хэмжээ, цаашдын зорилтын тухай” Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Д.Мягмарцоожийн илтгэл, 8 дугаар сард “Аймгийн эдийн засаг нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2012 оны төсвийн төсөл боловсруулсан дүнгийн тухай” Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Д.Алтангэрэлийн илтгэл, 10 дугаар сард зохион байгуулж “Аймгийн өвөлжилтийн бэлтгэл ажлын дүнгийн тухай” аймгийн Засаг даргын мэдээллийг хэлэлцэж, хэлэлцэж буй асуудал тус бүрээр төлөөлөгчид асуулт асууж, цаашид хэрэгжүүлж зохион байгуулах ажил, асуудлын талаар үнэтэй зөвлөгөө, санал дүгнэлт гаргасныг ажил хэрэг болгох зорилгоор санал шүүмжлэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Тэргүүлэгчдийн хурлдаанаар хэлэлцэж батлуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж хэрэгжүүлээд байна.

ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанаас сумдын ИТХ, багийн ИНХ, түүний Тэргүүлэгчдийн ажлыг жигд сайжруулах, арга зүйн удирдлагаар хангаж тэдгээрийн бодлого, үйл ажиллагааны чанарыг өөрчлөн хөгжүүлэхэд байнга дэмжлэг үзүүлж байна. Үүнд хуралдааны материалтай болон жилийн төлөвлөгөө, тайлантай нэг бүрчлэн танилцаж зөвлөмж хүргүүлэх, жилд 1-ээс доошгүй удаа ажилтай нь танилцаж ажил төлөвлөх, тайлагнах, үнэлж мониторинг хийх, хуралдаан зохион байгуулах, шийдвэр боловсруулах, шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, үр дүнг тооцож дүгнэх, Нутгийн захиргааны болон иргэний нийгмийн байгууллагатай ажиллах арга барил, төсөв, эдийн засаг, нийгмийн асуудлаар аргачилсан зөвлөгөөг хурлын Төлөөлөгчид, Тэргүүлэгчдийг байлцуулан өгч биелэлт, үр дүнтэй нь танилцах, ИТХ-ын дарга, ажлын албаны ажлын чанарыг үнэлэн дүгнэх, ажил сайжруулах, сануулга, зөвлөгөө өгөх, үүнийг үндэслэн сургалт зохион байгуулахад

аймгийн Хурал үйл ажиллагааныхаа нилээд хэсгийг чиглүүлж тэдний санал санаачилгыг дэмжиж ажиллаж байна.

ИТХ-ын ажлын чанар, хүртээмжийг дээшлүүлэх, Нутгийн өөрөө удирдах байгууллагын ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар Дуут, Манхан, Чандмань, Мөнххайрхан, сумын Хурал бусдаасаа илүү санаачлагатай ажиллаж байна. Манхан сумын ИТХ-аас багийн ИНХ-ыг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллаж байгаа талаар манай нийт сум, багийн хурлууд өөрийн онцлогт тохируулан хэрэгжүүлж олон шинэлэг ажил зохиож иргэдийн сэтгэлд хүрч идэвхийг өрнүүлэх боломжтой гэж дүгнэж байна.

Аймгийн ИТХурлаас 2011 оныг “Их бүтээн байгуулалт-эрчимтэй хөгжлийн жил” болгон зарлаж эдийн засгийн салбарт өмнөх жилүүдэд бүрдүүлсэн боломжийг ойн жилийн их хөрөнгө оруулалтаар дэмжин санхүүгийн нөөцийн хуваарилалт зохицуулалтыг оновчтой ашиглан хэрэгжүүлснээр орон нутагт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд бодлогыг төвлөрүүлж ажиллаа.

Өмнөх жилийн байгалийн зуд, гамшигаас мал аж ахуйн салбарт учирсан 16,8 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн арилгах арга хэмжээг оновчтой хэрэгжүүлж сургамжаас дүгнэлт хийж мал маллах ажиллагаанд бий болсон шинэ санаа өөрчлөлтүүд энэ жилийн байгаль цаг уурын таатай нөхцөлтэй уялдан мал аж ахуйн салбарт өсөлт бий болж 2011 оны хагас жилийн байдлаар 1684,8,0 мянган мал тоолуулж өмнөх оноос 2,7 хувиар нэмэгдсэн байна.

Мал аж ахуйн салбарт ажилаж амьдарч буй 8500 гаруй малчин өрхийн 18,1 мянган хүн 12,5 тн мах, 1036,8 мянган тн ноос, 350 гаруй тн ноолуур, 800 мянган ширхэг арьс шир, болон бусад түүхий эд бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж 32,6 орчим тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өрхийн орлогыг нэмэгдүүлэн амьжиргааг дэмжихэд чухал ач холбогдолтой боллоо.

Аймгийн ИТХ-аас бэлчээр ашиглалтыг сайжруулах, нөхөн сэргээх, бэлчээрийн даацад тохирсон хоршсон, өндөр ашиг шимтэй, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж хадлан, тэжээлийн үйлдвэрлэлийг сэргээх талаар тодорхойлсон бодлого тухайн сум орон нутгийн онцлогтой уялдуулан хэрэгжиж энэ онд 74,7 мянган тн хадлан бэлтгэж, 27 худаг гаргаж, 30,0 мянган га-д царцааны устгал хийсэн байна.

Газар тариалангийн бүтээгдэхүүнийг хадгалах, савлах, боловсруулах үйлдвэрлэлийг бий болгох, усалгаатай тариаланг нэмэгдүүлэх, үрийн чанарыг сайжруулан үр өгөөжийг дээшлүүлэх тухай зорилтууд тодорхой үр дүнд хүрч тус салбарын үйл ажиллагаа тогтворжин өсөлт бий болж 4000 орчим тариаланчид ажиллаж 2011 онд 2909,2 га талбайд тариалалт хийж 28663,9 тн ургац хурааснаас төмс 18902,2 тн, үр тариа 620,6 тн, хүнсний ногоо 10272,4 тн, тэжээлийн ургамал 3582,5 тн тус тус хураасан нь өмнөх оноос тариалсан талбайг 209 га-гаар ургац 34,7 хувь буюу 7,3 мянган тн-оор илүү байна.

Усалгаатай тариалангийн хэмжээ нэмэгдэж Буянт голын сав газрын дагуу 350 га талбайн услалтын систем ашиглалтанд орж түүнийг ашиглах түр журмыг баталж Ховд, Буянт голын сав газрын зөвлөлд хариуцуулан ажиллаж байгаа ба Ховд сумын 307 га атарын услалтын системийн барилга, байгууламж баригдаж байна.

Аймгийн хэмжээнд 1168 аж ахуйн нэгж, салбар байгууллагууд ажиллаж хүлээгдэж буй гүйцэтгэлээр аж үйлдвэрийн салбар 3,3 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, барилгын салбар 9,5 тэрбум төгрөгийн барилга угсралт их засварын ажил, бусад салбарт 0,7 тэрбум төгрөгийн ажил үйлчилгээ гүйцэтгэсэн нь өмнөх оноос өссөн үр дүнтэй байна.

Тус онд нийт жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх болон сум хөгжүүлэх сангаас 302 төсөлд 2,6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож дэмжлэг үзүүлснээр жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар дэвшүүлсэн зорилтуудаа хэрэгжүүлэн түр болон бүр 1237 ажлын байрыг бий болгожээ.

Тендер сонгон шалгаруулах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог идэвхижүүлэн хяналтын тогтолцоог бий болгож төрийн зарим үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагуудаар гүйцэтгүүлдэг тогтолцоог хэрэгжүүлж байгаа явдал төсөв санхүүгийн үр ашгийг дээшлүүлэхэд эерэг үр нөлөө үзүүлсэн бөгөөд нээлттэй нийгэм форумаас аймгуудын төсөв төлөвлөх, баталж зарцуулах талаар явуулсан судалгаагаар манай аймаг төсвийн нээлттэй байдлын индексээр тэргүүлсэн байна.

Татвар төлөгчдийг татварт бүрэн хамруулж татвар ногдуулалт төлөлтөнд зохих үр дүн гарснаар татвар төлөгч аж ахуйн нэгж байгууллагын тоо өмнөх оноос 144-оор нэмэгдэж 1433, татвар төлөгч иргэд 1086-аар нэмэгдэж 17284 хүрсэн байна.

2011 онд орон нутгийн төсөвт нийт орлогоор 3726,4 сая төгрөгийн орлого оруулахаас 4217,8 сая төгрөг төвлөрснөөс татварын орлогоор 3453,9 төгрөг оруулахаас 3714,6 сая төгрөг оруулж төлөвлөгөө 260,7 сая төгрөгөөр, татварын бус орлогоор 272,5 сая төгрөг оруулахаас 503,1 сая төгрөг оруулж төлөвлөгөө 230,6 сая төгрөгөөр тус тус давж биелүүлэхээр байна.

Орон нутгийн төсвөөс 5272,2 сая төгрөгийн зарлагыг санхүүжүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 6389,8 сая төгрөгт хүрлээ.

Тус онд улсын төсөвт нийт 992,2 сая төгрөгийн татварын орлого оруулахаас 1029,2 сая төгрөг оруулж төлөвлөгөө 100,0 сая төгрөгөөр буюу 10,0 хувиар давж биелэхээр байна.

Орон нутаг дахь улсын төсвийн байгууллагуудын төсвийн зарлага 27,8 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Аймгийн ИТХ-аас 2011 оны үндсэн зорилт болгон баталсан их бүтээн байгуулалтын эрчимтэй хөгжлийн жилийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн замын сангийн хөрөнгөөр 170,0 сая төгрөгийн, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 796,0 сая төгрөгийн, аймагт эрх нь шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгөөр 6482,1 сая төгрөгийн, улсын төвлөрсөн төсвийн

хөрөнгөөр 8399,0 сая төгрөгийн, зээл, тусламж, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 55843,0 сая төгрөгийн, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 1320,0 сая төгрөгийн нийт 73010,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн өмнөх оноос 2,6 дахин нэмэгдсэн байна.

2010 оны орон нутгийн төсвийн давсан орлогоос сумдын дүнгээр 225,7 сая төгрөгийг сум бүрээр Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхээр, аймгийн төвлөрсөн төсвийн орлого 836.6 сая төгрөгийг Жаргалант суманд 2,2 км хатуу хучилттай зам барихад 160,0 сая төгрөг, орон сууцны засвар үйлчилгээнд 105,0 сая төгрөг, Нэвтийн амралтын ЦДАШугам барихад 50,0 сая төгрөг, олон үндэстэн, ястаны өв соёлын хүрээлэнг барихад 50,0 сая төгрөг, бусад хөрөнгө оруулалтанд 471,6 сая төгрөг, аймгийн 80 жилийн ойн баярын зохион байгуулалтын ажиллагаанд 114,1 сая төгрөг, аймаг орон нутгийн зайлшгүй шаардлагатай арга хэмжээнд 103,4 сая төгрөгийг тус тус хуваарилан баталлаа.

Аймгийн өмч тайлант оны эхэнд нийт 94,6 тэрбум төгрөгийн хөрөнгө тоологдсоноос, барилга байгууламж 79,0 хувь буюу 74,0 тэрбум төгрөг, тоног төхөөрөмж 8,0 хувь буюу 7,0 тэрбум төгрөг, авто тээврийн хэрэгсэл 1,9 хувь буюу 1,0 тэрбум төгрөг, тавилга эд хогшил 3,3 хувь буюу 3,0 тэрбум төгрөг болон бусад хөрөнгө 7,7 хувь буюу 7,0 тэрбум төгрөгийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж төрийн өмчийн хороонд хүргүүллээ.

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд 2011 онд үр ашигтай ажиллахаар 1,3 тэрбум төгрөгийн орлого олж, 1,2 тэрбум төгрөгийн зарлага гаргахаар төлөвлөгөөг баталж мөрдснөөр санхүүгийн үр ашиг сайжирч хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1319,0 сая төгрөгийн орлого олж 133,4 сая төгрөгийн ашигтай ажиллах урьдчилсан дүн гарч байна.

Тайлант онд Шим ус компани 1750 метр хашаа татаж цэвэр усны байгууламжийн эрүүл ахуйн бүсийг харуулын байрын хамт байгуулсан, Мянган угалзат үйлдвэрийн газар Нэвт амралтыг иргэдийн аятай тухтай амрах нөхцөлийг бүрдүүлэхээр 100,0 сая төгрөгөөр байнгын цахилгааны эх үүсвэрт холбож амралтын газрыг өргөтгөн засварлаж 3 сарын хугацаанд 819 хүнийг амруулсан, Ховд суврага үйлдвэрийн газар 29 хүний шинэ ажлын байр бий болгож, “Сарны гэрэл” номын өргөө музейг байгуулсан зэрэг бүтээлч ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ИТХ-аас үндсэн чиглэлд тусгагдсан нийгмийн хөгжлийн зорилтуудыг хангаж тус салбарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, үйлчилгээний хүртээмж, чанар, хөнгөн шуурхай байдлыг сайжруулахад бодлого, төсөв, санхүүг төвлөрүүлэн иргэдийн амьдралын дэмжлэг болохуйц үйлчилгээний таатай орчинг бүрдүүлэхэд ажлаа чиглүүлж тодорхой ажлуудыг зохион байгуулж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн болон сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн боловсролыг дээшлүүлэх, сурах ая тухтай, тохилог орчин бий болгох, багш, ажилтнуудын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, багш, сурагч, эцэг эхийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн асуудлуудад бодлогыг төвлөрүүлэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар болон Төлөөлөгчдийн өдрөөр хэлэлцэж санал, зөвлөмж гаргаж аймгийн БСГ-т хүргүүлэн хэрэгжүүлээд байна.

Сургуулийн өмнөх боловсролын салбарт шинээр Булган, Ховд, Дөргөн, Жаргалант суманд 5 бүлэг нэмж 27 цэцэрлэгийн 128 бүлэгт өдрөөр 4033, ээлжийн 21 бүлэгт 522, явуулын болон нүүдлийн 39 бүлэгт 1256 хүүхдүүдийг тус тус хамруулан, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 82.3 хувьд хүрч дээшилсэн байна.

Боловсролын салбарын байгууллага, багш, сурган хүмүүжүүлэгчдийн хөдөлмөр бүтээлийн үр дүнд улсын түвшинд масс сургалтын түвшинг тодорхойлдог элсэлтийн ерөнхий шалгалтанд хэмжээс онооны дундажийг 503–д хүргэн амжилтыг ахиулж улсын хэмжээнд анх удаа 4-р байр эзлэн Прогресс, Цаст-Алтай цогцолбор, Жаргалантын 1, 2, 6, Дарви, Зэрэг, Дөргөн, Манхан, Мөнххайрхан, Дуут, Мөст, Мянгад сумын сургуулиуд шилдэг үнэлгээтэй сургуулиар шалгарсан байна.

Боловсрол, соёлын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэхэд 3134,0 сая төгрөгийн барилга байгууламж шинээр баригдаж, 320,0 сая төгрөгийн их засварын ажил хийж, 260,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, олон улсын төсөл хөтөлбөрийн дэмжлэгээр 500,0 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэнээр үйл ажиллагаа явуулах таатай орчин бүрдэж байна.

Дотуур байрны орны тоог 233-иар нэмэгдүүлснээр дотуур байранд суугчдын тоо 2481-д хүрч малчин өрхийн хүүхэд тав тухтай орчинд суралцах нөхцөлийг сайжруулсан байна. 2011-2012 оны хичээлийн жилд үдийн цай хөтөлбөрт 9441 хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүний тендерийг нээлттэй болгож чанар, хүртээмжийг сайжруулж үр дүнд хүрч ажиллаж байна.

Аймагт ажиллаж байсан Хөгжил МСҮТ, ХААИС-ийн Алтайн бүсийн салбар сургуулиудыг “Хөгжил” политехникийн коллеж болгон өргөтгөж, 25 мастерийн газар, 3 лабораторитойгоор 2011-2012 оны хичээлийн жилд 17 мэргэжлээр 1499 хүүхэд суралцуулж зах зээлийн үеийн үйдлвэрлэл, технологийн шаардалагад нийцэх мэргэжилтэй ажилтан бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Ховд их сургуулийг кампус сургуулийн хэлбэрт шилжүүлэхээр 200 га газрын байршлыг шийдвэрлэлээ.

Аймгийн хөрөнгө оруулалтаас эх үүсвэрийг шийдвэрлэн олон үндэстэн ястнуудын “Өв соёлын хүрээлэн”-г ашиглалтанд оруулж, өв соёлоо өвлүүлэн хөгжүүлэх, сурталчлах, нийтэд

түгээн дэлгэрүүлэх боломж бүрдүүлж 80 жилийн ойгоор “Олон угсаатны өлгий” биет бус өв тээгчдийнхээ баримтат кино /DVD/ хийлгэн, бүртгэл мэдээллийн сандаа хадгаллаа.

Аймгийн боловсролын салбарын хөгжлийн үндэс тулгуур болсон ЕБС, цэцэрлэгийн багш нарын мэдлэг ур чадварын түвшин тогтоож чадавхийг сайжруулан мэргэжил мэдлэгийг дээшлүүлж сурган дадалгаажуулах зорилгоор тэднийг аттестатчилах журмыг баталлаа.

Эрүүл мэндийн салбарт эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх үйлчлүүлэгч, иргэдийн сэтгэл ханамжид нийцсэн чанартай, хөнгөн шуурхай үйлчилгээ, стандарт хангасан найдвартай эм, тариа, урвалж, орчин үеийн технологийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангах чиглэлийг тодорхойлон хэрэгжүүллээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар эрүүл мэндийн салбарын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг баталснаар тус салбарт ойрын жилүүдэд хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаа тодорхой болж менежментийн өөрчлөлтөөр үйлчлүүлэгчийн хэрэгцээг бүрэн хангасан, сэтгэл ханамж бүхий үйлчилгээг бий болгох боломж нөхцөл бүрдэж байна.

Эрүүл мэндийн байгууллагууд аймгийн хэмжээнд 353,7 мянган хүнд үзлэг хийж 4,0 хувиар , 19595 хүнийг хэвтүүлэн эмчилж 14,0 хувиар, 2026 эх төрж 109 тохиолдлоор өмнөх оноос тус тус нэмэгдэж, нялхасын эндэгдэл 41 гарч 5-аар, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 10 гарч 1 тохиолдлоор өмнөх оноос буурч эхийн эндэгдэл 2 тохиолдол гарч өмнөх оны түвшинд байна. Халдварт өвчин 609 тохиолдол гарч өмнөх оноос 58,0 хувиар нэмэгдсэний 82,7 хувийг А вируст гепатит эзэлж байна.

Сумдын эмнэлгүүд 2-оос дээш их эмчтэй болж анхан шатны лабораторийн багаж хэрэгслэлээр хангаснаар 5-7 төрлийн шинжилгээ хийж, нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоог батлуулан ажиллуулах болсноор иргэдэд хүргэх мэргэжлийн эмчийн тусламж, хүртээмжтэй шуурхай үйлчилгээг бий болж нийгмийн эрүүл мэндийн бүх төрлийн үйлчилгээг сайжруулах боломжтой боллоо.

Хүн амын эрүүл мэндийг хамгаалахаар 2011 онд вакцинжуулалтын хамралт 98.5 хувьд хүрсэн ба дархлаажуулалт сайжирч тарилгат халдварт өвчин бүртгэгдээгүйгээр үр дүнд хүрсэн байна.

Алсын зайн оношлогоогоор эх барих эмэгтэйчүүд, хоол боловсруулах эрхтэн, зүрх судасны эмгэг, эсийн шинжилгээний мэдээлэлийг дамжуулан сүүлийн 3 жилд 13,8 мянган шинжилгээ, оношийн баталгаажилт хийж нарийн мэргэжлийн эмч нартай хамтарч ажилласан нь иргэдэд хүрсэн үйлчилгээ болж байна.

Тайлангийн хугацаанд эрүүл мэндийн даатгалаас хувийн хэвшлийн эмнэлэгүүдэд 156,0 сая төгрөг, БОЭТ-д 1561,0 сая төгрөг, Булган сумын нэгдсэн эмнэлэгт 130,5 сая төгрөг, Мөст сумын сум дундын эмнэлэгт 5,9 сая төгрөг, эмийн хөнгөлөлтөнд 72,1 сая төгрөг, нийт 1925,5 сая төгрөгийг санхүүжүүлсэн явдал эмнэлгийн байгууллагууд төдийгүй хувийн

хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжиж үйл ажиллагааг сайжруулахад чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

Жаргалант суманд 50 ортой эх нялхсын төвийн барилга 1589.5 сая төгрөгөөр баригдаж ашиглалтанд орж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн бөгөөд аймгаас тус эмнэлгийн орчины тохижилтонд 10,0 орчим сая төгрөг шийдвэрлэн тохижууллаа.

Хүн амын дунд нийгмийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажил тодорхой санаачилга бүхий сонирхолын бүлгийн хэмжээнд голдуу явагдаж байгаагаас нийтийг хамаарсан арга хэмжээ болж төлөвшиж хэвшээгүй байгаад дүгнэлт хийж өөрчлөх шаардлагатай байна.

Иргэдэд нийгмийн халамжийн сангаас нийгмийн халамжийн тэтгэвэрээр 1797 хүнд 817,3 сая төгрөг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжаар 3260 хүнд 171,6 сая төгрөг, алдар цолтой ахмад настан 83 хүнд 84,2 сая төгрөг, алдарт эхийн одонтой 8300 эхэд 1159,7 сая төгрөг, жирэмсэн болон хүүхэдтэй 2928 эхэд 487,3 сая төгрөг, хүний хөгжил сангаас 74644 хүнд 16016,6 сая төгрөг нийт 18,7 тэрбум төгрөгийн тэтгэмж, хөнгөлөлт, тэтгэлэг, даатгалын сангаас 8706 тэтгэвэр авагчдад 12,6 тэрбум төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг хүүхэд багачууд, ахмад настан болон нийгмийн эмзэг бүлгийн хүн ам, ард иргэдэд олгосон нь тэдний орлогын эх үүсвэр болж амьдрал ахуйг тэтгэхэд зохих дэмжлэг болж байна.

2011 онд 2106 хүн идэвхитэй ажил хайж бүртгүүлж 2121 түр болон байнгын ажлын байраар хангагдсан байна.

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн сангаас мэргэжил олгох давтан сургалтанд 605 хүнийг хамруулан 57 хүнийг байнгын ажлаар хангасан, 21 ажил олгогчид 43,9 сая төгрөгийн урамшуулал олгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 28 төсөлд 112,0 сая төгрөг, 1842 хүнийг хамарсан нийтийн ажил болон дэвшүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилт хангах ажлыг дэмжихээр 107,3 сая төгрөг санхүүжүүлсэн нь тодорхой үр дүнтэй ажил болжээ.

Аймгийн нийгмийн даатгалын хэлтэс энэ онд хүлээгдэж буй гүйцэтгэлээр 6283,0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 107,0 хувиар биелүүлэн 434 ажил олгогчийн 13446 даатгуулагчийг заавал даатгалд, сайн дурын даатгалд 1495 даатгуулагчийг хамааруулж иргэдийн нийгмийн хамгаалалын хамрагдах хүрээг өргөтгөсөн байна.

Орон нутгийн олонхи иргэдийн нийтлэг хүсэл, язгуур эрх ашиг сонирхолд нийцүүлэн төрийн үйл ажиллагаанд иргэдийн болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог бий болгож хамтын ажиллагааны Төр, Иргэний нийгмийн зөвлөл, Хувийн хэвшлийнхний гурван талт хамтын ажиллагаа, түншлэлийн гэрээг байгуулан ажиллаж төлөвшиж байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, тэдний үүсгэл санаачилгыг дэмжиж баталсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Төрийн бус байгууллагуудыг мэдээлэл, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж төрийн бус байгууллагын 3 удаагийн сургалт, 2 удаагийн бусад аймгуудын туршлага солилцох арга хэмжээнд оролцож, иргэний танхимын үйл ажиллагааг эхлүүлж аймгийн ИТХ-ын хуралдаанд давхардсан тоогоор нийт 32 иргэн, Иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг урилгаар оролцууллаа.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй буддагийн 10, исламын 6, есүс христийн цуглааны 5 сүм хийд, шашны байгууллагын үйл ажиллагаанд зөвшөөрөл олгож жил бүр тайланг хүлээн авч судалгаа дүгнэлт хийж зохих журмын дагуу үйл ажиллагааны зөвшөөрлийг сунгаж байна.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Цэргийн штаб, Хүүхдийн төлөө хэлтэс, Шүүх шинжилгээний алба, Тагнуулын газар, Байгаль орчин аялал жуучлалын газрын удирдлагуудаар өргөтгөн шинэчилж, 27 гишүүнтэйгээр жилийн ажлын төлөвлөгөөнд 69 асуудлын төлөвлөн 68-ыг бүрэн биелүүлж ажиллаа.

Зөвлөлийн хурлыг 5 удаа хуралдуулж, Манхан, Жаргалант сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлүүдийн ажлын мэдээлэл, аймгийн Цагдаагийн газрын ажил үүрэг хариуцсан тасгуудын мэдээлэл, “Архидан согтуурахаас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх жилийн аяны явц, үр дүнгийн тухай” аймгийн Засаг даргын илтгэл, Сургуулийн сурагч, багш, ажилчдын дунд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хамгаалах талаар зохиож байгаа ажлын тухай” аймгийн Боловсрол соёлын газрын дарга Б.Дүгэржавын илтгэлийг хэлэлцэж, зөвлөмж, тэмдэглэлээр үүрэг өгч, “Архидан согтуурахаас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” Үенч сумын Засаг даргын илтгэлийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоол гаргуулан ажиллаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор 2010 онд гэмт хэрэг гараагүй буюу бууруулсан сум, баг, байгууллага шалгаруулах болзолын дагуу Дарви сум 1 дүгээр байр эзэлж 200000 мянган төгрөг, Мөнххайрхан сум 2 дугаар байр эзэлж, 150000 төгрөг, Зэрэг сум 3 дугаар байр эзэлж 100000 төгрөг, Нийгмийн даатгалын хэлтэс, Жаргалант сумын Тахилт баг шалгарч тус бүр 100.0 мянган төгрөгөөр шагнаж аймгийн ИТХ, Засаг даргын “өргөмжлөл”-ийн хамт гардууллаа.

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлье” аймгийн зөвлөгөөнийг угтаж зохиосон ажлын хүрээнд “Гэмт хэрэг зөрчилгүй” хамт олноор 19 байгууллагыг шалгаруулан аймгийн ГХУСАЗЗ, Цагдаагийн газрын өргөмжлөлөөр шагнаж алдаршууллаа

Аймгийн ГХУСАЗЗ, ХИС-тай хамтран “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт онол практикийн бага хурал, мөн сэдвээр Магсаржав багийн

30 гаруй иргэдээс санал асуулга авч нэгтгэн дүгнэлт хийж, аймаг, сумын удирдлага, холбогдох газар байгууллагуудад хүргүүлээ.

Энэ онд тохиож байгаа түүхт ойнууд болон аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн хүрээнд эрч хүч, оюун ухаан, хөдөлмөр бүтээлээ улс, эх орон, төрөлх аймаг, орон нутаг ард түмнийхээ тусын тулд зориулж эрхэлсэн ажилдаа өндөр амжилт гаргасан тэргүүний хүмүүсийг төрийн дээд шагналаар урамшуулан шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид 417 хүний тодорхойлолтыг өргөн мэдүүлснээс Монгол Улсын хүний гавьяат эмч 1, Байгаль орчны гавьяат ажилтан 1, гавьяат малчин 1, аж үйлдвэрийн гавьяат 1, гавьяат тээвэрчин 1, гавьяат эдийн засагч 1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 11, Цэргийн Гавьяаны Улаан тугийн одонгоор -3, Алтан гадас одонгоор 50, Хөдөлмөрийн хүндэт медалиар 49, Цэргийн хүндэт медалиар - 3, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медалиар 700, Алдарт эх I одонгоор 1908, II одонгоор 2865 эх, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр аймгийн Хүндэт иргэнээр 4, Хүндэт тэмдгээр 162, аймгийн 80 жилийн ойн медалиар 2000 хүн тус, тус шагнагдсан байна.

Аймгийн ИТХ-аас 2009-2011 онд гаргасан бодлогын чанартай 64 тогтоолын 141 заалт бүрийг тооцоход Удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын чиглэлийн 19 тогтоолын 25 заалт 90,0 хувьтай, Боловсрол, соёлын чиглэлийн 2 тогтоолын 4 заалт 95,0 хувьтай, Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалийн чиглэлийн 6 тогтоолын 29 заалт 85,5 хувьтай, Хүнс, хөдөө аж ахуй жижиг дунд үйлдвэрийн чиглэлийн 8 тогтоолын 21 заалт 89,0 хувьтай, Санхүү, төрийн сангийн чиглэлийн 17 тогтоолын 26 заалт 82,3 хувьтай, Хууль, эрх зүйн чиглэлийн 10 тогтоолын 34 заалт 66,8 хувьтай, Байгаль орчны чиглэлийн 2 тогтоолын 2 заалт 70,0 хувийн буюу аймгийн дүнгээр 82,0 хувийн биелэлттэй байна.

Нутгийн удирдлагын байгууллагуудын үйл ажиллагаанд иргэд, ИНБ-ын оролцоог хангасан чанартай, шуурхай, хүртээмжтэй төрийн үйлчилгээг нийтэд хүргэх орон нутгийн хөгжлийг эрчимжүүлэх талаар дэвшүүлсэн бодлого зорилтыг ажил хэрэг болгоход бүх шатны ИТХ, Төлөөлөгчид, Засаг дарга, түүний Тамгын газар харьяа агентлаг, байгууллага, албан тушаалтнууд хувийн хэвшил, ИНБ, иргэдийн дэмжлэгтэйгээр тодорхой үр дүнд хүрч ажилласныг тэмдэглэж цаашид дараах зорилтуудад бодлого, санхүү, хөрөнгийг төвлөрүүлж ажиллах шаардлагатай байна. Үүнд:

1. 2012 он аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн хугацааны болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төгсгөлийн жил тул өмнөх жилүүдэд бий болгосон боломж үр дүнд тулгуурлан нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлж төрийн үйлчилгээний хүртээмжтэй, нээлттэй, чанартай, хөнгөн шуурхай, чирэгдэлгүй, байдлыг улам сайжруулан бататгаж албан тушаалтнуудын ажил хариуцах чадвар, хариуцлагыг эрс дээшлүүлж, хүний хөгжлийг дэмжин иргэн, айл өрх, байгууллага, хамт олон бүрийг эдийн

засаг, аж ахуйгаа бие дааж авч явах чадварыг төгөлдөржүүлэн тогтвортой өсөлт бүхий хөгжлийг ханган бататгахад бодлогыг төвлөрүүлэн хэрэгжүүлье.

2. Аймгийн хэмжээнд эдийн засаг, ниймийн хөгжлийг хангахаар оруулж буй санхүү хөрөнгө оруулалтын өсөлт нэмэгдэж олон салбарыг хамаарч нийгмийн нэн тулгамдсан шаардлага хэрэгцээ зохих хэмжээнд хангагдаж байгаа ч хөгжлийн бодиттой тогтвортой нөхцөл бүрдэхгүй байгааг өнөөдөр хүний хөгжлөө эргэн харж, дүгнэн ярилцаж саналаа нэгтгэн бодлогоо тодорхойлох шаардлагатай байна. Хүний хөгжлийн өөрийн тулгуур болсон эрүүл биетэй, нийгмийн хэрэгцээг хангасан боловсрол мэргэжилтэй, ахуй амьдралаа зохицуулах орлоготой байх тулгуур үзүүлэлтийн харилцан шүтэлцээтэй оршин тогтнолын зөв бодлогыг хэрэгжүүлэн, тогтвортой хөгжлийг дэмжихэд амин сүнс нь оршиж байна. Өөрөөр хэлбэл нийгмийн салбаруудын бүтээлч ажиллагаа тэдний салбар дундын бодлогыг уялдуулан зохицуулсан төрийн оновчтой удирдлага зохион байгуулалт, хамтын ажиллагаандаа бүх шатны байгууллагууд бодиттой дүгнэлт хийж өнөөдрийн үйл ажиллагааг эрс өөрчлөн хүний хөгжлийг дэмжиж эрчимжүүлэх хэлбэрт шилжүүлье. Энэ нь эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулж нийгмийн эрүүл мэндийг нийтийн хүртээл болгож, бүх шатны боловсролын чанарыг дээшлүүлэн мэргэжлийн ур чадварыг эзэмшүүлэн бий болсон үйлдвэрлэл үйлчилгээний тогтвортой үйл ажиллагааг хангахаас шалтгаалах тул 2012 оныг “Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж төр, захиргаа, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэд, ажил хариуцсан албан тушаалтны идэвх, санаачилга, манлайлалыг өрнүүлэн бодлого төвлөрүүлэн хамтран ажиллацгаая.

3. Аймгийн 2011 оны төсвийн орлогыг бүрдүүлэх, санхүүжилтийг хангахад дотоод эх үүсвэрийг бүрэн дайчилж хэрэгжүүлэн ажилласан боловч манай аймагт олон төсөл хэрэгжүүлж хариуцлагатай уул уурхайн хөгжлийг бий болгон хамтран ажиллахаар амлаж иргэдийн төлөөллийн байгууллагын шийдвэр гаргуулж байсан хөшөөтийн уурхайн Мо Эн Ко компани 2011 онд орон нутгийн төсөвт 1,4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр аймгийн ИТХ-аас баталсан, нийгмийн хариуцлагын арга хэмжээнд 500,0 сая төгрөг санхүүжүүлэхээр гэрээнд тусгасан ажил, үүрэгтээ хариуцлагагүй хандаж аймгийн орлогыг саатуулснаас орон нутгийн санхүүгийн салбарт хүндрэл үүсч төсвийн зээллэгт орсноор эдийн засаг, нийгмийн салбарт төлөвлөсөн бодлого, иргэдэд хүргэж буй төрийн үйлчилгээний хэвийн байдал алдагдаж, зарим бүтээн байгуулалтын ажил тасалдахад хүрч өр авлага нэмэгдлээ. Ирэх онд тус компаниас 4,4 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт оруулахаар төсөвлөгдөж байгааг харгалзан санхүүд дахин давтагдаж болох хүндрэлийг бодолцож санхүүгийн дотоод эх үүсвэрийг бүрэн дайчилж төсөв, санхүүгийн сахилга, дэг журмыг эрс сайжруулан, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж ажиллахыг нийт төсөв захирагчид, санхүүгийн ажилтнуудад анхааруулж, Мо Эн Ко компаниас төрийн өмнө амлаж төсөвт тусгасан болон аймаг, орон

нутагтаа гэрээгээр хүлээж буй үүргээ биелүүлэн хариуцлагатай ажиллаж, аймаг орон нутгийн хөгжил, хэвийн амьдралыг хойш нь чангаах биш хүлээсэн үүргийн хэмжээнд дэмжиж ажиллахыг шаардаж байна.

4. Хөрөнгө оруулалтын цар хүрээ тэлж бүтээн байгуулалтын гүйцэтгэлийн чанар, үр дүнд нааштай өөрчлөлтүүд бий болж үр ашгийн үзүүлэлтүүд сайжирсан эерэг үнэлгээ гарч байгаа ч гэсэн зарим хөрөнгө оруулалтын эх үүсвэр нь шийдэгдсэн материаллаг үйлдвэрлэлийн салбарын боловсруулах үйлдвэр барих ажил цаг хугацааны хувьд хойшлогдон удааширч, зарим хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн чанар шаардлага хангахгүй байгаад дүгнэлт хийж цаашид хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нийгмийн суурь үйлчилгээний өргөтгөл, шинэтгэл болон тогтвортой ажлын байрны хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх арга хэмжээнд түлхүү зориулан илүү үр ашигтай хэлбэрт шилжүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлэе.

5. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих талаар орон нутагт зохих эрх мэдэл шилжиж хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нутгийн баялаг, хэрэгцээ шаардлагыг харгалзан нэмүү үйлдвэрлэлд зориулан ажлын байрыг бий болгож иргэдийн орлогыг нэмэгдүүлэх талаар боломж бүрдэж хэрэгжүүлж эхэлсэн ч санхүүгийн эх үүсвэрийг буцаан төвлөрүүлэх цаг хугацаагаа баримталдаггүй, зориулалт нь өөрчлөгдөж арилжаа худалдаа, ахуйн хөрөнгө болон өөрчлөгддөг зэрэг зохисгүй байдал бий болж байхад нөгөө талд тогтвортой аж ахуй эрхлэгчид болон шинээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгжийн хөрөнгийн эх үүсвэр дутагдаж байна. Үүнд дүгнэлт хийж аймаг, сум, багийн хэмжээнд иргэдийн нэн тэргүүний хэрэгцээг хангах хөгжлийг тэтгэсэн тэргүүлэх чиглэлийг тогтоож өрхийн аж ахуй, ЖДҮ-ийг дэмжих бодлогыг тодорхойлон нээлттэй сонголтоор шийдвэрлэн бодиттой дэмжлэг үзүүлж хөрөнгө оруулалтыг хөгжил болгон үр ашгийг дээшлүүлж ажиллахад бүх шатанд бодлого чиглэл ажлын арга барилын өөрчлөлт гарган ажиллах шаардлага тулгарч байгааг тэмдэглэж байна. Хөрөнгийг ашиглах зөв шийдэл нь орон нутгийн хөгжлийн баталгаа болно гэдэгт та бүхэн санал нийлнэ гэдэгт итгэж байна.

6. Байгаль орчны доройтол, стандартын бус үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн улмаас хүний эрүүл мэнд болон ажиллаж амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх аливаа асуудалд тавих хяналтыг өндөржүүлэн ялангуяа Ховд хотын өвлийн цагийн агаарын бохирдол, утаан дахь хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх элементүүдийг багасгах талаар судалгаа шинжилгээ, мэргэжлийн байгууллагуудын анхаарал үйл ажиллагааг төвлөрүүлэн дорвитой ажиллах хэрэгтэй байна. Утаагүй зуух, түлшний хэрэглээг дэмжих, цахилгааны шөнийн тарифт шилжих болон дулааны 2 дахь эх үүсвэрийг барих ажлыг түргэтгэж түүнд холбох барилга, байгууламжуудын зураг төсөв, санхүүгийн асуудлыг одооноос зохих журмаар судалж төлөвлөн бэлтгэлийг ханган шийдвэрлэх нь зүйтэй байна.

7. Хөгжил, бүтээн байгуулалтыг эрчимжүүлэн нийгмийн үйлчилгээг сайжруулж иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд нийгмийн хэв журмыг хангаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь нэн тэргүүний зорилт хэрэгцээг агуулсаар байна. Өнөөдөр хууль хяналт, мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт иргэдийн санал хүсэлтийг судалж үзэхэд нийгмийн хэв журам ажлын бүтээлч санаачилгыг алдагдуулж хариуцлагыг сулруулсан, гэмт хэргийн суурь үндэс болсон архидан согтуурах ажиллагаа санаа зовоосон асуудал байсаар байна. Олон нийтээрээ “архидан согтуурахаас сэргийлэх ажлыг эрчимжүүлье” сэдэвт зөвлөгөөнийг зохион байгуулж бүгдээрээ хэлэлцэн бодлого чиглэлээ тодорхойлон тодорхой ажлуудыг зохион байгуулсан ч хүрсэн үр дүн чамлалттай байна. Тухайлбал согтууруулах ундаа худалдах болон үйлчилгээ үзүүлж буй цэгийн тоог МХГ-аас жил бүр 12.5 хувь хүртэл бууруулсаар байхад 2011 онд 43 цэгээр нэмэгдэж 258-д хүрсэн нь ажил хариуцан зөвшөөрөл олгож буй албан тушаалтнуудын хууль тогтоомж, стандарт, норм, нормативуудыг мөрдөж дэвшүүлсэн бодлого, зорилтыг хэрэгжүүлэх талаар ажлын арга барил, үйл ажиллагаанд өөрчлөлт гарахгүй байгааг онцлон анхааруулж байна. Нөгөө талаар олгогдсон зөвшөөрөл бүхий байгууллагуудын үйл ажиллагааны болон нийгмийн хариуцлагыг өндөржүүлж ажиллах шаардлагатай байна.

Иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, нийгмийн хэв журмыг сахин аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулахын төлөө хууль хяналтын байгууллагууд идэвх санаачилгатай ажиллаж байгааг тэмдэглэн үр дүнд хүрсэн ажлаа эрчимжүүлж иргэдийн хуулиа дээдэлж сахин биелүүлэх нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэн тэдний оролцоотой нийгмийн хэв журмыг хангах бодлого болон үйл ажиллагааны шинэ санаа, санаачилгыг өрнүүлж хэрэгжүүлнэ гэдэгт итгэж байна.

Нийгмийн хэв журмыг ханган гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанаас тусгаар нэг ч иргэн, байгууллага, хамт олон байх учиргүйг сануулж тус ажлыг нийтийн оролцоотой эрчимжүүлэх бодлогыг тодорхойлон удирдан зохион байгуулах үүргийг төр, захиргааны байгууллагын ажил хариуцсан албан тушаалтнууд ажилдаа дүгнэлт, хийж эрс өөрчлөлт гаргаж ажиллахыг анхааруулж 2011 онд зохиосон ажил, дэвшүүлсэн зорилтыг тунгаан хэлэлцэж, үнэлж дүгнэн, цаашдын бодлого чиглэлийг тодорхойлж шийдвэрлэн хэрэгжилтийг хангахад бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг илтгэлдээ тэмдэглэсэн байна.

Тус илтгэлийг аймгийн ИТХ-ын нутгийн удирдлага, хууль зүй, хүний эрхийн хороогоор аймгийн ИТХ-ын 2011 онд зохиосон ажил, дэвшүүлсэн зорилтыг хэлэлцэж “Хангалттай сайн” гэж дүгнэж багийн иргэдийн хурлын үйл ажиллагааг идэвхижүүлэх, хөрөнгө оруулалтын хэтийн төлөвлөгөөнд ажлын байр бий болгохоор төлөвлөх, Хурлын шийдвэрийг сурталчилан хэрэгжүүлэх ажлыг илүү олон нийтэд ил тод болгох саналыг хуралдаанд оруулсан байна.

АЙМГИЙН ИТХ-ЫН IX ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

“Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж
хүний хөгжлийг дэмжих жил” болгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн зүйлийн 59 дүгээр зүйлийн 59.2, 62 дугаар зүйлийн 62.1, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2011 оны тайлан, цаашдын зорилтын тухай ИТХ-ын дарга Х.Батболдын илтгэлийг хэлэлцээд аймгийн ИТХ-ын 9 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын 9 дүгээр хуралдаанд хэлэлцүүлсэн “Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2011 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, цаашдын зорилтын тухай” ИТХ-ын дарга Х.Батболдын илтгэлд хийсэн дүгнэлт, дэвшүүлсэн зорилтыг сайшааж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2011 онд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааг “хангалттай сайн” гэж дүгнэсүгэй.

2. Аймгийн хэмжээнд 2012 оныг “Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарласугай.

3. Аймгийн ИТХ-ын дарга /Х.Батболд/, Засаг дарга /Г.Нямдаваа/ нарт үүрэг болгох нь:

1/ Нутгийн удирдлагын чадавхийг дээшлүүлж төрийн ажил үйлчилгээг сайжруулах бодлого, ажлын чиглэлийг аймаг, сум, баг, төрийн үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгж бүрээр тодорхойлон боловсруулж хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч үр дүнг тооцож, илтгэх

2/ Иргэн хүний хөгжлийн эрүүл биетэй нийгмийн хэрэгцээг хангасан боловсрол мэргэжилтэй, ахуй амьдралаа зохицуулах орлоготой байх тулгуур зарчмаар иргэдийн оролцоотой тодорхойлон хэрэгжүүлж нийгмийн салбаруудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах удирдлага, зохион байгуулалтын бодлогыг оновчтой тодорхойлон хэрэгжүүлэх

3/ Нийгмийн салбарын хөгжлийн хүрсэн түвшинг дээшлүүлэн, хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлон, мэргэшсэн боловсон хүчнээр бүрэн хангах, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авч салбар, нэгж бүрийг хүний хөгжлийг хангах менежментийн төлөвлөгөөтэй болгон хэрэгжүүлэх

4/ Буянт голын хөвөөнд Ховд хот байгуулагдсаны 250 жилийн ойг хөрөнгө оруулалт, арга хэмжээг баруун бүсийн тулгуур төв - Ховд хотын тохижилт, соёлжилт, өнгө үзэмжийг эрс сайжруулан иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах нөхцөлийг дээшлүүлэхэд хөрөнгө оруулалтыг төвлөрүүлж хөгжил, бүтээн байгуулалтыг дэмжих арга хэмжээ болгон зохион байгуулах

4. Аймгийн ИТХ-ын дарга /Х.Батболд/-д ДААЛГАХ нь:

1/. Аймаг, сумын ИТХ-ын 2009-2012 оны бүрэн эрхийн хугацаанд дэвшүүлсэн зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд ИТХ, Төлөөлөгч, Тэргүүлэгчид, ажлын албаны үйл ажиллагааг эрчимжүүлэн бодиттой дэмжлэг үзүүлж орон нутгийн хөгжлийг ахиулж тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд бодлогыг төвлөрүүлэн үр бүтээлтэй ажиллаж 2012 оны 3 дугаар улиралд багтаан бүрэн биелүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх

2/ Шинэ үеийн нутгийн өөрөө удирдах байгууллагын 20 жилийн ойг тохиолдуулан аймаг, сумын ИТХ, багийн ИНХ-ын үйл ажиллагааг бэхжүүлж чадавхижуулан төлөвшүүлэх, ажлын үр нөлөөг дээшлүүлэн орон нутгийн хөгжлийг тэтгэж, иргэдийн амьжиргааг дэмжих бодит ажлуудыг санаачлан бүтээлчээр тэмдэглэн өнгөрүүлэх

3/ Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдээс аймгийн хөгжлийг тэтгэх болон ялангуяа нэмүү бүтээгдэхүүн үйлдвэрлэж, тогтвортой ажлын байр бий болгохоор тусган баталсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэхэд илүү санаачилгатай, шуурхай ажиллаж, шаардлагатай асуудлуудыг зохих хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж хэрэгжилтэнд тавих хяналтыг өндөржүүлэх

5. Багийн ИНХ, сумын ИТХ-ын дарга нарт ЗӨВЛӨХ нь:

1/. 2009-2012 оны бүрэн эрхийн хугацааны үндсэн чиглэлд дэвшүүлсэн зорилт болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэхэд байгууллага, хамт олон, иргэдийн ажлыг уялдуулан эрчимжүүлж 2012 оны 3 дугаар улиралд багтаан биелэлтийг хангахаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах

2/ Хүний хөгжлийг дэмжиж орон нутгийн хөгжлийг эрчимжүүлэхээр иргэдийн оролцоотой, нутгийн онцлогт тохирсон алс хэтийн бодлогыг тодорхойлон боловсруулж сум, багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй бүхий л байгууллага, хамт олон, иргэдийн үүсгэл, санаачилга, идэвхийг өрнүүлэн хэрэгжүүлэх

3/. Шинэ үеийн нутгийн өөрөө удирдах байгууллага үүсч хөгжсөний 20 жилийн ойг сум, багийн хэмжээнд нутгийн өөрийн удирдлагыг төлөвшүүлэн чадавхижуулах, хүний хөгжлийг дэмжиж нутгийн хөгжлийг тэтгэх үйл ажиллагааг өрнүүлж, нутгийн бренд бүтээгдэхүүн бий болгохоор ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлэх

6. Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг эрчимжүүлэн, үр дүнг бүтэн жилээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаанд танилцуулж байхыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Ч.Багдал/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Х.БАТБОЛД

“Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2011 оны биелэлт аймгийн эдийн засаг нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн тухай” аймгийн Засаг дарга

Г.Нямдаваа итгэлдээ ... 2011 оныг “Их бүтээн байгуулалт-Эрчимтэй хөгжлийн жил” болгон зарласан аймгийн ИТХ-ын бодлого шийдвэрийг хэрэгжүүлж, баруун бүсийн тулгуур төв-загвар аймаг болгохын төлөө эрчимтэй хөдөлмөрлөж багагүй амжилт оллоо.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн явц Засгийн газраас баталсан аргачлалын дагуу сүүлийн 3 жилээр өссөн дүнгээр тооцоход хөтөлбөрийн биелэлт 88,0 хувь, аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт 91,0 хувьтай байна

Төрийн байгууллага, албан хаагчдын хариуцлага чадавхийг өндөржүүлж, төрийн албаны ил тод, нээлттэй, шуурхай байдлыг бий болгох зорилтын хүрээнд төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, хөдөөгийн багийн төвүүдийг тохижуулах, шинээр барьж байгуулах, ажиллах нөхцөлийг сайжруулан техник хэрэгслээр хангах ажлыг үргэлжлүүлэн хийсэн, эдгээрийн дотроос гадаад орнуудад нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллагуудын туршлага судлуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах зэргээр шинэлэг ажлуудыг зохион байгуулсны үр дүнд энэ салбарт дэвшүүлсэн зорилт 89.0 хувьтай хэрэгжиж байна.

Монгол улсын хууль, Засгийн газрын тогтоол шийдвэр, үндэсний хөтөлбөрүүдийн заалт бүрийг хяналтанд авч, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцыг эрчимжүүлэх чиглэлээр сум, байгууллагуудыг удирдлага, арга зүйгээр ханган ажиллаж, хэрэгжилтийн явцад давхардсан тоогоор 24 сум, 54 байгууллагад хяналт, шинжилгээ үнэлгээ хийлээ.

Хөдөөд төрийн үйлчилгээг хүргэх үндсэн нэгж болох “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд хөдөөгийн 62 багийн Засаг даргын мотоциклийг шинэчилж, Зэрэг сумын Бургасан, Мянгад сумын Цагаанбулан багуудыг улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулан жишиг баг болгож, Чандмань сумын Сүлжээ багт нүүдлийн төв, Манхан сумын Баянгол багийг соёлын төвтэй болголоо.

Дарви сум Монгол улсын Засгийн газрын 2009 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан улсын “Тэргүүний сум” шалгаруулах болзол журмыг хангаж, баруун бүсээс анх удаа “Улсын тэргүүний сум”-аар шалгарч батламж 100,0 сая төгрөгөөр шагнагдсан нь энэ хурлын илтгэлд онцлон тэмдэглэх үйл явдлын нэг юм.

Энэ жилийн өвөлжилтийн бэлтгэл хүлээн авах өдөрлөгийн үед “Аймгаас баг бүрт, сум, багаас өрх бүрт хүрч ажиллах зорилт” дэвшүүлэн, аймгийн Засаг даргын Тамгын газраас “Төрийн үйлчилгээг иргэдэд” сэдэвт өдөрлөгийг хөдөөгийн баг бүрт зохион байгуулж, аймгийн төр захиргааны байгууллагаас гаргаж байгаа бодлогын зорилтууд түүний хэрэгжилтийн явц байдлын тухай тодорхой тоо баримт, график дүрслэл, фото зургийн тайлбартайгаар танилцуулж, 10200 гаруй иргэд малчдад хүрч ажиллан тэдний санал бодлыг сонсож, төрийн болон урлаг соёлын зарим үйлчилгээг үзүүллээ. Энэ арга хэмжээний хүрээнд ард иргэдээс

гаргасан санал, тулгамдаж байгаа асуудлыг нэг бүрчлэн судлан үзэж, үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгай төлөвлөгөө гарган ажиллаж байна. -4-

Төрийн захиргааны албан хаагчийн тухайн албанд ажилласан хугацаа, төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ дүгнэсэн үнэлгээ, сум байгууллагаас ирүүлсэн саналыг дэмжин 20 байгууллагын 37 төрийн албан хаагчид аймгийн Засаг даргын захирамжаар зэрэг дэв олгож, төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн албан хаагч 15 хүн төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөлөө.

Энэ онд ОХУ-ын БНТыва, Алтайн хязгаар, Томск муж, Алтайн БНУ, БНХАУ-ын ШУӨЗО-ны Баянгол, Алтай, Цонж аймгуудад хийсэн албан ёсны айлчлалууд ихээхэн үр дүнтэй болсон.

2011 онд аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, төрийн болон төсвийн байгууллагын дарга, удирдлага, ажилтан албан хаагч, бизнес эрхлэгчид 150 гаруй хүн Ази, Европын өндөр хөгжилтэй улс гүрэн, Булангийн орнууд, АНУ-д мэргэжил дээшлүүлж туршлага судлан, 100 шахам иргэд аж ахуйн нэгж олон улсын үзэсгэлэн худалдаа, Эко аялалд оролцсон байна. Энэ нь манай аймгийн эдийн засаг, нийгмийн салбарын гадаад харилцаа улам өсөж байгааг харуулсан томоохон үзүүлэлт юм.

Иргэний шинэчилсэн бүртгэл, бичиг баримтыг сайжруулах ажил амжилттай хийгдэж 27.0 мянган зөрчил арилгаж, бүртгэлийн ажиллагаа 98.0 хувьтай байна.

Цагдаагийн газар Үенч, Цэцэг, Дөргөн, Дарви, Манхан сумдын цагдаагийн кабонуудыг барьж ашиглалтанд хүлээлгэж өгч, Хүндэтгэлийн талбай, спорт үйлчилгээний цогцолбор, нам даралтын зуухыг тус тус барьж ашиглалтанд орууллаа.

Цагдаагийн газарт 6 суудлын автомашин шинээр авч байнгын хөдөлгөөнт эргүүлд ашиглах болсноор гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн газарт шуурхай очиж ажиллах боломж бүрэн бүрдсэн юм.

Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Ой хээрийг түймрээс хамгаалах тухай, Улсын нөөцийн тухай хуулиудын хэрэгжилтийг хангах зорилгоор Засаг даргын нэрэмжит шалгалтыг давхардсан тоогоор 58 суманд зохион байгуулж, дүрэм, шаардлага зөрчсөн 650 зөрчил илрүүлж, 286 зөрчлийг засуулан, 247 зөрчлийг засуулахаар заавал биелүүлэх албан шаардлага 142, мэдэгдэл 9, танилцуулга 15-ыг өгч хяналт тавьж ажиллаа.

Булган суманд баригдах аврах гал унтраах ангийн 820 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий барилгын ажлыг эхлүүлэв. Энэ нь байгалийн хүнд нөхцөлд Алтайн өндөр давааны өмнө аймгийн төвөөс 300-аас илүү км алслагдан байрлах сум, багуудад шаардлагатай үед аврах, аюулаас сэргийлэхэд чухал ач холбогдолтойгоос гадна олон арван ажлын шинэ байр бий болгох чухал ач холбогдолтой юм.

Нийгмийн бодлогын хүрээнд үйлчилгээний хамрах хүрээг өргөжүүлж, чанар хүртээмжийг дээшлүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж мөрийн хөтөлбөрийн биелэлт 89.4 хувьтай байна.

Цэцэрлэгүүдэд шинээр 5 бүлэг нээн, 7 цэцэрлэгт гэр цэцэрлэг олгож нийт багуудад гэр цэцэрлэг ажиллуулан, хувилбарт бүлгүүдийн тоог нэмэгдүүлснээр сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 82.3 хувьд хүрч, өмнөх оныхоос 3.9 хувиар нэмэгдэн дэвшүүлсэн зорилт амжилттай хэрэгжлээ.

Ерөнхий боловсролын сургуулийн стандартын шинэчлэлийг хэрэгжүүлэн, бүх сумдад гэгээрэл төвүүдийг байгуулж, албан бус боловсролын хамрах хүрээ, хөтөлбөрийг өргөжүүлэн ажилласнаар бага болон суурь боловсролын хамралтыг өмнөх оноос 2.0-2.4 хувиар ахиулж, нийт 400 насанд хүрэгчдийг хууль эрх зүй, эрүүл мэнд, аж ахуй эрхлэх, амьдрах ухааны зэрэг албан бус сургалтанд хамруулан чадавхижуулав.

Сургууль төгсөгчдийн ерөнхий эрдмийн хичээлийн шалгалтын дундаж оноо 503,4–д хүрч, аймгуудын хэмжээнд 4 дүгээр байранд шалгарч, Прогресс, Цаст-Алтай цогцолбор, Жаргалантын 1, 2, 6, Дарви, Зэрэг, Дөргөн, Манхан, Мөнххайрхан, Дуут, Мөст, Мянгад сумын сургуулиуд шилдэг үнэлгээтэй сургуулийн болзлыг хангасан нь багш, сурагч, эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлж ажилласны үр дүн байлаа.

Хөгжил МСҮТ, ХААИС-ийн Алтайн бүсийн салбар сургуулиудыг “Хөгжил” политехникийн коллеж болгон өргөтгөж, 25 мастерын газар, 3 лабораторитойгоор 17 мэргэжлээр 1499 хүүхэд суралцуулж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцүүлэн Оюу толгойн хөрөнгө оруулалтаар 158 иргэнийг сургаж мэргэшүүлж байна.

Боловсролын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, суралцагсдын суралцах, хөгжих таатай орчинг бүрдүүлэх зорилгоор улсын болон олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар 2011 онд 3.1 тэрбум төгрөгийн барилга байгууламж шинээр баригдаж, 320.0 сая төгрөгийн их засвар, 260.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдлээ. Тухайлбал: Жаргалант сумын 320 хүүхдийн сургууль, Мөст сумын соёлын төв, Мөнххайрхан сумын сургуулийн спорт заал, Дөргөн сумын цэцэрлэгийн барилгыг ашиглалтанд оруулж, Прогресс дунд сургууль, Булган сумын 320 хүүхдийн сургууль, Мянгад сумын соёлын төв, Дуут, Буянт сумдын цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүллээ. Ховд хотод баригдаж буй “Баруун бүсийн хүүхэд, залуучуудын хүрээлэн” нь ирээдүй үеийнхнийхээ төлөө хийж буй улсын хэмжээний хамгийн том бүтээн байгуулалтын нэг болж, манай аймгийн олон компани, аж ахуйн нэгж хамтран ажиллаж, ашиглалтанд хэсэгчлэн өгч эхэллээ.

“Өв соёлоороо гоёцгооё” наадмыг зохион байгуулж, биет бус өв тээгчдийн уран бүтээлийг цахим бүртгэлд авч, олон үндэстэн ястнуудын өв соёлын хүрээлэн байгуулснаар өв соёлоо өвлүүлэн хөгжүүлэх, нийтэд сурталчлан дэлгэрүүлэх, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж бүрдлээ.

Ховдчууд бид цаашид олон үндэстэн ястныхаа бахархал болсон “Өв соёлын хүрээлэн”-гээ улам сайжруулан тохижуулах хэрэгтэй бөгөөд зарим сумдын удирдлага зориуд анхаарах шаардлагатай байгааг анхааруулж байна.

Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлэн Манхан сумын нутгаас 16 ширхэг хөшөө дурсгал, Ховд сумын нутгаас 2 буган чулуун хөшөө, Буянт сумын нутгаас нэг хүн чулуун хөшөө дурсгалыг илрүүлэн судалгааны эргэлтэнд оруулж, улсын хамгаалалтанд 3 дурсгал, аймгийн хамгаалалтанд 7 дурсгалыг бүртгүүлэхээр үндэслэл саналыг боловсруулаад байна.

Эрүүл мэндийн талаар эмч мэргэжилтний хангамжийг нэмэгдүүлэх, эмчилгээ оношилгооны дэвшилтэд технологийг нэвтрүүлж, нийгмийн эрүүл мэндийг хөгжүүлэх зорилт дэвшүүлэн ажилласнаар бүх сумд 2-оос дээш их эмчээр хангагдан, эх нярай, эд эсийн, болон зүрхний зайн оношлогоогоор 464 шинжилгээ, оношилгоог клиникийн төвийн эмнэлгүүдэд дамжуулан баталгаажуулж ажилласнаар иргэд Улаанбаатар хотын төрөлжсөн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмчийн тусламж, зөвлөмжийг орон нутагтаа авах боломж нэмэгдлээ. Энэ онд сумдын эмч, БОЭТ-ийн сувилахуйн албаны нийт 23 эмч мэргэжилтнийг гадаад орны богино хугацааны сургалт, туршлага судлах аялалд, давхардсан тоогоор 184 эмч мэргэжилтнийг орон нутгийн сургалтанд хамруулан чадавхижуулав.

Энэ онд сумдын эмч, БОЭТ-ийн сувилахуйн албаны нийт 23 эмч мэргэжилтнийг гадаад орны богино хугацааны сургалт, туршлага судлах аялалд, давхардсан тоогоор 184 эмч мэргэжилтнийг орон нутгийн сургалтанд хамруулан чадавхижуулав.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нялхсын эндэгдэл 5 тохиолдлоор, 100 мянган амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 5.8 пунктаар буурч, халдварт өвчний гаралт нэмэгдсэний 66.8 хувийг халдварт шар өвчин эзэлж байна.

Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахаар Бельги улсын Засгийн газрын 6 сая евро буюу 10.8 тэрбум төгрөгний өртөг бүхий төсөлд хамруулахаар шийдвэрлүүлээ. Энэ нь алслагдсан бүс нутгийн ард иргэдэд нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг чанартай шуурхай авах боломж нөхцлийг бүрдүүлэх юм.

Шинээр 50 ортой амаржих газрыг ашиглалтанд оруулж, Зэрэг, Манхан суманд 15 ортой шинэ эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлж, 3 сумын эмнэлэг, 6 өрхийн эмнэлгийн машин, 56 багийн эмчийн мотоциклийг шинэчилснээр эмнэлгийн тусламж үйлчилгээний шуурхай байдлыг сайжруулах боломж дээшиллээ.

2009-2011 онуудад улсын аварга шалгаруулах 6 удаагийн, бүсийн 11 удаагийн уралдаан тэмцээнийг аймагтаа зохион байгуулж манай тамирчид нийт 494 медаль хүртээд байна. Нийгмийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажлын хүрээнд уулын спортыг хөгжүүлэхэд анхаарч баруун бүсийн сарьдаг ноён оргилууд болох Хүйтний оргил,

Хөх сэрхийн ноён оргилуудад аймгийн уулчид амжилттай авирч, шинэлэг амжилтуудыг тогтоолоо.

2011 оныг Засгийн газраас “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгон зарласны дагуу орон нутгийн мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог ханган, түншлэлийг хөгжүүлэх бодлого зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд нийт 2160 ажлын байр шинээр бий болгож, зохион байгуулсан ажлынхаа үр дүнгээр баруун бүсдээ тэргүүлсэн амжилт үзүүллээ.

Энэ хүрээнд өдөлмөр эрхэлдэггүй 3280 иргэн, 1155 ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг үндэсний мэдээллийн санд байршууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэргэжил олгох, давтан сургах үйлчилгээнд нийт 831 хүнийг хамруулан сургаснаас 60.5 хувь нь тухайн суралцсан мэргэжлийн чиглэлээрээ ажиллаж байна.

Нийтийг хамарсан ажлын 82 төслийг орон нутгийн хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулж, эмзэг бүлгийн 1358 хүнийг хамруулан түр ажлын байраар хангасны 92.5% нь байгаль орчин хамгаалах, ногоон ажлын байр байлаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд орон нутагт ажиллаж байгаа олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагууд ч ач холбогдол өгч оролцлоо. Тухайлбал зөвхөн Мерси Кор олон улсын байгууллага хэрэгжүүлж буй төслийнхээ хүрээнд нийт 308 байнгын, 79 түр ажлын байр гаргасан байна.

Нийгмийн халамжийн хуулиудыг сурталчлан хэрэгжүүлж иргэдэд халамжийн сангаас 2.1 тэрбум төгрөгийн тэтгэмж, хөнгөлөлт, даатгалын сангаас 12.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, хүний хөгжил сангаас 19.0 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгон “Цагаан-Уул” ахмадын амралт сувиллын газарт 185 ахмад настанг амраан сувилж, 2959 ахмадад 418.2 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлт үзүүлээд аймаг Ахмадын өргөөтэй болсон нь ахмаднастнуудын талархлыг хүлээж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр дэвшүүлсэн зорилтхэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалт, сувиллын төвийг Дэлхийн зөн олон улсын байгууллагын 100 мянган долларын дэмжлэгээр байгуулж, тус төвийн ажиллагсдыг мэргэшүүлэн тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүллээ.

Санхүү эдийн засгийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилт 86.7 хувьтай хэрэгжиж байна.

Аймгийн нийгэм эдийн засгийн гол үзүүлэлт болох ДНБ-ийг Үндэсний Статистикийн хорооноос шинээр боловсруулсан аргачлалын дагуу тооцоход 2010 оны гүйцэтгэлээр 156.4 тэрбум төгрөгт хүрч, 2009 оныхоос 9.0 тэрбум төгрөгөөр буюу 7.7 хувиар өссөн байна.

Төрийн сангийн мэдээллийн сүлжээнд 17 сумыг холбосноор санхүүгийн сүлжээнд тогтмол хяналт тавьж, дансны үлдэгдлийг байнга хянах, мэдээ тайланг үнэн зөв авч, өр

авлага гаргуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээгээр сумдын төрийн сангийн болон санхүүгийн программын зарим хэсгийн шинэчлэлт хийж, цаашид сумдад ажилллаж байгаа төрийн сангийн төлөөлөгч нарын ажил үүргийн хуваарь дээр статистик тоо мэдээг нэмж хариуцуулан чадваржуулж, тогтвор суурьшилтай ажиллуулахад анхааран төрийн сангийн төлөөлөгч нарын үндсэн цалинг 20 хувиар нэмэгдүүллээ.

2011 орон нутгийн төсөвт нийт 3822.1 сая төгрөгийн орлого оруулахаас 4287.6 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 439.5 сая төгрөгөөр давуулан биелүүлэхээр байгаа нь нэг талаас ард иргэд, аж ахуй нэгжүүдийн татварын хуулийн ойлголт, хэрэгжүүлэлт нэмэгдэж байгаа, нөгөө талаас татварын байцаагчдын ажлын ур чадвар, уялдаа холбоо, хуулийн сурталчилгаа сайжирч байгаагийн илрэл юм.

2010 онд тус аймагт орон нутгийн болон төсвийн хөрөнгө оруулалт гадаад, дотоодын зээл тусламж, төсөл хөтөлбөр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 28.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж байсан бол 2011 онд хөрөнгө оруулалтын бүх сувгаар 73.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж даруй 2.6 дахин нэмэгдсэн байна.

Хөрөнгө оруулалтын тендерийн үйл ажиллагааг иргэдэд нээлттэй, ил тод болгохын тулд Мерси Кор олон улсын төслийн байгууллага болон Сангийн яамны худалдан авах ажиллагааны газартай, Санхүү төрийн сангийн хэлтэс хамтран сургалт зохион байгуулж, 40 гаруй хүнд тендерийн үнэлгээний хороонд ажиллах эрхийн бичгийг олгож, үнэлгээний ажлыг ил тод нээлттэй болгож ажилласны үр дүнд дэлхийн нээлттэй форумаас 2011 онд явуулсан судалгаагаар 2 дугаар байр эзэлсэн нь сайшаалтай хэрэг юм.

Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалт бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан ажиллаж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсний үр дүнд 2008 онд 33.7 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байсан бол 2011 онд 104,7 сая төгрөг болж өссөн байна.

Дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуй, байгаль орчны талаар үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 157 зорилтыг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулан бодлого зорилтоо чиглүүлэн ажилласнаар хэрэгжилт 86.0 хувьтай байна.

Сүүлийн жилүүдэд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх ажилд бодитой дэвшил гарч, санхүү зээлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн 2.6 тэрбум төгрөгийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг бүрдүүлж, үүнээс гадна сум бүрт хүн амын тооноос хамааран 50.0-265.0 сая төгрөгийн эх үүсвэр бүхий “Сум хөгжүүлэх сан” байгууллаа.

Дээрх хөнгөлөлттэй зээл олгох ажлыг орон нутагт амжилттай зохион байгуулснаар энэ онд 145 жижиг дунд үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжиж, 487 ажлын байр шинээр бий болгон, 314 ажлын байр хадгалагдсан байна. Хэдийгээр жижиг дунд үйлдвэрийг дэмжих

зээлийн эх үүсвэрүүд бий болсон ч түүнийг хэрхэн үр дүнтэй ашиглах, илүү амжилтанд хүргэх асуудал бидний тулгамдсан зорилтын нэг болж байна.

Хүнсний ногоо савлах үйлдвэр баригдаж, ХАА-н түүхий эдийн цэвэрлэх байгууламжийн зураг төслийг боловсруулах зэрэг томоохон хөрөнгө оруулалт хийгдлээ. Эдгээр хөрөнгө оруулалтын үр дүнд ХАА-н гаралтай түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоод гадаадын зах зээлд нийлүүлэх таатай боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Монгол мал хөтөлбөрийн баруун бүсийн улсын зөвлөгөөн, аймгийн Бизнес эрхлэгчид, МАА-н мэргэжилтэн, Газар тариалан эрхлэгчид, Залуу малчдын зөвлөгөөнүүдийг тус тус зохион байгуулж, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх зорилтоо тодорхойлон хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Энэ онд МАА-н үйлдвэрлэлд 8500 малчин өрхөд 18043 хүн ажиллаж, жилд дунджаар 11-12,0 мянган тн мах, 794,7 мян тонн ноос, 247,2 мян тонн ноолуур, 500-600 мянган ширхэг арьс, шир зах зээлд нийлүүлж, ХАА-н салбар нь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг үйлдвэрлэж байна.

2011 оны жилийн эцсийн урьдчилсан дүнгээр 1684.8 мянган мал тоолуулснаас тэмээ 16.5, адуу 64.9, үхэр 78.9 хонь 591.7, ямаа 932.6 мянгыг тоолуулж урьд онтой харьцуулахад 2.8 хувиар буюу 45.6 мянган толгойгоор өссөн дүнтэй байна.

Дарви, Дөргөн, Ховд, Чандмань, Эрдэнэбүрэн сумууд малаа таван төрөл дээр нь өсгөсөн байна.

Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй 27 худгийг шинээр гаргаж, бэлчээрийн хортон шавьжтай тэмцэх зорилгоор царцааны устгалын ажлыг 30.0 мян га-д 91.3 хувийн техникийн үр дүнтэй хийж, 115 хүнийг түр ажлын байраар хангасан байна.

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс эрүүл болохыг баталгаажуулах, вакцин хэрэглэдэггүй аймаг болох тандан шинжилгээнд 15 сумын 2280 малыг хамруулж шинжлүүлснээр гоц халдварт өвчнөөр тайван, вакцин хэрэглэдэггүй бүсийн ангилалд багтаж, бруцеллёз, ям зэрэг 5 өвчний өвчлөл тархалтыг тогтоох шинжилгээг 17 сумын 10.7 мянган малд хийхэд эдгээр өвчнөөр тайван гэсэн дүгнэлт гарсан нь мал мах экспортлох, зах зээлд нийлүүлэх, малын үнэ ханшийг нэмэгдүүлэх нөхцлийг баталгаажуулсан чухал ач холбогдолтой үзүүлэлт боллоо.

Мал сүргийг бүртгэлжүүлэх, ээмэгжүүлэх ажилд 70 гаруй мянган үхэр, 100 гаруй мянган бог малыг хамруулж, үндэсний үйлдвэрт хонь, тэмээний ноос тушаасан 2457 малчны материалыг бүрдүүлж мал хамгаалах санд хүргүүлснээр 469.0 тн хонины ноос, 11.8 тн тэмээний ноосонд урамшуулал олгуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллалаа.

Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, усалгаатай газар тариаланг хөгжүүлэх талаар дэвшүүлсэн бодлого зорилтууд амжилттай хэрэгжиж, Буянт голын 2400 га-гийн услалтын системийн барилгын ажлыг үргэлжүүлэн энэ онд 307 га-гийн системийг ашиглалтад оруулахад бэлэн болж, Эрдэнэбүрэн сумын Бандийн услалтын системийг Швецарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр сэргээн засварлалаа.

Энэ онд 40 аж ахуйн нэгж, 3700 тариаланчид нийт 2909.2 га-д тариалалт хийж, талбайн хэмжээг урьд оныхоос 209 га-аар нэмэгдүүлэн, үр тариа 620.6 тн, төмс 18902.2 тн, хүнсний ногоо 10272.4 тн, тэжээлийн ургамал 3580 тн нийт 28151 мянган тн ургац хураан авсан нь өмнөх оныхоос 5.0 мянган тн-оор илүү байна.

Мянгад, Зэрэг, Мөнххайрхан, Дарви, Ховд, Эрдэнэбүрэн сумдын 04-ийн шугамыг шинэчлэн Зэрэг сумын трансформаторын хүчин чадлыг нэмэгдүүлж, Цэцэг сумыг ЦДАШ-д шугамд холбох зураг төслийг боловсруулан хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсвийн тодотголд тусган гүйцэтгэгчийг сонгон шалгарууллаа.

Энэ онд Мянганы замын босоо тэнхлэгийн дагуу Ховд-Манхан чиглэлийн 85.3 км, Мөстийн Бага улаан даваа-Алтайн Тэмээн хүзүү чиглэлийн 110.8 км, хэвтээ тэнхлэгийн дагуу Манхан-Дарви чиглэлийн 100 км хатуу хучилттай авто замуудыг барих ажлыг эхлүүлж амжилттай ажиллаж байна.

Аймгийн төвийн авто замыг шинэчлэх төслийг амжилттай эхлүүлж аймгийн 80 жилийн ойг угтан 5.1 км хатуу хучилттай авто замыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчиллээ.

Манай аймгийн хамгийн тулгамдсан асуудал болсон Дулааны станцын хэвийн ажиллагааг хангах, шугам сүлжээний нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, горим тохируулгын ажлыг шинээр байгуулагдсан албатай хамтран хийж, өвөлжилтийн бэлтгэлийг хангах, зуухны засвар шинэчлэлийн ажлын график гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа. Дулааны станцын 2, 3 дугаар зуухны ул ширэм, халах гадаргууг бүрэн шинэчлэн сольж, одоогийн байдлаар 3 зуух ашиглалтад орж, ирэх онд иж бүрэн шинэ зуух нэмж суурилуулах бэлтгэлийг хангалаа.

Дулааны хоёр дахь эх үүсвэрийг байгуулах эхлэлийг тавьж, газрын байршлыг сонгон түүнд үндэслэн ТЭЗҮ, зураг төсвийг боловсруулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил ЭБЭХЯ-нд хийгдэж байна. Энэ ажилд нийт 14 тэрбум төгрөг төсөвлөгдөж байна.

Засгийн газрын 100000 айлын орон сууц хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан орон сууцжуулах бодлогын зорилт амжилттай хэрэгжих нөхцөл бүрдэж, энэ онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 102 айлын орон сууц барьж ашиглалтад орууллаа.

Газрын тухай хууль, газар өмчлөлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу иргэн бүрт газар өмчлүүлэх бодлогын хүрээнд иргэнд олгох газрын хэмжээ, хязгаарыг 2011 оны аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, өссөн дүнгээр аймгийн хэмжээнд нийт 8462 иргэнд 1251.8 га газрыг өмчлүүлж, 9810 иргэнд 15101.01 га газрыг эзэмшүүлээд байна.

Газрын зөрчил маргааныг шийдвэрлэх ажлыг зохион байгуулж аймгийн төвд 300 гаруй зөрчилл байгаагийн 166-г арилгахаар төлөвлөснөөс 134 –ийг бүрэн арилгаж ажиллаа.

Ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлыг 40 га талбайд, Ногоон хэрмийн үндсэн зурвасыг 10 га талбайд байгуулж, “Мод тарьж ургуулах үндэсний өдөр”-өөр 41924 мод, бут, жимс, жимсгэнийг суулгаж, аймгийн төвд 16038.9 м² талбайг зүлэгжүүлж, 126 цэцгийн мандал байгууллаа.

Энэ оныг Засгийн газраас “Усны жил” болгосонтой холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрт гадаргын ус, уст цэгийн тооллого судалгааг хийж, судалгаагаар 5 хөв цөөрөм, 4 УЦС, 5 услалтын систем, 4 үерийн хамгаалалт, 1187 худаг, 216 гол горхи, 27 рашаан, 119 нуур байгааг тогтоож, улсын болон төсөл хөтөлбөрийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр 14 булаг, шандны эхийг хамгаалан тохижуулж, Мөст, Эрдэнэбүрэн сумдын төвийн гүнийн худагт ус зөөлрүүлж, цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулан, ундны усны чанар, стандартыг сайжрууллаа.

Мянган Угалзатын БЦГ-ын хилийн цэсийг өргөтгөн Бөөрөг, Балгатайн нурууны 234725 га талбай, Мөнххайрханы БЦГ-ыг өргөтгөн Үенчийн хавцал, Мандалхайрхан уулын 191525 га талбай, Булган гол-Их Онгогийн 79954.7 га талбайг улсын тусгай хамгаалалтанд авч, аймгийн нийт нутаг дэвсгэрийн 32 хувийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулсан нь бусад аймгуудтай харьцуулахад илүү хувьтай байгаа юм.

“Монгол Алтайн нурууны биологийн төрөл зүйлийг хамгаалах стратеги төлөвлөгөө”-г хэрэгжүүлсэн нь ан, амьтан, ургамлын төрөл зүйлийг хамгаалах, судлах, зохистой ашиглах, цаашид байгалийн нөөцийн зохистой менежментийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүллээ.

Ховд аймгийн нийгэм, эдийн засгийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулахдаа 2012 оныг “Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж, хүний хөгжлийг дэмжих жил” болгон хөрөнгө оруулалт, ажлын байрыг нэмэгдүүлж, жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх зорилтыг дэвшүүлж хэрэгжүүлэхийн зэрэгцээ Ховд хот өнөөгийн бууриндаа шилжин суурьшсаны 250, Ховд хот Манжийн амбанаас чөлөөлөгдсөний 100 жилийн түүхт ойнуудыг угтаж, өмнөх жилийн ололт, туршлага дээрээ тулгуурлан Ард Аюушийн талбайг шинэчлэх, гэрэлтүүлэх, ногоон байгууламжийг өргөжүүлэх, хотын доторхи замыг шинэчлэн дуусгах, дулаан хангамжийн шинэ эх үүсвэрийг барьж эхлэх, цэвэр бохир усны системийг өргөтгөх, үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлж үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр ахиц дэвшил гаргах зорилтууд дэвшүүлээд байна.

Энэ арга хэмжээний хүрээнд нийтдээ 565.8 сая төгрөг зарцуулж 6 багийн төвийг ЦДАШ-д холбоно.

2012 онд Багийн хөгжлийн дэмжих хөтөлбөрт 660.0 сая, орон нутгийн хөгжлийг дэмжихэд 100.0 сая, Хөдөөгийн хүн амын үүрэн телефон утасны хүртээмжийг нэмэгдүүлэхэд 170.0 сая Хөдөөгийн залуусын хөгжил мэдээлэл хөтөлбөрт 80.0 сая Сумдын номын сангуудад 20.0 сая, сумдын эмнэлгийн оношилгооны анализатор авахад 200.0 сая гэх мэтчилэн хөдөөгийн хөгжилд зориулсан олон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр үндсэн чиглэлд тусгаад байна.

УИХ-ын 2010 оны 36 тогтоолоор батлагдсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хөдөөгийн хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд “Сум дундын төв” төсөлд Дарви сумыг хамруулна.

Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын 110.8 км, Манхан- Ховдын 85.3 км, Манхан-Дарви чиглэлийн 100 км хатуу хучилттай авто замыг барьж байгуулан ихэнх хэсгийг ашиглалтанд оруулснаар манай аймгийн 10 сум хатуу хучилттай авто замаар аймгийн төвтэй холбогдох нөхцөл бүрдүүлэхээр үндсэн чиглэлд тусгасаныг хуралдаанд илтгэсэн байна.

Тус илтгэлийг аймгийн ИТХ-ын МАН-ын бүлэгээс хэлэлцээд хэрэгжүүлсэн ажлын дүнг тэмдэглээд аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг “Хангалттай сайн” биелүүлсэн гэж дүгнэж хүрсэн амжилтаа бататгаж Ховд хотын 250 жилийн ойг “Бүтээлч хөдөлмөрийн баяр” болгон тэмдэглэж хөтөлбөрийн зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарахыг санал болгосон байна.

Мөн Ардчилсан намын бүлгээс үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтоо хэрэгжүүлэн биелэлт нь 88,0 хувьтай байгаа тул үр дүнг “Хангалттай” гэж дүгнэжээ.

Тус илтгэлийг аймгийн ИТХ-ын нийгмийн бодлого болон хүнс, ХАА, байгаль орчны хорооны хурлаар хэлэлцээд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хэрэгжүүлсэн ажлыг сайшаан тэмдэглээд үр дүнг “Хангалттай” гэж дүгнэн хуралдаанд оруулсан байна.

Хуралдаанд аймгийн АН-ын дарга н.Пүрэвдорж үг хэлж ... Ховдод ажилгүйдэл, ядуурал, архидалт, гэмт хэрэг их байгаа нь төсөв хөрөнгө оруулалт байгаа онохгүй, хүнээ олохгүй байгаатай холбоотой гэж алдахгүй боддог тооны машиныг, Төсвийн үргүй зардал нэмэгдэж ард түмний мөнгийг хэмнэх, төсвийн зардал нэг бүрийг олж харах нүд дутаж байгаа тул ард түмний амьдралыг хараарай гэж томруулагч шил, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Архигүй Монголын төлөө” аяныг хэрэгжүүлэхийг уриалж сүү бэлэглэе гэж аймгийн Засаг даргад гардуулжээ.

Хуралдаан аймгийн Засаг даргын илтгэлийг хэлэлцээд 9/03 дугаар тогтоолыг баталсан байна.

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН IX ХУРАЛДААНЫТОГТООЛ

2011.12.23

№ 9/03

Ховд

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны
хөтөлбөр, 2011 оны Үндсэн чиглэлийн
биелэлтэнд үнэлэлт өгөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, аймгийн Засаг дарга Г.Нямдаваагийн “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2011 оны биелэлт, аймгийн эдийн засаг, нийгмийн 2012 оны үндсэн чиглэлийн тухай” илтгэлийг хэлэлцээд аймгийн ИТХ-ын 9 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, 2011 онд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг “хангалттай” гэж дүгнэсүгэй.

2.Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2012 оны үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

3.Аймгийн Засаг дарга /Г.Нямдаваа/-д ДААЛГАХ нь:

1/.Аймгийн Засаг даргын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд бүх талын арга хэмжээг эрчимтэй шуурхай зохион байгуулж 2012 оны 3 дугаар улиралд багтаан бүрэн биелүүлж, үр дүнд хүргэх

2/.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас баталсан болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан боловсруулах үйлдвэр, ялангуяа мах, малын гаралтай түүхий эд болон газар тариалангийн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрүүдийг ашиглалтанд оруулахад шаардлагатай хөрөнгө санхүү, удирдлага зохион байгуулалтын асуудлыг нэн тэргүүнд шуурхай шийдвэрлэн биелэлтийг хангах арга хэмжээ авах

3/ .”Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж хүний хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд хийх ажлыг бодиттой тодорхойлон бүх шатны байгууллага, иргэдийн оролцоо, идэвх санаачилгыг өрнүүлэн төрийн үйлчилгээг сайжруулж эцсийн үр дүнгийн хариуцалгыг өндөржүүлж төр, хувийн хэвшил, ТББ, иргэдийн оролцоо хамтын ажиллагааны түншлэлээр тогтвортой хөгжлийг дэмжсэн арга хэмжээг хэрэгжүүлж бодит үр дүнд хүргэх

4/. Бензин шатахуун болон зарим хүнсний барааны хангамжийг сайжруулж хэрэглээг тогтвортой хангах, үнийн өсөлтөөс хамгаалах, нөөцийг бүрдүүлэх санхүүгийн эх үүсвэрийг эрх бүхий байгууллагуудын дэмжлэг болон дотоод нөөц бололцоог ашиглан шийдвэрлэн хэрэгжүүлэх

5/. Аймаг орлогоороо зарлагаа нөхөж өөрийгөө санхүүжүүлэх болсонтой холбогдуулан орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх ажиллагааг сайжруулан зарлага санхүүжилт, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн хяналтыг өндөржүүлж санхүүгийн сахилгыг

бэхжүүлэн төсөв захирагчид болон санхүү бүртгэлийн ажилтнуудын ажлын хариуцлагыг эрс дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах

6/. Хөшөөтийн уурхайн Мо Эн Ко компанитай 2011 онд байгуулсан хамтын ажиллагааны гэрээг дүгнэж тус компаниас 2012 онд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого болон нийгмийн хариуцлагын санхүүжилтийг бүрдүүлэх талаар 2012 оны 1 дүгээр сард багтаан өмнөх гэрээг шинэчлэн баталж аймгийн эдийн засаг нийгмийн дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтийг хангах санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулан хугацаандаа бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллах

7/. Ховд хотод баригдах дулааны 2 дахь эх үүсвэрийн хөрөнгө оруулалтыг бүрдүүлэх, барилга, байгууламжийг барих асуудлуудыг эрх бүхий байгууллагуудтай хамтарч шуурхай зохион байгуулах арга хэмжээ авч тус эх үүсвэрт холбогдох барилга, байгууламжуудын шугам сүлжээний зураг, төсвийг 2012 оны эхний хагас жилд багтаан гаргаж санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэн бэлтгэл ажлыг бүрэн хангах

8/. Ховд хотын агаарын бохирдолд мэргэжлийн байгууллагуудын оролцоотой хяналт шинжилгээ үнэлгээ хийж айл өрхөд утаагүй түлш, зуух хэрэглэх, өөрийн халаалтын систем бүхий аж ахуйн нэгж байгууллагуудыг дулааны нэгдсэн системд холбох замаар агаарын бохирдлыг хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөлгүй хэмжээнд хүртэл бууруулах бодлогыг 2012 оны 1 дүгээр улиралд багтаан тодорхойлж хэрэгжүүлэх арга хэмжээ авах

9/. Нийтийн эзэмшлийн гудамж талбай, барилга байгууламж, хөшөө дурсгал болон бусад өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулж, бүрэн, бүтэн байдлыг хангах асуудлыг журамлаж, олон нийтэд өргөнөөр сурталчилан иргэдийн оролцоотой тавих хяналтыг өндөржүүлж ажиллах

3.Сумдын Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

1/. 2009-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэн хугацаандаа бүрэн биелүүлж үр дүнг хангаж ажиллах

2/. Ард түмний уламжлалт зан заншил, соёл иргэншлийг баяжуулан орчин үеийн хөгжил, дэвшлийг түшиглэсэн хүний хөгжлийг дэмжих иргэдэд хандсан сургалт, сурталчилгаа, мэдээллийн хүрээг өргөтгөж, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг эрс сайжруулан тэргүүн туршлага, ажлын шинэ арга барил, санал санаачилгыг нийтийн хүртээл болгосноор иргэдийн ахуй амьдралын хандлагыг өөрчлөх бодлого болгон хэрэгжүүлэх

3/. Сум хөгжүүлэх сангаас жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор олгож буй санхүү, зээлийн дэмжлэгийг сум орон нутагтаа нэн шаардлагатай, зах зээлд өрсөлдөх чадвартай, тогтвортой ажиллах боломжтой төсөл хөтөлбөрүүдийг сонгон хамааруулж хөрөнгийн үр ашгийг сайжруулан иргэн, айл өрхийн орлогыг нэмэгдүүлж, амьдралыг тэтгэх арга хэмжээ авах

4/.Орон нутгийн байгалийн баялгийн ашиглалтанд тавих хяналтыг дээшлүүлж, иргэдийн оролцоотой байгаль орчин, бүтээсэн эд баялгаа хамгаалах, оршин суугч иргэдийн аюулгүй амьдралын баталгааг хангах, нийгмийн хэв журмыг сайжруулах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах

4.Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг эрчимжүүлэн, үр дүнг хагас, бүтэн жилээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж байхыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Л.Батбаяр/-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Х.БАТБОЛД

“Аймгийн төсвийн 2011 оны урьдчилсан гүйцэтгэл, 2012 оны төсөл, 2010 оны гүйцэтгэлийн тухай” аймгийн Засаг даргын тамгын газрын санхүү эдийн засаг бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Д.Алтангэрэл илтгэлдээ ...Тайлант жилд татвар төлөгч ААНэгжийн тооллого явуулж 1194 аж ахуйн нэгж тооллогод хамаарагдан, нийт орлогоор орон нутгийн төсөвт 3,8 тэрбум төгрөг оруулахаас 4,2 тэрбум төгрөг, татварын орлогоор 3,5 тэрбум төгрөг оруулахаас 3,7 тэрбум төгрөг, улсын төсөвт 1,0 тэрбум төгрөг оруулахаас 1,1 тэрбум төгрөг тус тус оруулж орон нутгийн зарлагаар 6,4 тэрбум төгрөг, улсын төсвийн байгууллагуудын зардалд 27,8 тэрбум төгрөг тус тус санхүүжүүлсэн байна. 2011 онд замын сангийн хөрөнгөөр 0,2 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 0,8 тэрбум төгрөг улсын төсөв болон бусад хөрөнгө оруулалтаар 71,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллажээ.

2012 онд орон нутгийн төсөвт нийт орлогоор 9,4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс татварын орлогоор 8,8 тэрбум төгрөг, нийт зардлыг 8,5 тэрбум төгрөг байхаар төлөвлөж аймаг анх удаа өөрийгөө санхүүжүүлэх төлөвлөлт хийж орон нутгийн төсвөөс 1,0 тэрбум төгрөг, улсын төсвөөс 69,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оуулалт хийхээр төлөвлөсөнийг тэмдэглээд 2010 оны төсвийн гүйцэтгэлийг орлогыг 4,1 тэрбум төгрөг, зарлагыг 4,7 тэрбум төгрөгийн байхаар батлуулах саналыг илтгэсэн байна.

“Аймгийн Аудитын газрын 2009 оны ажлын тайлан, орон нутгийн 2010 оны төсвийн төсөлд төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж орлого нэмэгдүүлэх талаар өгөх саналын тухай” аймгийн Ерөнхий аудитор Ч.Цэрэнчимэд илтгэлдээ 163 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулсанаар 57,0 хувь буюу 93 тайлан “Зөрчилгүй дүгнэлт”, 38,6 хувь буюу 63 тайлан “Сөрөг дүгнэлт ” дүгнэлт өгсөн байна. Санхүүгийн тайлангийн аудитад хамаарагдсан 163 байгууллагын дүнгээр 7,3 тэрбум төгрөгийн алдаа илэрүүлсэнээс 54,5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 26,0 сая төгрөгийн авлага, 27,2 сая төгрөгийн бараа материал, 1342,7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 9,1 сая төгрөгийн өр төлбөр, 2803,9 сая төгрөгийн өмчийн дансдын гүйлгээг, төсвийн урсгал орлогыг 250,5 сая төгрөг, зарлагыг 270,8 сая төгрөг илүү буюу дутуу дүнгээр илэрхийлсэнээс тайлангийн үеийн үр дүн буюу төсвийн ашиг, алдагдал 2165,4 сая төгрөгөөр хэтэрүүлэн буруу тооцогдсон байна.

Тайлангийн хугацаанд 52 сум, байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийж 948,5 сая төгрөгийн зөрчил төлбөр илрүүлсэнээс 214,1 сая төгрөг нь төлбөр, 734,4 сая төгрөг нь зөрчил байсаныг тайландаа дурдаад аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн хандивын дансанд иргэд байгууллагаас 299,7 сая төгрөг бэлнээр төвлөрч 165,3 сая төгрөгийн бэлэн бусаар хандив цугларч ой угтсан хөрөнгө оруулалтанд зориулан давсан орлогоос 504,4 сая төгрөг 2011 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаас 98,7 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 19,0 сая төгрөг, нийт 1,1 тэрбум төгрөг төвлөрсөнөөс 60,5 хувь буюу 655,2 сая төгрөгийг бүтээн байгуулалтанд, 39,5 хувь буюу 427,4 сая төгрөгийн ойн арга хэмжээнд зарцуулсаныг илтгэлдээ тэмдэглэн 2012 онд орон нутгийн орлогыг 63,0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн үр ашиг, арвилан хэмнэлтийг 73,3 сая төгрөгөөр сайжруулах бололцоотой байна гэсэн санал дүгнэлтийг оруулсан байна.

Аймгийн ИТХ-ын эдийн засгийн хорооны хурлаар Д.Алтангэрэлийн илтгэлийг хэлэлцээд илтгэлийг хуралдаанд оруулж хэлэлцүүлэх, төсвийн байгууллагууд гадаад дотоодод аялал хийхгүй байхыг тэмдэглээд төсвийн саналд Шим ус компаний хөрөнгө оруулалтаас 40,0 сая төгрөгийг хасах, Ач заяа эмнэлгийн Томографийн аппаратын 94,0 сая төгрөгөөс 30,0 сая төгрөгийг хасах, БОЭТөвд дуудлагын машин авахад 30,0 сая төгрөг, Дарви сумын сургуулийн ширээ сандал авахад 15,0 сая төгрөг, Хайрхан, Бугат багийн замын гэрэлтүүлэгт 25,0 сая төгрөгийг тус тус нэмж тусгах, улсын төсвийн байгууллагуудын 2012 оны төсвийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар дэмжүүлэхээр эрх шилжүүлэх зэрэг саналыг хуралдаанд оруулсан байна. Мөн Ч.Цэрэнчимэд даргын илтгэлийг хэлэлцээд ... аудитын газрын 2011 оны ажлын дүнг “Хангалттай сайн” биелүүлсэн байна гэж дүгнээд орлогыг 63,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, төсвийн үр ашгийг дээшлүүлэх саналыг тус тус дэмжих, МоЭнКо компаниас төвлөрүүлэх 4431,0 сая төгрөгийг оруулах талаар гэрээ байгуулж биелэлтэнд хяналт тавьж ажиллах саналыг хуралдаанд оруулсан байна.

Хуралдааны “Орон нутгийн 2012 оны төсөв батлах тухай” 9/04 тогтоолоор аймгийн 2012 оны төсвийн орлогын доод хязгаарыг 9505,2 сая төгрөгөөр үүнээс татварын орлогыг 8863,7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 8458,3 сая төгрөгөөр, орон нутгийн төсөв болон замын сангийн хөрөнгө оруулалтыг 1225,6 сая төгрөгөөр, сумдын төсвийн орлогын доод хязгаарыг 2373,7 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэгийг 2703,3 сая төгрөгөөр баталж улсын төсвийн байгууллагуудын 2012 оны төсвийг дэмжиж шийдвэрлэх эрхийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд шилжүүлжээ. Орон нутгийн төсвийн 2010 оны гүйцэтгэл батлах тухай 9/05 дугаар тогтоолоор аймгийн төсвийн 2010 оны орлогыг 4063,5 сая төгрөгөөр, зарлагыг 5629,9 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Хуралдааны “Тайланд үнэлэлт өгч санал дэмжих тухай” 9/06 дугаар тогтоолоор аймгийн Аудитын газрыг 2011 онд ажил үүргээ хууль эрх зүйн хүрээнд “Хангалттай сайн”

биелүүлсэн гэж дүгнэж 2012 оны аймгийн төсвийн орлогыг 63,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, зардлын үр ашгийг 73,0 сая төгрөгөөр сайжруулсаныг дэмжсэн байна.

Аймгийн 2011 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2012 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тухай” аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын дарга У.Батзаяа илтгэлдээ... аймгийн газрын нэгдмэл сан нийт 7,6 сая га бөгөөд ХАА-н газар 5,6 сая га буюу 75,6 хувь, хот, тосгон суурин газар 35,31 га буюу 0,46 га, зам, шугам сүлжээний газар 26,3 мянган га буюу 0,35 хувь, ойн сан бүхий газар 465,1 мянган га буюу 6,12 хувь, усан сан бүхий газар 43,1 мянган га буюу 0,57 хувь, тусгай хэрэгцээний газар 1,4 сая га буюу 18,95 хувь тус тус эзэлж байгаа бөгөөд, тайлангийн жилд ХАА-н газар 192,8 мянга га, хот, тосгон суурин газар 15,06 га газар хасагдаж, зам, шугам сүлжээний газар 1,2 мянган га, ойн сан бүхий газар 34,8 га, тусгай хэрэгцээний газар 191,5 мянган гагаар тус тус нэмэгдсэн байна.

Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах ажлыг үргэлжлүүлсэнээр өссөн дүнгээр нийт 8462 иргэнд 1,3 мянган га газрыг өмчилүүлж, 9810 иргэн төрийн байгууллага, аж ахуйн нэгж 15,1 мянган га газрыг эзэмшиж, 137 хуулийн этгээд 503,91 га газрыг ашиглаж байна. 2011 онд гэр бүлийн хэрэгцээнд үнэгүй өмчлүүлэх газрын төлөвлөгөөний биелэлт 82,9 хувийн биелэлттэй байна.

2011 онд газрын төлбөрөөр 73,4 сая төгрөг төвлөрүүлэхээс 60,3 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөө 82,2 хувийн биелэлттэй байна. Жаргалант сумын хэмжээнд газрын 166 зөрчилийн 80,7 хувь буюу 134 зөрчлийг арилгасан тухай тэмдэглээд 2012 оны газрын төлөвлөгөөнд тусгах саналыг хуралдаанд илтгэсэн байна.

Тус илтгэлийг аймгийн ИТХ-ын үйлдвэрлэл, дэд бүтэц, хот байгуулалтын хороо хэлэлцээд Жаргалант сумын хилийн цэцэгийг өргөтгөх, Буянт Ховд сумын Жаргалант сумын залгаа нутгуудад суурьшлын бүс бий болгох, газар олгох хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, газрын зөрчил бүхий газрыг цэгцлэх, мод зүлгийг хамгаалах, цөлжилтийг бууруулах, илтгэлийг дэмжиж хуралдаанаар хэлэлцүүлэх саналыг хуралдаанд оруулжээ.

Хуралдаан илтгэлийг хэлэлцээд “2012 оны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлах тухай” 9/07 дугаар тогтоолоор газар зохион байгуулалтын 2012 онд иргэн, аж ахуйн нэгжид үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлэх газрыг 72,856 га, хууль бус газар эзэмшилтийн талаар авах арга хэмжээний 1,1 га, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэх газрыг 211,77 га, иргэнд эзэмшиж байгаа хашааны газрыг нь үнэгүй өмчлүүлэх газар 153,60 га, өмчлүүлэх гэр бүлийн хэрэгцээнд болон аж ахуйн нэгж байгууллагын байгууллагад төмс, хүнсний ногоо таримал ургамал тариалахад эзэмшүүлэх газрыг 1348,20 га, нийтийн эдэлбэрийн газрын төлөвлөлт 0,05 га, сумын өвөлжөө, хаваржааны доорхи газрыг эзэмшүүлэх 20,3 га, бэлчээрийг сайжруулах арга хэмжээнд 242,54 га, иргэнд тариалангийн зориулалтаар давуу эрхээр эзэмшүүлэх 181,6 га, ААН, байгууллагад

тариалангийн зориулалтаар эзэмшүүлэх 550,0 га, усан сангийн газарт хэрэгжүүлэх 3,08 га, суурьшлын бүсэд шинээр үүсэх зам шугам сүлжээний доорхи газрыг 35 км, тухайн жил тусгай хамгаалалтанд авах 160362,0 га, газрыг элэгдэл, эвдрэл, доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх газар 186,7 га, газрын зөрчил маргааныг шийдвэрлэх газрыг нэрээр нь, эрчимжсэн мал аж ахуйн зориулалтаар эзэмшүүлэх газрыг 43,5 га, төсөвт байгууллагын зайлашгүй хэрэгцээнд зориулан эзэмшүүлэх газрыг 886,32 га хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 9 дүгээр хуралдаанд нийт 31 төлөөлөгчийн 25 буюу 83,8 хувь нь оролцож урилгаар 112 хүн оролцсоноос төсвийн байгууллагын ажилтан 89, иргэд 23 оролцож, 43 хүн үг хэлж, нийт 5 асуудал хэлэлцэн 7 тогтоол баталсан байна.

2008-2012 оны сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарын нэрс

дд	Нэр	Сумын нэр, нэр албан тушаал	Нэр	Сумын нэр, албан тушаал
1	Д.Баттөмөр	Алтай сумын ИТХ-ын дарга	Р.Бадамцэцэг	Алтай сумын Засаг дарга
2	Х.Балжинням	Булган сумын ИТХ-ын дарга	С.Баярсайхан	Булган сумын Засаг дарга
3	Н.Сүхээ	Буянт сумын ИТХ-ын дарга	М.Пүрэв	Буянт сумын Засаг дарга
4	Л.Даваа, Г.Эрдэнэчулуун	Дарви сумын ИТХ-ын дарга	Д.Түмэндэмбэрэл	Дарви сумын Засаг дарга
5	Ч.Буянбат	Дөргөн сумын ИТХ-ын дарга	Ш.Пүрэвхүү	Дөргөн сумын Засаг дарга
6	Х.Мөнхтуяа	Дуут сумын ИТХ-ын дарга	Б.Гантөмөр	Дуут сумын Засаг дарга
7	Б.Батбилэг	Зэрэг сумын ИТХ-ын дарга	Д.Октябрь	Зэрэг сумын Засаг дарга
8	Ц.Пүрэвдаш	Манхан сумын ИТХ-ын дарга	С.Гантөмөр	Манхан сумын Засаг дарга
9	Р.Даваадорж	Мөст сумын ИТХ-ын дарга	П.Баянзул	Мөст сумын Засаг дарга
10	Б.Мөнхдорлиг	Мөнххайрхан сумын ИТХ-ын дарга	С.Жимсээ	Мөнххайрхан сумын Засаг дарга
11	Б.Рагчаадорж	Мянгад сумын ИТХ-ын дарга	Н.Энхтуяа	Мянгад сумын Засаг дарга

12	Э.Уртнасан	Үенч сумын ИТХ-ын дарга	Ш.Даваа	Үенч сумын Засаг дарга
13	Ж.Мөнхзориг	Цэцэг сумын ИТХ-ын дарга	Д.Мөнхтөр	Цэцэг сумын Засаг дарга
14	Т.Пүрэвжав	Чандмань сумын ИТХ-ын дарга	Б.Догсом	Чандмань сумын Засаг дарга
15	Х.Тогторхан	Ховд сумын ИТХ-ын дарга	Д.Мурат	Ховд сумын Засаг дарга
16	А.Бадамдорж	Эрдэнэбүрэн сумын ИТХ-ын дарга	Д.Буянхишиг	Эрдэнэбүрэн сумын Засаг дарга
17	Б.Гантулга	Жаргалант сумын ИТХ-ын дарга	Х.Батболд, М.Мягмарцог	Жаргалант сумын Засаг дарга